



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН АСУУДЛААР БИЧИХ НЬ

Сэтгүүлчдэд зориулсан цуврал

Орчуулсан:

Б. Батбаяр
Г. Батбаяр

Хянан тохиолдуулсан:

Ц. Гомбосүрэн
Б. Мөнхсоёл



ГАРЧИГ

Дайдр Шийхан

ӨМЧ ХУВЬЧЛАЛ

3-13

Изабел Ортис

ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ НЬ

14-28

Абид Аслам

ДЭЛХИЙН БАНК

29-44

Грэхэм Ваттс

**СЭТГҮҮЛ ЗҮЙГ ӨӨРИЙН
БИЗНЕС БОЛГОХ**

45-55

Изабел Ортис

**СУУРЬ ОЙЛГОЛТ:
ХӨГЖЛИЙНТУСЛАМЖ**

56-69

Марк Скаузен

**АЛЬ НЬ ЭДИЙН ЗАСГИЙГ
ХӨТӨЛДӨГ ВЭ:**

70-77

хэрэглээний зарцуулалт уу,
эсвэл хөрөнгө оруулалт уу?

ӨМЧ ХУВЬЧЛАЛ

Дайдр Шийхан

Тэтчер, Рейган нар тус тусын улс орны удирдлагад сонгогдон гарч ирсэн 80-аад оны сүүл үеэс төрийн өмчийн үйлдвэрийн газрын хэлбэртэй бизнес эрхлэх тухай ойлголт өөрчлөгджээ. Улс гүрний засгийн газрууд ч хувийн хэвшилд давамгайлах байдал олгох, төрийн өмчийн аж ахуйн хэлбэрийг халах явдал түгээмэл болсон билээ. Засгийн газрууд тэрхүү зорилгынхоо үүднээс төрийн өмчийн компаниудыг худалдах буюу өмч хувьчлалыг явуулдаг.

Куба, Хойд Солонгос зэрэг цөөн улсыг эс тооцвол сүүлийн жилүүдэд бараг бүх улсад өмч хувьчлал ямар нэг хэмжээгээр өрнөжээ. Өмч хувьчлах нь эдийн засгийн өндөр өсөлтийг бий болгох, төсвөөс тэтгүүлдэг явдлыг арилгах, хүмүүст хямд үйлчилгээ үзүүлдэг илүү сайн компаниудыг төрүүлэх зэрэг олон давуу талыг бий болгодог.

Өмч хувьчлалыг үр ашгийг дээшлүүлэх зорилгоор явуулдаг учраас түүний үр дүнд ажлын байр ихээхэн хэмжээгээр хорогдож болзошгүй байдаг. Иймд ажилгүй болж байгаа тэдгээр ажилчдын нийгмийн баталгааг бий болгох нь төрийн чухал үүргүүдийн нэг юм.

Зарим тохиолдолд өмч хувьчлалын үр дүнд бий болгохоор төсөөлж байсан давуу талууд бүрэлдэхгүй ч байж болно. Ялангуяа хөгжиж байгаа улс орнуудын хувьд зах зээлийн өрсөлдөөнийг бий болгоход шаардлагатай эрх зүйн болоод зохицуулалтын орчин тодорхойгүйн улмаас бүтэлгүйтэх нь бий. Тухайлбал, Орос улсад явагдсан өмч хувьчлалын үр дүнд муу ажиллаж байсан төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд нь мөн л сайнгүй ажилладаг хувийн хэвшлийн компаниуд болж хувирчээ. Хувийн хэвшлийн компаниуд шинээр бий болсон

хэдий ч тэдгээрийн үр ашиг нэмэгдээгүй, хүмүүст хүрэх үйлчилгээний чанар дээрдээгүй, бараа бүтээгдэхүүний үнэ ч буураагүй төдийгүй шинээр ажлын байр бий болгох зорилтууд ч хэрэгжээгүй аж.

ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН ҮЙЛ ЯВЦ:

Юуг худалдаж болох вэ?

Засгийн газар нь аливаа пүүс дэх өөрийн эзэмшлээсээ бүрэн татгалзаж пүүсийг 100 хувь хувьчилж болно. Мөн тухайн засгийн газар пүүст өөрийн сонирхлын тодорхой хэсгийг хадгалан үлдэж болно. Гэхдээ засгийн газар пүүс дэх өөрийн сонирхлын 51 буюу түүнээс дээш хувийг худалдсан тохиолдолд л өмч хувьчлал явагдсан гэж үзэх ёстой. Улс орны стратегийн ач холбогдол бүхий сонирхолд зохих эрх мэдэлтэй байгаа гэдгээ олон нийтэд харуулахын тулд засгийн газар аж ахуйн нэгж дэх өөрийн өмчлөлийн тодорхой хэсгийг хадгалан үлдэж болно.

Хувьчлалыг яаж явуулдаг вэ?

1. **Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг:** Хувьчлалыг хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн аргаар явуулахдаа тухайн улсын иргэдэд хувьчлагдах компанийн хувьцаанд хөрвөх эрхтэй эрхийн бичгийг тараадаг. Энэхүү аргыг төв болон зүүн европын улс орнуудад өргөнөөр ашигласан боловч тэр бүр амжилттай болж чадаагүй юм.

Давуу талууд:

Мэдээллээр харьцангуй хомс хүн амд компаниудын хувьцааг хуваарилах нь улс төрийн бодлогын үүднээс оновчтой шийдэл болох магадлалтай. Зөвхөн цөөн тооны мөнгөтэй хүмүүст зориулагдах бус, хүн амыг бүхэлд нь хамарч чаддаг учир өмч хувьчлалын энэ аргыг шударга арга гэж үзэж болно. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчлалыг явуулах нь нийгмийн гишүүдийг хувьцаа эзэмшигчид болгон хувиргаснаар шинэхэн үүсч буй хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх боломж олгодоггоороо сайн аргад тооцогддог.

Сул талууд:

Хувьчлалыг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр явуулснаар төрд орлого ордоггүй. Бас компани нь мянга мянган хувь хүмүүсийн эзэмшилд очдог учир түүнийг үр ашигтай ажиллуулж чадах, өөрчлөлт хийхийг шаардах хөрөнгө оруулагчид тэр бүр олддоггүй. Иймд компанийг хуучин менежерүүд нь урьдын адил удирдсан хэвээр байх эрсдэлтэй.

- Чех улсад 1992-1995 оны хооронд хөрөнгө оруулалтын эрхийн бичиг ашиглан өргөн хүрээтэй өмч хувьчлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад нэгэн бэрхшээл ажиглагджээ. Юу гэвэл, хөрөнгө оруулалтын сангууд маш олон тооны хөрөнгө оруулалтын эрхийн бичгийг худалдан авсан байна. Дотоодын, төрийн өмчийн том банкууд нь тэдгээр хөрөнгө оруулалтын сангуудыг өмчилдөг байжээ. Гэтэл банкууд нь хувьчлагдсан компаниудаас авлагатай байх явдал олонтаа тохиолдсон байна. Эцсийн дүндээ банкууд нь компаниудын жинхэнэ өмчлөгчид болон хувирч, хөрөнгө оруулалтын сангууд нь муу ажиллаж байгаа компаниудаас хувьцаагаа бусдад шилжүүлэх замаар гарч чадахгүй байдалд хүрчээ. Гэхдээ энэ бэрхшээлийг зөвхөн хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр явуулах хувьчлалаас үүдэлтэй гэж үзэж болохгүй. Банкууд аж ахуйн нэгжүүдийг өөр бусад олон аргаар худалдан авах боломжтой байдаг.
- 2. **Шууд худалдах арга:** Засгийн газар томоохон хөрөнгө оруулагч нарт компанийг шууд худалдаж болно. Худалдан авах стратегийн найдвартай хөрөнгө оруулагч нар нь гол төлөв хувийн хэвшлийн нэг буюу хэд хэдэн компанийн консорциум байдаг. Нээлттэй дуудлага худалдаанд оролцож компанийг худалдан авахаар хамгийн өндөр үнэ санал болгосон хөрөнгө оруулагч буюу засгийн газрын зохион байгуулсан тусгай уралдаант шалгаруултад (тендер) тэнцсэн хөрөнгө оруулагч ялагчаар тодордог. Энэ аргыг 1996 онд Kenya Airways компанийг хувьчлахад ашигласан байна. Засгийн газар тус компанийн 77% -ийн хувьцааг хэд хэдэн удаагийн дуудлага худалдаагаар худалджээ. KLM Royal Dutch Airlines уг тээврийн компанийн 26 % -ийг, харин дотоодын хөрөнгө оруулагч компанийн хувьцааны үлдсэн хувийг худалдан авчээ.

Давуу талууд:

Уралдаан шалгаруулалтын аргаар хувьчлалыг явуулах нь төрд орох орлого илүү байх нөхцлийг бүрдүүлдэг. Энэ аргаар явуулсан хувьчлалын үр дүнд зөвхөн хөрөнгө оруулалт хийгдээд зогсохгүй техникийн болон удирдлагын дадлага туршилагатай стратегийн хөрөнгө оруулагч нар тухайн улсад орж ирдэг. Шууд худалдах арга нь компанийг хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлахаас маркетингийн болон бусад зардлын хувьд хямд байдаг.

Сул талууд:

Энэ аргаар хувьчлахад хувьцаа шинээр гаргах, худалдах ямарваа нэг ажиллагаа явагддаггүй учир хөрөнгийн зах зээл хөгжихөд хувь нэмэр оруулдаггүй.

- 3. Хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан худалдах замаар хувьчлал явуулах:** Хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан худалдах замаар хувьчлал явуулах (орч: IPO- Initial Public Offering) арга бий.

Давуу талууд:

Энэ аргаар хувьчлалыг явуулах нь хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг. Хувьчлалыг ийнхүү явуулах нь хэн, юуг, ямар үнээр худалдаж авсан нь олон нийтэд нээлттэй байх нөхцлийг хангана. Мөн энэ аргаар хувьчлал явуулах нь санал болгож буй бүх хувьцааг улс төрийн нөлөө бүхий нэг хүчин худалдан авахаас сэргийлдэг. Эдгээр шалтгааны улмаас ч ийм аргын хувьчлал гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах нь илүү байдаг.

- 4. Хослуулах арга:** Энэ нь стратегийн хөрөнгө оруулагч нарт хувьчлах аж ахуйн нэгжийн тодорхой хувийг шууд худалдах, улмаар (гол төлөв 12 сарын дараа) хувьцааг нийтэд санал болгож хөрөнгийн биржээр дамжуулан худалдах аргуудыг хослуулдаг хэлбэр юм. 1991 онд явагдсан Telmex-ийн хувьчлалыг компанийн 20%-ийг стратегийн хөрөнгө оруулагч нарт худалдаад мөн компанийн 31%-ийг нь 1991, 1992 онуудад хувьцаа шинээр гаргаж хөрөнгийн биржээр арилжсан байна.

Давуу талууд:

Компанийн хувьцааг шууд болон нийтэд санал болгож хөрөнгийн биржээр дамжуулан худалдах нь томоохон хөрөнгө оруулагчдад компанийг үр ашигтай ажиллуулах нөхцлийг олгодог. Энэ аргаар хувьчилснаар компанийн үнэ өсөх бөгөөд засгийн газар, хувьцаа эзэмшигчдийн аль алинд нь ашигтай юм. Мөн энэ аргыг хэрэглэх нь хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Сул талууд:

Компанийн хувьцаа болон ногдол хувийг хэд хэдэн үе шат, өөр өөр аргаар худалдахад их зардал гардаг. Хөрөнгө оруулалтын банкуудыг хувьцаа худалдах ажиллагаанд оролцуулснаас үүсдэг үйлчилгээний төлбөр зэрэг нь үүнд нөлөөлдөг байна. Ийм учраас энэ арга нь ихэвчлэн хөрөнгө оруулагчдын сонирхлыг татсан томоохон компаниудын хувьд хэрэглэгддэг байна.

- 5. Концесс:** Ус, эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбарын зүй ёсны монополь компаниудыг төр хувьчлахгүй байхаар шийдэж болно. Тэгэхдээ төр компанийг удирдах эрхийг тодорхой хугацаагаар бусдад худалддаг. Энэхүү арга нь хөрөнгө оруулагч нарт орлого олох боломж олгохын хамт хэрэглэгчдийг үнийн хэт өсөлтөөс хамгаалдаг давуу талтай юм. Уг аргыг улс орны үнэ цэнэтэй аж ахуйн нэгжүүдээ хамгаалах нэг хэлбэр гэж хэлж болно. Жишээ нь, 1997 онд Габон улс Societe d’Energie et d’Eau du Gabon (SEEG) гэдэг ус, цахилгаан эрчим хүчний компаниа хувьчлахад энэ аргыг хэрэглэжээ. Хувьчлан авах сонирхол бүхий талууд засгийн газартай байгуулах концессийн гэрээний нэг этгээдээр шалгарсан тохиолдолд ус, цахилгаан эрчим хүчний үнийг үлэмж хэмжээгээр бууруулах санал тавьж байв. Electricity Board of Ireland-тай баг болон оролцсон France’s Vivend компани эрчим хүчний үнийг 17.25 %-иар бууруулан наад зах нь 200 сая долларын хөрөнгө оруулалт хийх санал тавьснаар энэхүү шалгаруулалтад ялалт байгуулжээ. Үүний дараа Gabon-ы хувьцааг хөрөнгийн биржээр амжилттай борлуулсан байна.

Хувьчлалын үр дүнд?

Хувьчлалын үр дүнд компанийн өрсөлдөх чадвар сайжирч, илүү үр ашигтай ажилладаг болох ёстой. Компани үр ашигтай ажиллахын хэрээр ажлын байр шинээр бий болох нөхцөл бүрдэхээс гадна иргэдэд илүү чанартай, хямд үнэтэй бараа, үйлчилгээ үзүүлдэг болох ёстой. Өмч хувьчлалын үр дүнд урьд нь үр ашиггүй ажиллаж байсан компаниудыг тэтгэж байсан хөрөнгийг хэмнэх нөхцөл бүрдсэн ч түүнийг эрүүл мэнд, боловсрол, зам барих зэрэг ажилд зарцуулах боломж гарна.

Ийм үр дүнд гарах эсэхийг урьдчилан хэлэхийн тулд дараахь гурван асуултыг тавих хэрэгтэй болно. Үүнд:

- Компанийг хэн худалдан авсан бэ?
- Тэд компанийг сайн ажиллуулахын тулд ямар ажил хийж байна вэ?
- Компани сайн ажиллахад шаардагдах эдийн засгийн тааламжтай орчинг засгийн газар бүрдүүлж чадаж байна уу?

“Төр өмч хувьчлалын бэлтгэлийг хангах талаар юу хийсэн бэ?” гэдэг асуултыг өмч хувьчлал явагдахаас бүр өмнө та тавьж байвал зохилтой.

АНХААРАХ ЗҮЙЛС:

- Их хэмжээний өр төлбөр. Их хэмжээний өрийн дарамтад байгаа төрийн өмчийн компанийг хөрөнгө оруулагч нар тэр бүр сонирхдоггүй. Төр тийм компанийг хувьчлахын тулд гол төлөв түүний өрийг өөрөө барагдуулдаг. Мөн байж болохоор нэгэн шийдэл бол маш хямд үнээр компанийг өрийн хамт худалдах явдал юм. (Филиппин улсын эрчим хүчний Наро-сог компанийн хувьчлал үүний жишээ юм).
- Өрсөлдөөнийг дэмжих бодлого. Хэрэв өрсөлдөөний зохистой орчин байхгүй бол төрийн мэдлийн цахилгаан холбооны монополь компанийг хувийн хөрөнгө оруулагч нарын эзэмшилд шилжүүлсэн ч үнэ буурах боломжгүй юм. Төрийн зүгээс цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэх сонирхолтой бусад компаниудад лиценз олгосон уу? Монополь компани бусад өрсөлдөгч нартаа компанийхаа дэд бүтцийг (орч: холбооны шугам сүлжээг) нь боломжийн үнээр ашиглуулж байгаа эсэхийг хянах хөндлөнгийн байгууллага бий юу? Орон нутгийн хэрэглэгчдийн төлж буй үйлчилгээний төлбөр ямар түвшинд байна вэ? Хөрөнгө оруулагч нь үнэ тогтооходоо нэг талаас зохих хэмжээний орлого олохоо, нөгөө талаас аль

болох олон тооны хэрэглэгчтэй байхаа харгалзан үздэг байх ёстой.

- Өмчлөх эрх. Өмчлөх эрхийг эрх зүйн тогтолцоогоор баталгаажуулсан тогтолцоо бүрдсэн байх шаардлагатай. Газрын буюу бусад өмчийн эрхийн маргаантай асуудал бүхий компанийг хөрөнгө оруулагчид сонирхохгүй. Компанийг худалдахаас өмнө үүссэн ямар нэг маргаан бий юу? Компанийг хувьчилсны дараа аливаа гэрээ хэлцлийн биелэлтийг хангаж чадахуйц шүүхийн тогтолцоо тус улсад бүрдэж чадсан уу?
- Санхүү, эдийн засгийн таатай бус орчин. Компанийг хувьчилсны дараах үед зээлийн хүүгийн хэмжээ хэр өндөр байх вэ? Мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх хөрөнгийн болон өрийн бичгийн зах зээл тухайн улсад бий юу? Банкны систем тогтвортой юу, эсвэл банкууд нь их хэмжээний өр төлбөртэй юу? Өмч хувьчлалын үр дүн нь макро-эдийн засгийн орчин, тэр дундаа банкны секторын эрүүл байдал зэргээс шалтгаална. Мөн шинэ хөрөнгө оруулагчаас компанийг санхүүжүүлэх төлөвлөгөө нь хэр найдвартай, хэр сайн боловсруулагдсаныг анхаарах шаардлагатай. Шинэ хөрөнгө оруулагч нь ойрын төлөвлөгөөндөө компанийг өөрчлөн зохион байгуулах ажлыг, дунд хугацааны төлөвлөгөөндөө компанийг өргөжүүлэх ажлыг тусгасан байж болно. Санхүүгийн эх үүсвэргүй бол эдгээр зорилтын алиныг ч хэрэгжүүлэх боломжгүй болно.

Төр энэхүү шилжилтийн явцыг саадгүй бөгөөд үр ашигтай болгохын тулд юу хийсэн бэ гэсэн асуултыг өмч хувьчлалын дараа та өөртөө тавих хэрэгтэй:

АНХААРАХ ЗҮЙЛС:

- Цомхтгол. Компанийг хувьчлахын өмнө, түүнийг хувьчилсны дараа ажиллагсдыг их хэмжээгээр цомхтгох шаардлага гарч болно. Хөрөнгө оруулагч хэт олон ажиллагсадтай компанийг сонирхохгүй байж (төрийн өмчийн олонх компани тийм байдаг) болох учир түүнийг хувьчлахын өмнө ажиллагсдын тоог ихээхэн хэмжээгээр хорогдуулж болно. Ер нь төр ихэвчлэн үр ашиггүй ажиллаж байгаа компаниудыг хувьчилдаг. Ихэнх тохиолдолд шинэ хөрөнгө оруулагч тухайн компанид хэт олон тооны туслах болон захиргааны ажиллагсад байгааг олж тогтоодог. “Цагаан захтай” олон тооны ажиллагсдыг халах нь компанийн хувьд ашигтай байж болох боловч улс орны эдийн засаг, улс төрийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болно. Иймд “төр компанийн ажиллагсдыг ийнхүү олноор халах явдлаас сэрэмжлэхийн

тулд ямар арга хэмжээ авсан бэ; Төр нь компанийг шинэ өмчлөгчдөд шилжүүлэхдээ шинэ өмчлөгчийн тавьж байгаа ажиллагсдын цомхтголын төлөвлөгөөг тооцож үзсэн үү” г.м. асуулт зүй ёсоор тавигдана. Зарим улс (тухайлбал, Бенин, Замбия зэрэг) компанийг хувьчлах гэрээндээ шинэ өмчлөгч ажиллагсдыг 5 жилийн хугацаанд цомхтохгүй байх тухай заалт оруулдаг. Мөн зарим улс (тухайлбал, Пакистан, Мадагаскар зэрэг) компанийн шинэ өмчлөгч цомхтгол хийхээр болвол тэдгээр ажиллагсад төлбөл зохих төлбөрийн хэмжээг урьдчилан тохирдог. Цомхтголд өртөгсдөд олгох тэрхүү төлбөр нь ажиллагсадын хэдэн сар, заримдаа бүтэн жилийн цалинтай тэнцэхүйц хэмжээтэй байдаг бөгөөд тэр нь чөлөөлөгдсөн ажиллагсад шинэ ажилд орох хүртэл багагүй дэмжлэг болдог. Мөн энэхүү төлбөр нь зарим хүнд шинээр бизнес эхлэх хөрөнгийн анхны эх үүсвэр болж болно.

- Чадварлаг боловсон хүчний дутагдал. Төрийн өмчийн компанид хэт олон тооны захиргааны албан хаагчид, цөөн тооны чадварлаг үйлчилгээний ажиллагсад ажилладаг байж болно. Хүрэлцэхүйц тооны, чадварлаг ажиллах хүч бэлтгэх үүднээс төр боловсрол, сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсэн үү? Шинэ өмчлөгч тусгай сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсэн үү? Шинээр ажиллагсад авсан уу?
- Ажиллагсдын нийгмийн асуудал. Төрийн өмчийн олон компани ажиллагсаддаа орон сууц, боловсрол, эрүүл мэнд болон хүүхэд асрахад зориулсан зэрэг янз бүрийн тэтгэлэг олгодог. Төр хувьчлалын дараа эдгээр тэтгэлгээ алдах ажиллагсдын ашиг сонирхлыг харгалзан дээрх нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж чадсан уу? Уг асуудал хуучин Зөвлөлт холбоот улсад нэн хурцаар тавигдсан бөгөөд зөвхөн өмч хувьчлалтай холбогдоод зогсохгүй төвлөрлийг сааруулах процесс, нутгийн өөрөө удирдах байгууллагуудын бүтцийг хамарсан томоохон бэрхшээл болон хувирчээ. Иймд санхүүгийн эх үүсвэр бий болгох асуудлыг туйлын нягт нямбай тооцож үзэх нь чухал.
- Татвар хураалтын дутагдалтай байдал, төсвийн томоохон алдагдал. Өмч хувьчилж компанийг худалдсаны дараа засгийн газрын төсөвт ихээхэн хэмжээний бэлэн мөнгө орж ирдэг. Гэхдээ энэ нь ганц удаагийн явдал бөгөөд урьд нь компаниас төсөвт оруулж байсан тогтмол орлого тасалдахад хүрнэ. Ийм байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд зах зээлийн шаардлагад нийцсэн татвар хураалтын системийг бий болгох шаардлагатай.

- Төрийн оролцоо. Төр нь компанийг хувьчилсны дараа түүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох ёсгүй. Үнийг хянаж өрсөлдөөнийг хангаж ажилладаг Бие даасан хараат бус зохицуулах зөвлөлүүд байх ёстой. (Украины эрчим хүчний салбарын хувьчлалын туршлагыг үз).

ШИНЭ ӨМЧЛӨГЧИД:

Өмч хувьчлалын явцад зөвхөн засгийн газар хэрхэн ажиллаж байгааг анхаарч байх өрөөсгөл талтай. Хувьчлагдсан компани хэр ажиллаж байгаагийн бүх хариуцлагыг шинэ өмчлөгчид биечлэн хариуцах ёстой байдаг. Иймд шинэ өмчлөгч нар компанийг эдийн засгийн эрүүл бүрэлдэхүүн хэсэг болгож ажлын байрыг бий болгож чадах уу гэсэн асуулт гарч ирнэ. Шинэ өмчлөгчид нь гол төлөв дараах этгээд байдаг.

Гадаадынхан. Гадаадын хөрөнгө оруулагчид компанийг худалдан авахдаа гадаад валютаар төлбөрийг хийдэг. Энэ нь ч засгийн газарт ашигтай бөгөөд өөрийн гадаад өр төлбөрийг барагдуулах санхүүгийн эх үүсвэртэй болно. Гадаадын хөрөнгө оруулагчид мөн туршлага, дэвшилтэт технологийг тухайн улсад авч ирдэг нь бас нэг давуу тал юм. Ядуу улс орнуудад компанийг худалдан авахад хүрэлцэхүйц мөнгөн хөрөнгөтэй дотоодын хөрөнгө оруулагчид тэр бүр байхгүй байж болно. Харин гадаадын хөрөнгө оруулагч нь олсон орлогоороо компанийхаа үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дахин хөрөнгө оруулалт хийх чадвартай байдаг.

АНХААРАХ ЗҮЙЛС:

Гадаадын хөрөнгө оруулагч нь компаниас олсон орлогоо компанидаа буцааж хөрөнгө оруулалт хийхгүйгээр тухайн улсаас авч явж болно. Ийм байдал үүсвэл өмч хувьчлалыг бүхэлд нь эсэргүүцэх улс төрийн уур амьсгал бүрэлдэх аюултай.

- **Компанийн дотоодын менежерүүд.** Эдгээр хүмүүс нь гол төлөв компанийн удирдах албан тушаалтнууд буюу ажиллагсад байдаг. Нэг талаас эдгээр хүмүүсийг компанийг удирдах арвин туршлагатай, компанийг үр ашигтай ажилладаг болгох зорилготой хүмүүс гэж үзэж болох юм. Нөгөө талаас, компанийг түүнийг удирдаж буй хүмүүст нь шилжүүлэн өгвөл олон бэрхшээлийн үүднээс нээх идэвхгүй арга барилыг өөгшүүлэх уршигтай.

АНХААРАХ ЗҮЙЛС:

Компанийн хуучин удирдлагын эрх бүхий хүмүүс нь компанийг удирдах аргыг өөрчлөх сонирхолгүй, төрийн зүгээс дэмжлэг, хөнгөлөлт горьдсон хүмүүс ч тохиолдож болно.

- **Хөндлөнгийн менежерүүд.** Эдгээр хүмүүс нь дотоодын ажил хэрэгч хүмүүс буюу бизнесийн хүрээнийхэн байж болно. Тэд дотоодын зах зээлийн тухай сайн ойлголттой, компанийг өргөжүүлэхэд шаардагдах санхүүгийн болон техникийн боломжтой, бизнесийн үйл ажиллагааны хуримтлжлсан туршлагатай байж болно. АНХААРАХ НЬ: компанийг аливаа өрсөлдөөнөөс гадуур байлгах үүднээс төрд нөлөөлж чадах улс төрийн хувьд нөлөө бүхий менежерүүд байж болно.

Шинэ өмчлөгчид юу хийх ёстой вэ?

АНХААРАХ ЗҮЙЛС:

- Ажиллагсад ажиллах урам өгөх, тэдэнд зориулсан сургалт явуулах. Эхэн үедээ шинэ өмчлөгчид нь тэнд ажиллаж байсан менежерүүдийг ажиллуулах боломжтой. Гэхдээ тэдгээр нь шинэ дадлага туршлага олж авч цаашид хөгжих авьяастай хүмүүс мөн эсэхийг анхаарах ёстой. Шинэ өмчлөгчид нь компанийн урт хугацааны зорилтыг хангаж үр ашгийг нь дээшлүүлэхийн тулд ажиллагсаддаа зориулсан сургалт явуулж, үргэлжлүүлэн ажиллах сонирхлыг нь төрүүлэх хэрэгтэй.
- **Стратеги.** Зөвхөн улс төрийн аль нэг сонирхлыг хангах үүднээс компанийн үйлдвэрлэж байсан бараа бүтээгдэхүүн, үзүүлж байсан үйлчилгээг илрүүлж түүнийг таслан зогсоож чадаж байна уу? Компанийн харьцангуй давуу талтай үйл ажиллагааг нь шинэ өмчлөгчид зохих ёсоор анхаарч цаашид өргөжүүлж чадаж байна уу? Шинэ өмчлөгчид нь техник технологи, хүний нөөцөө байнга сэлбэж чадаж байна уу? Компани нь үйл ажиллагааныхаа эхэн үед мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж чадахгүй байвал шинэ өмчлөгчид бэлэн мөнгөний эргэлтийг хэрхэн бий болгох төлөвлөгөөтэй байна вэ? Компани нь бонд гаргах буюу банкнаас зээл авах боломжтой юу? Шинэ өмчлөгч нь компанид оруулах бэлэн мөнгөтэй юу?
- **Мэдээлэх үүрэг.** Хувьчлагдсан компани нээлттэй эсэх – олон нийтийн зүгээс компанийн санхүүгийн байдлын талаар мэдээлэл авах боломж бий юу? Хэрэв компани хөрөнгийн биржид бүртгэлтэй бол тайлангаа Үнэт цаасны байгууллага болон олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн гаргаж байгаа юу? Компани монополь үйл ажиллагаатай бол төрийн болон хөндлөнгийн хяналтын

байгууллагад үйл ажиллагаагаа тайлагнаж байгаа юу? Компани менежерүүд болон нягтлан бодогч нартаа зориулан сургалт явуулдаг уу?

- **Орлого, үр ашиг.** Компани зөвхөн олсон ашгийнхаа төдийгүй үйл ажиллагааныхаа ашигт байдлын талаар мэдээлдэг байх ёстой. Нийт хөрөнгийн хэмжээнд харьцуулсан орлого, борлуулалтын орлого, өөрийн хөрөнгө болон орлогын харьцаа зэргийн тухай мэдээллийг авах нь чухал. Мөн компанийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн харьцаа, эдгээр харьцуулсан үзүүлэлт нь компани хувьчлагдсаны дараах нэг жилийн хугацаанд сайжирсан эсвэл доройтсоныг ажиглах нь чухал.

ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ НЬ

Изабел Ортис

ЯДУУРЛЫН ЧИГ ХАНДЛАГА, ТҮҮНИЙ ХЭМЖҮҮРҮҮД

2.8 тэрбум хүн буюу ойролцоогоор дэлхийн нийт хүн амын хагас нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ядуурлын шалгуур үзүүлэлт болох өдрийн 2 ам. долларын хэрэглээнээс доогуур түвшинд амьдарч байна. Үүнээс 1.2 тэрбум нь өдрийн 1 ам. долларын орлоготой буюу нэн ядуу гэсэн ангилалд багтаж байна. Эдгээр ядуусын дийлэнхи нь Ази, Африк тивд амьдарч байгаа аж. Эрэгтэйчүүдтэй харьцуулбал эмэгтэйчүүдийн дунд ядуурал илүү түгээмэл, хот суурин газрыг бодвол хөдөө, тосгодоод ядуурлын түвшин илүү өндөр байдаг ажээ. Өвгөд хөгшид, үндэсний цөөнх, дүрвэгсэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг эмзэг бүлгийнхэн ядууралд илүү өртөмтгий байдаг байна. 1987 оноос хойш ядуурлын хэмжээ нийтдээ буурсан бөгөөд хөгжиж буй орнуудын хүн амын ядуурлын түвшин нь 28%-аас 24% болжээ. Гэхдээ туйлын утгаараа ядуурал буураагүй. Хөгжиж буй улс орнуудын хувьд хүн амын өсөлтийн түвшин нь өндөр хэвээрээ байгаа бөгөөд хүүхдүүд нь ядуу орчинд төрөх явдал элбэг байна. Дэлхийн Банкны мэдээ баримтыг иш үндэс болговол, ядуурлын түвшин 1980-аад оны сүүлээс хойш утгаа бол нэмэгдсэн дүн гарчээ.

Ядуурлыг хэрхэн тодорхойлох, ямар хэмжүүрээр үнэлэх нь улс төрийн агуулгатай асуудал юм. Ядуурал нь улс орны хөгжлийн түвшин дорой байгааг, нийт хүн амд чиглэсэн бодлогын үр дүн муу байгааг илтгэн харуулдаг учир засгийн газрууд ядуурлын бодит байдлыг нуух хандлагатай байдаг. Иймээс улс орон бүр ядуурлыг тодорхойлохдоо хооронд нь харьцуулах боломжгүй ялгаатай аргуудыг хэрэглэдэг байна. Түгээмэл хэрэглэдэг аргын нэг бол 2000-2500 калор хүнсийг хэрэглэхэд шаардагдах мөнгөн үнэлгээ, мөн түүнчлэн бусад хүнсний бус хэрэгцээг хангахад зориулагдах мөнгөн үнэлгээг

үндэслэх арга юм. Гэсэн хэдий ч эдгээр хэмжүүрүүд нь хувцас, ундны ус, орон байр, эрүүл мэнд, боловсролын зэрэг наад захын хэрэгцээг бодитойгоор тусгаж чаддаггүй. Иймэрхүү шалтгааны улмаас Нэгдсэн Үндэстний Байгууллага нэг, хоёр долларын гэсэн ядуурлын шалгуур үзүүлэлтийг ашиглаж эхэлжээ. Энэ арга ч бас өөрийн сул талуудтай юм. Учир нь нэг доллараар нэг улсад худалдаж авч болох бүтээгдэхүүний тоо хэмжээ нөгөө улсад худалдаж авч болох бүтээгдэхүүний тоо хэмжээнээс ялгаатай байх нь ойлгомжтой. Хэрэглээний сагсны хамгийн бага хэмжээгээр тооцож үзвэл ядуу хүмүүсийн тоо үлэмж их хэмжээгээр нэмэгдэх болно.

Олон хүмүүс ядуурлыг зөвхөн орлоготой холбоотой гэж үздэггүй байна. Ядуурал нь ялгаварлан гадуурхах, боолчлох, нөөцөд тавих хяналт муу байх, аливаа эрсдэлд өртөмтгий байх, хүчирхийлэл, авилгад автамтгай байх, шийдвэр гаргахад оролцоо хомс байх, хүчин мөхөсдөх, үгүйсгэгдэх зэрэг эдийн засгийн бус олон хэмжүүртэй. Ядуурлын тодорхойлолтын хүрээг өргөжүүлэхийн хэрээр ядуу хүмүүсийн тоо өссөн дүнтэй гардаг.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд ядуурлын тухай буруу ойлголттой байх нь түгээмэл байдаг. Ядуурлыг тэгш бус байдлын тухай ойлголтоос салгаж авч үзэх нь чухал. Ядуурал нь тодорхой орлого/хэрэглээний түвшнээс доогуур амьдарч байгаа хүмүүсийн тоог илэрхийлдэг. Харин тэгш бус байдал нь нийт бүлгийн хүрээнд орлогын хуваарилалт ямар байгааг илтгэн харуулдаг ойлголт юм. Жишээлбэл, дэлхий дээр нийт 2.8 тэрбум хүн ядуу /ядуурлын тухай ойлголт энд гарч ирнэ/ байдаг бол дэлхийн хамгийн баян хүмүүс болох 20 хувь нь дэлхийн нийт орлогын 89%-ийг хүртэж, харин хамгийн ядуу 20 хувь нь тэрхүү орлогын дөнгөж 1.2%-ийг хүртэж байна /орлого хуваарилалтын ойлголт/. Баячууд, ядуучуудыг хооронд нь харьцуулахад орчин үеийн хөгжлийн загварууд хэнд үйлчилж байгаа, тэдгээрийн зохистой эсэх тухай асуудлууд гарч ирэх бөгөөд шударга бус байдлын мэдрэмж, улс төрийн амлалтуудыг бий болгох шалтгаан болдог. Тийм ч учраас тэгш бус байдлын тухай үндэсний судалгаанууд ядуурлын тухай судалгааны дүнгээс бодитой бус байдаг. НҮБ-ын байгууллагууд орлого хуваарилалтын тоо баримтыг илүү сайн хянах талаар судалгаа хийж байна. Өнөөдрийн байдлаар ХХ зууны сүүлийн хагаст тэгш бус байдал даамжирсан гэсэн дүгнэлт гараад байгаа.

ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ТУХАЙ ОЙЛГОЛТЫГ ТҮҮХЭН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ

Ядуурал бол шинэхэн ойлголт биш юм. XIX-р зууны үеийн Европ тивийг дүрслэсэн бичиг сэлтэд өнөөдрийн хөгжиж буй орнуудынхтай адиламыдрал, ажлын нөхцлийн тухай нэлээд их дурдсан байдаг. Чарльз Диккенсийн азгүй хүүхдүүдийн тухай зохиолууд өнөөгийн Африк, Ази, Латин Америкийн ажил хийж буй хүүхдүүдийн амьдралтай төстэй мэт. Фридрих Энгельсийн бичсэн зүйлд гардаг Манчестерийн гол дээрх аж үйлдвэрийн төв өнөөдрийн Манила дахь Смоуки уул, Рио де Жанейро дахь Нова Игуазу-г санагдуулахаар. Хөгжингүй орнуудад болж өнгөрсөн иргэдийн эрх болон хамгааллын төлөөх эрчимтэй хөгжил нь хөгжиж буй орнуудад мөн гарч болно.

1930-аад оны АНУ-тай холбоотой нэгэн жишээ татъя. 1929 оны Их хямралын дараа ядуурал газар авч, хүмүүс хөдөлмөрөөсөө өөр худалдах юмгүй шахам болон нүүж, гэмт хэрэг өсч, иргэд эрх мэдэлгүй болсон нь өнөөдрийн хөгжиж буй орнуудад байгаа дүр зурагтай ижил байна. Олон жилийн зовлон бэрхшээл, ажилгүйдэл, хямралын эцэст ерөнхийлөгч Рузвельтын засаг захиргаа Шинэ Гэрээ-г хэрэгжүүлэн эдийн засгийг идэвхижүүлэн, ажлын байр бий болгож, гэмт хэрэгтэй тэмцэж, ядуучуудын нийгмийн аюулгүй байдлыг хангаж чаджээ. Ингэсний үрээр АНУ хөгжил цэцэглэлтийн шат руу шилжсэн юм.

Дэлхийн II-р дайны төгсгөлд Өрнөдийн дэвшилтэт эдийн засагтай орнуудын эдийн засагчид улс төрийн хямрал үүсгэхээс гадна, коммунизм, фашизмыг хөгжихэд нэмэр болсон ажилгүйдэл болон эдийн засгийн хямралыг дахин хэзээ ч гаргахгүй байхаар санаа шулууджээ. Ажил эрхлэлт ба макро эдийн засгийн тогтвортой байдал / бага инфляцитайгаар тасралтгүй өсөлт явагдахыг хэлж байна/ нь аливаа үндэстний бодлогодоо баримтлах гол зорилго болох ёстой гэдгийг тэд хүлээн зөвшөөрчээ. Засгийн газрууд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн болон орон байрын тусламж, тэтгэврийн насны хязгаар, ажилгүйдлийн даатгал, ажил эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн хууль, зохицуулалтуудыг хэрэгжүүлэх зэрэг асуудлуудад оролцох болсон байгаа. Энэ нь бас үр дүнгээ өгч дайны дараах бодлого үйлдвэрлэлийн үр ашгийг нэмж, дотоодын эрэлтийг өргөжүүлж, эдийн засаг бүхэлдээ өсчээ. Европ, Япон, Хойд Америк, Австрали, Шинэ Зеландын хүн ам түүхэнд үзэгдээгүй хурдацтайгаар хөгжсөн байна.

Дээрхээс үүдэх сургамж гэвэл засгийн газрын дэмжлэгтэйгээр уялдаа сайтай бодлого явуулахад түргэн амжилтанд хүрч болох явдал юм. Гэтэл хөгжиж буй орнуудын засгийн газрын хувьд ядуурлыг бууруулах гэдэг нь хөгжлийн олон зорилтуудын нэг л асуудал нь байдаг. Хөгжиж буй орнуудын ихэнх нь хөрөнгийн хомсдолтой, гадаад өрийн дарамттай, бүтээгдэхүүнээ хөгжингүй орнуудын зах зээлд экспортлох гарц муутай байдаг. Санхүүгийн асуудал хүнд байдгаас нийгмийн халамжийн асуудал энэ тэргүүнд тавигддаггүй, хангалтгүй түвшинд байдаг. Олон тохиолдолд эдгээр бэрхшээлтэй асуудлуудын шийдэл нь засгийн газрын олон нийтэд чиглэсэн бодлогоос шударга бусаар ашиг олдог ашиг сонирхлын бүлгүүдийн гарт байдаг. Гэтэл хөгжил хүн амын дийлэнх хэсэг рүү чиглэсэн байх ёстой. Ийм учраас ядуурлыг бууруулах тухай санал мэтгэлцээн, маргаанууд нь маш их улс төржиж үзэл сурталжсан шинжтэй болсон байх нь түгээмэл тохиолддог.

ЯДУУРАЛ, ТЭГШ БУС БАЙДАЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ТУХАЙ МАРГААН

Хөгжиж буй орнуудын хувьд ядуурлыг бууруулах нь гол зорилго байх ёсгүй, эдийн засгийн өсөлт нэгдүгээрт тавигдах ёстой гэж олон хүн маргадаг. Тэд эцсийн дүнд эдийн засгийн өсөлтийн үр шим ядуучуудад ч хүрнэ гэдэг. Түүгээр ч үл барам 1971 оны эдийн засгийн салбар дахь Нобелийн шагналтан Саймон Кузнец зэрэг эрдэмтэд тухайн орны хөгжлийн эхний шатуудад тэгш бус байдал гарах нь гарцаагүй бөгөөд дараагийн шатанд улс орон баяжиж нийгмийн сайн сайхан, хөгжил, ядуурлыг бууруулахад хөрөнгө оруулдаг болно, ингэхээр эдгээр нь хоёрдогч зорилго гэж үзэж байжээ. Энэ үзэл бодол одоо цагт хоцрогдсон хэдий ч хөгжлийн тухай маргаанд хүчтэй нөлөө үзүүлсэн хэвээр байна. Эдийн засгийн өсөлтийг гол зорилгоо болгоод суурь боловсрол, усны хангамж бусад нийгмийн хөгжлийн асуудлыг орхигдуулсан бодлогыг өнөөдөр ч олон засгийн газар баримталсаар байна.

Гэтэл энэ үзэл ядуучуудыг дэмжих бодлогыг хойш нь тавихад аятайхан арга зам болж болно. Ядуурлыг бууруулахад эдийн засгийн тогтвортой өсөлт хэрэгтэй нь мэдээж. Гэвч эдийн засгийн өсөлтийг хангах нь дангаараа хангалтгүй буюу өсөлтийн чанар чухал үүрэгтэй байдаг. Өсөлт нь ажил эрхлэлтэд янз бүрээр

нөлөөлдөг. Гэтэл ажил эрхлэлт бол ядуурлыг бууруулах хамгийн баталгаатай арга зам. Уг нь ядуурлыг бууруулах бодлого нь ажлын байр бий болгодог түргэн, тогтвортой хөгжлийг зорилгоо болгох ёстой. Гэтэл сүүлийн хэдэн арван жилд ажлын байр бий болгодоггүй өсөлт маш их гарсан ба үр дүн аажимдаа гарах тухай Кузнецийн онол огт хэрэгжээгүй байна. Ажлын байргүй ч түргэн өсөлт нь татварын орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэр болж тэрхүү орлогоор нийгмийн хөгжлийг санхүүжүүлж, дотоодын эдийн засгийг дэмжих боломжтой гэж үзсэн хэрэг.

Сүүлийн үед Кузнецийн онолыг эсэргүүцэх нь элбэг болжээ. Дээр тэмдэглэсэнчлэн ядуурлыг тогтвортой бууруулахад өсөлт хэрэгтэй. Гэхдээ үүний хажуугаар орлого хуваарилалтын хэтэрхий тэгш бус байдал нь тэрхүү өсөлтөд саад болдог. Хэдхэн хүний гарт бүх хөрөнгө, баялгийг төвлөрүүлж, ядуурлын өндөр түвшинд хүрэх эрсдэл үүсгэснээр тухайн улсын дотоодын зах зээл боогдмол байдалд орж, үүнээс болж дотоодын эрэлт буурч, үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн борлогдохгүйгээс үйлдвэрлэл өсөхгүйд хүрдэг байна. Хэт тэгш бус хуваарилалттай нийгэмд улс төрийн хурцадмал байдал, нийгмийн тайван бус уур амьсгал ноёлдог. Мөн амьдралын ядуу нөхцөл, ялангуяа нялхас, хүүхдүүдийн тэжээлийн дутагдал, ядуу байдал нь эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж, нас баралтыг нэмэгдүүлж, оюуны чадварыг бууруулж, ирээдүйн насанд хүрэгчдийн ажлын үр ашиг, чадамж багасна. Үйлдвэрлэлийн үр ашгаа сайжруулж, олон улсад өрсөлдөх чадвартай болж, дотоодын зах зээлээ хөгжүүлж, тасралтгүй эдийн засгийн өсөлтийг хангая гэвэл тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого зайлшгүй хэрэгтэй.

Эдийн засгийн тэгш бус өсөлтийг зөвтгөх хүчин зүйлүүд

- Өсөлт бол ядуурлыг бууруулах урьдач нөхцөл мөн. Өсөлтийн үр дүнг нийгмийн бусад гишүүд ажимдаа хүртдэг.
- Баячууд хөрөнгийг их хэмжээгээр хуримтлуулж, тэгш бус байдал хэдий чинээ их байна, орлого тэр хэмжээгээр их байж хөрөнгө оруулах сонирхол мөн тэр хэмжээгээр өндөр байх бөгөөд ирээдүйн хурдацтай хөгжлийг хангана.
- Ядуурал, тэгш бус байдал нь ажлын хүч хямд байх

нөхцлийг хангадаг бөгөөд хөрөнгө оруулалтыг урамшуулдаг байна.

- Хөрөнгө оруулагчид/өндөр орлоготой бүлгүүдийн татварыг бууруулж ядуурлыг бууруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгоход зохих анхаарал хандуулахгүй бол нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж болно.

Тэгш бус хөгжлийг буруутгах санаа оноо:

- Хөгжлийн эхний шатаас эхлэн эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах ажлыг улс орны хөгжлийн стратеги болон төр, иргэд хоорондын гэрээ гэсэн үүднээс нэгэн зэрэг хэрэгжүүлэх ёстой юм.
- Аливаа өсөлтийн чанар чухал байдаг. Нийгэмд оруулах хөрөнгө оруулалтын зэрэгцээ хөгжлийн үйл явцад (ажил эрхлэлт, хуваарилалт, сайн засаглал, зах зээлийн аливаа гажигийг арилгах, тогтвортой байдлыг хангах) зохих анхаарал хандуулах ёстой.
- Тэгш бус байдал нь хөгжлийн гаж загварууд, тухайлбал хямд хөдөлмөрийн хүчнээс хамааралтай болох зэрэг байдлыг бий болгодог. (“race to the bottom” хэмээгч үзэгдэл нь цалингийн хэмжээг өрсөлдөгч хамгийн ядуу улсын түвшинд аваачдаг).
- Тэгш хуваарилалтын загварууд нь дотоодын эрэлтийг урамшуулж өсөлтийг хангадаг; бага орлоготой бүлгүүдийн эрэлт нь (хэрэглээний харьцаа) дотоодын зах зээлийн багтаамжийг өсгөдөг.
- Ядуу хүмүүсийн орлогыг нэмэгдүүлэх нь ажиллах хүчний үр бүтээлийг дээшлүүлдэг.
- Тэгш бус байдал их байхын хэрээр хүчирхэг бүлэглэлүүдэд баялаг илүү оногдох бөгөөд тэд ч өөрсдийн давуу байдлыг алдахыг хүсдэггүй – тэгш бус байдал нь нийгмийн дэвшилд саад тотгор болоод зогсохгүй дотоод дахь улс төрийн зөрчилдөөнд нөлөөлдөг.
- Баячууд болон ядуучуудын амьдралын түвшний хоорондын эрс ялгаатай байдал - дэлхийн хүн амын 80 %-д дэлхийн орлогын дөнгөж 11% ногддог байдал - ихээхэн санаа зовоох болжээ. Учир нь зохион байгуулалттай террорист бүлэглэлүүд дэлхийн хамгийн ядуу орнуудад үүрлэх болсон байна.

XXI-р зууны эхэн үеийн ядуурлыг бууруулах бодлого

Дэлхийн хөгжиж байгаа 3 улс орон тутмын 1 нь ядуурлын эсрэг бодлогыг өөрийн үндэсний төлөвлөлтдөө оруулсан байдаг. Тэрхүү бодлого нь хязгаарлагдмал төсөвтэй, зорилго болон үр дүнд хүрэх хугацааг тогтоогоогүй байх нь түгээмэл байдаг. Олон улсын хамтын нийгэмлэгээс 1995 онд зохион байгуулсан Нийгмийн асуудлаархи дэлхийн чуулганаас тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн юм. Мөн Мянган Хөгжлийн Ерөнхий Ассамблейн зорилтуудыг НҮБ-ын 55 дугаар Чуулганаар (2000) баталсан байна. Эдгээрт 2015 он гэхэд өлсгөлөн болон нэн ядуу байдлыг арилгах; бүх нийтэд ерөнхий боловсрол олгох, нялхсын эндэгдлийг бууруулах, эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах, хүйсийн тэгш байдлыг хангаж эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, ДОХ болон хижиг зэрэг өвчинтэй тэмцэх, байгаль орчныг хамгаалж хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг хөгжлийн үзүүлэлтүүдийг хангах зорилтыг тавьжээ. Мянган Хөгжлийн зорилтууд нь хэрэгжүүлэхэд хүнд боловч засгийн газрууд зохих хүч гаргаваас биелэх боломжтой юм. Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд, ЭЗХАХБ, засгийн газруудын хамтын ажиллагаа болон олон улсын төрийн бус байгууллагууд нь бүгд Мянган Хөгжлийн зорилтуудыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн юм.

Энэ ч утгаараа олон улсын хөгжлийн банкууд болох Дэлхийн банк, Африк, Ази, Америк хоорондын хөгжлийн банк нь, Олон улсын валютын сангийн дэмжлэгтэйгээр эдийн засгийг хөгжүүлэх зорилтыг өөрсдийн үйл ажиллагааны ядуурлыг бууруулах зорилт болгон өөрчилсөн юм.

“Өсөлт түрүүлж явагдах ёстой юу, эсвэл ядууралтай тэмцэж хөгжих ёстой юу” гэсэн маргаан дахин үүсч, бүх улсын бодлогын тухай яриа хэлэлцээрт байнга дурдагдаж байна. Ядуурлыг бууруулах үүднээс үзвэл, зохион байгуулалтын өөрчлөлт хангалтгүй байгаа ч зорилтыг тийнхүү шинээр тодорхойлсон нь нийгмийн дэвшлийн зүг хийсэн чухал алхам юм.

Олон улсын хэмжээнд дараахь асуудлуудыг хэлэлцэн тохирчээ. Үүнд:

1. Ядуурлыг бууруулах ажилд тулгарч буй бэрхшээлүүдийг шинжлэн дүгнэх, эдгээрийг даван туулах стратегийг зөвшин тохирох: Эхний ээлжинд ядуурлын эсрэг үр дүнтэй стратеги боловсруулахын

тулд тухайн улс яагаад ядууралтай байгааг тогтоох, ядуурлын түвшингийн тухай зөвшилцөн тохирч нэгдсэн ойлголттой болох нь чухал. 1990-ээд оны сүүл үед гэхэд олон улсын хөгжлийн банкууд дунд болон урт хугацааны төлөвлөгөөнүүд, нэн ядуу улс орнуудад хэрхэн ажиллах зэрэг Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөний баримт бичгүүдийг боловсруулж эхэлжээ.

2. Улс орнуудын ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлого: Ядуурлыг бууруулах ажил нь зөвхөн буяны байгууллагын шинжтэй үйл ажиллагаа явуулснаар олигтой үр дүнд хүрэхгүй. Энэ ажил нь эдийн засаг, улс төр болон нийгмийн шатанд бүтцийн өөрчлөлтийг хийхийг шаарддаг. Олон улсын байгууллагуудын өөр хоорондоо ялгаатай олон нэр томъёог тооцон анхааралдаа авч ядуурлыг бууруулах ажлын нэн тэргүүний зорилтуудыг товч байдлаар тодорхойлбол дараахь дүр зураг харагдаж байна. Үүнд:

- (a) **Ядуучуудад чиглэсэн өсөлт:** Энэ нь ажил олголтын түвшин, сайн сайхан амьдралыг дэмжих тогтвортой бодлого юм. Хувийн хэвшил бол аливаа өсөлт, ажил эрхлэлтийг хангах гол хөдөлгүүр юм. Ядуурлыг бууруулахын тулд хувийн хэвшилд өрсөлдөөнийг дэмждэг, шударга практикийг тогтоох шаардлагатай бөгөөд гэхдээ үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг ядуучууд хүртэж чадахуйц байх ёстой. Улсын секторын зүгээс хийх хөрөнгө оруулалт нь хувийн хэвшлийн дутууг нөхөхөд гол үүрэг гүйцэтгэх ёстой. Тухайлбал, батлан хамгаалах салбарт санхүүжилт олгохоосоо илүү хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийх, томоохон хэмжээний эрчим хүчний үйлдвэрүүдийн төслийг дэмжихээсээ илүү орон нутгийн эрчим хүчний асуудалд анхаарах, том хэмжээний зам барихын оронд хөдөө аж ахуйн үйлдвэрийг зах зээлтэй холбох зам барихад анхаарах зэрэг жишээг энд хэлж болно.
- (b) **Ядуучуудад боломж, бололцоо олгох.** Баялгийг (газар, өмч, байгалийн баялаг) бүтээх, худалдан авах буюу аливаа баялаг, санхүүгийн эх үүсвэр (зээл), тодорхой чадварыг олж авах боломжийг ядуучуудад олгох зэрэг зорилтууд үүнд хамаарна.
- (c) **Сайн засаглалыг баталгаажуулах.** Үүнд: ядуучуудыг дэмждэг, дэмжихийг зорилгоо болгосон хариуцлагатай, нээлттэй, үр нөлөө бүхий захиргааны байгууллагын тогтолцоог бий болгох; ядуучуудад хүрч үйлчилж чаддаг,

шударга эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх; хууль ёс, дэг журмын биелэлтийг баталгаажуулах; хуваарилалтыг сайжруулах; хүн амыг оролцуулсан, улс төрийн аливаа нөлөөллөөс ангид, төвлөрсөн бус хэлбэртэй нийтийн үйлчилгээний удирдлагын механизмыг бий болгож, уг үйлчилгээ нь зөвхөн цөөн тооны хүмүүст үйлчлэх боломжийг хязгаарлах; дэвшилтэт татварын тогтолцоог дэмжиж нийгмийн үйлчилгээний хүртээмж, албан тушаалыг танил талаар хуваарилах явдал, авилгатай тэмцэх зэрэг зорилтууд үүнд багтжээ.

(d) Ядуу, эмзэг бүлгүүдийн эрхийг хамгаалах байгууллагуудыг бэхжүүлэх, тэдгээр бүлгүүдээс улс төрийн болон эдийн засгийн амьдралд оролцох нөхцлийг хангах. Хөгжилтэй орнуудын хувьд ядуучууд болон эмзэг бүлгийн хүмүүсийг өөрсдийнхээ эрхийг хамгаалах боломжийг олгох ажлыг зохион байгуулах явдал нь нийгмийн хөгжлийг хангах чухал ажил болсон юм. Нийгмийг зохион байгуулалт, хөдөлгөөнд оруулах гэдэгт сайн засаглалыг дэмжих, ил тод, нээлттэй байдлыг хангах, засгийн газар ард иргэдийн өмнө хариуцлага хүлээдэг байх нөхцлийг бүрдүүлэх зэрэг ажлыг хамруулдаг.

(e) Нийгмийн үйлчилгээний салбарт хөрөнгө оруулалт хийх. Бараг бүх хөгжиж буй улс орон сүүлийн хэдэн арван жилийн туршид нийгмийн талаар баримтлах өөрийн гэсэн бодлоготой болжээ. Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамд бараг бүх улсад байдаг боловч нийгмийн халамжийн үйлчилгээг ядуу иргэдэд тэр бүр хүргэн ажиллаж чаддаггүй. Энэхүү нөлөө муутай байдал нь гол төлөв,

Нэгдүгээрт: аливаа бодлого хүн амын тодорхой нэг хэсгийг / эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүдийг, ядуучуудаас илүү нийгмийн чинээлэг хэсгийг/ хамардагтай холбоотой; мөн

Хоёрдугаарт: хөтөлбөрүүдэд хөрөнгө буруу хуваарилсанаас санхүүжилт хүрдэггүй. Үүний түгээмэл жишээ бол суурь боловсролын байгууллагын оронд их дээд сургуулиудад хөнгөлөлт үзүүлэх, орон нутагт жижиг эмнэлгүүд байгуулахын оронд нийслэл хотод зүрх судасны том эмнэлэг байгуулах гэх мэт. 1990-ээд оны үеийн инфляцийн эсрэг хөтөлбөрүүд болон өрийн хямралын улмаас нийгмийн халамжийн салбарт олгох санхүүжилт бүр ч багассан. Нийгмийн үйлчилгээний хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ядуучуудад үйлчлэх явдлыг баталгаатай болгох чиглэлээр зөв салбарыг тэргүүлэх ач холбогдолтой болгох нь Мянганы Хөгжлийн Зорилтуудыг биелүүлэх

талаар зайлшгүй авах ёстой арга хэмжээнүүд юм.

- (f) **Хүйсийн тэгш бус байдалтай тэмцэх.** Ядуурал хүйсийн шинж чанартай болж байгаа хандлага дэлхий даяар ажилагдаж байна. Хөдөлмөр ба гэрийн ажлын үүрэг хариуцлагыг хүйсээр хуваадаг байдал эмэгтэйчүүдийг цалингүй ажиллуулах, тэдэнд дутуу нөхцөл олгох байдалд хүргэж байна. Хүйсээр ялгах нь нөөцийг хуваарилахад тэр чиглэлийн тэгш бус байдал үүсгэж, эмэгтэйчүүдийн үндсэн эрхийг /боловсрол, ажил эрхлэлт, өв залгамжлал, бүртгэл гэх мэт/ хязгаарлахад хүргэж байна. Ядуурлыг бууруулж, дэлхийн хүн амын тал хувийн статусыг сайжруулахын тулд хүйсийг харгалзсан бодлого, хөтөлбөрүүдийг хөгжүүлэх шаардлагатай.
- (g) **Ядуучуудын эмзэг байдал, эрсдлийг багасгах.** Орлогын хэмжээгээр ядуурлыг тодорхойлоход ядуурлын түвшинг илтгэсэн нэг янзын тоо гарах хэдий ч ядуурал нь тогтвортой байдаггүй учраас олон хувь хүн, айл өрхүүд ядуурлын шугаманд ойрхон хэмжээний орлоготой байж ядуурлын түвшин рүү шилжих өндөр эрсдэлтэй тулгардаг. Эрсдэлд маш олон зүйл багтаж болно: байгалийн гамшиг, иргэний зөрчилдөөн, эдийн засгийн өөрчлөлтүүд, санхүүгийн хямралаас гадна, ургац муу байх, ажилгүй болох, өвчинд нэрвэгдэх, үйлдвэрийн осолд орох, тахир дутуу болох, нас барах, өндөр настай болох зэрэг өрх гэрийн доторх өөрчлөлт тухайн айлын ба гишүүдийнх нь ирээдүйд заналхийлж байдаг. Нийгмийн хангамж, баталгаат байдал, гамшгаас урьдчилан сэргийлж, уршгийг арилгах хөтөлбөрүүд, түргэн тусламжийн хангамж зэрэг нь ядуучуул болон эмзэг бүлгүүдийн аюулгүй байдлыг хангахад маш чухал.

Энэ хөтөлбөрийг шүүмжлэгчид дээрх арга хэмжээнүүд нь үр дүнд хүрэхгүй гэж үзэх нь бий. MDB зэрэг НҮБ-ын байгууллагуудын дэмжсэн энэ хөтөлбөрийг ядуурлыг түргэн бууруулахад заавал хэрэгжүүлэх ёстой ч зөвхөн үүгээр хязгаарлагдах ёсгүй. Дахин хуваарилах бодлогод зохих анхаарал хандуулах шаардлагатай. Энэ хөтөлбөр үндэстэн улсын дотоодын асуудлуудад төвлөрсөн байдаг тул олон улсын түвшингийн гадаад асуудлуудыг /өрөөс хөнгөлөх, дэлхийн санхүүгийн нөлөө, зах зээл рүү нэвтрэх хязгаарлагдмал боломж гэх зэрэг/ бараг хөндөөгүй байдаг. Түүгээр ч үл барам НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд ба MDB-ууд /тэр байтугай нэг байгууллага доторх салбар хэлтсүүд/ өөр хоорондоо зөрчилтэй бодлого боловсруулж байна. Зарим ажилтан дээрхтэй адил ядуурлыг бууруулах хөтөлбөр дээр ажиллаж байхад нөгөө нэг хэсэг нь ядууралтай хамаагүй

мэт харагддаг ч ядуурлыг үүсгэгч макро эдийн засгийн шийдвэр гаргаж байна. Үүнд шүүмжлэлтэй хандаж буй төрийн бус байгууллагууд нийгэм эдийн засгийн арга замуудыг хайж, үндэстний болон олон улсын бодлого боловсруулалт хоорондоо уялдаатай байж, дэлхийн бүх хүнд үр ашгаа өгөхийг баталгаатай болгохуйц захиргааны шинэ тогтолцооны төлөө тэмцэж байна. Хэд хэдэн саналаас үндэслэн ядуурлыг бууруулахад дараах арга хэмжээнүүдийг олон улсын хэмжээнд авах шаардлагатай гэдэг дээр тэд зөвшилцөөд байна. Үүнд:

/i/ Гуравдагч ертөнцийн өрийг авч үзэх. ОУВС, Дэлхийн Банкнаас өрийг багасгах талаар янз бүрийн оролдлого хийж буй хэдий ч хөгжиж буй орнууд өрөнд баригдсан хэвээр байгаа бөгөөд хомсхон хөрөнгийн сангаа ядуурлыг бууруулахын оронд өрөө төлөхөд зарцуулж байна. Jubilee 2000 гэх зэрэг төрийн бус байгууллагууд хамгийн ядуу орнуудын өрийг хүчингүй болгохын төлөө тэмцэж байна.

/ii/ Олон улсын санхүү, корпорациудад зохицуулалт хийх. Өнөөдрийн санхүүгийн зах зээл дэх үргэлжилсэн хямрал, тогтворгүй байдлаас үндэслэн шүүмжлэгчид “дэлхийн казино” гэдэг ойлголтын тухай түүнчлэн хөгжлийг дэмжихийн хамт богино хугацааны хуурамч хөрөнгийн урсгал, татвараас зайлсхийх явдал, мөнгө угаахтай тэмцэх чадвартай санхүүгийн шинэ зохион байгуулалт бүрэлдүүлж байдлыг зохицуулах шаарлага гараад байгаа тухай ярьж байна. Олон нийтийн хариуцлагын боловсронгуй зарчмуудыг бий болгон хэрэгжүүлж, иргэд/хэрэглэгчдийг байгууллагуудын болзошгүй хариуцлагагүй хандлагаас хамгаалах шаардлага үүсээд байна. /АТТАС International, Corpwatch-ыг үз/

/iii/ Дэлхийн Худалдааны Байгууллагаас эхлээд олон улсын худалдааг шинэчлэх, тэгэхдээ улс хоорондын “чөлөөтэй, үл ялгаварласан” гэсэн нэр төдий өрсөлдөөнд тулгуурласан өнөөдрийн загварыг орхих. Энэ загвар нь хуурамч бөгөөд ядуу орнуудад хамгийн хөгжиж өрсөлдөх боломжтой хөдөө аж ахуйн салбарт л гэхэд ялгаагүй Европын холбоо, АНУ, Японы засгийн газрууд өөрийн үйлдвэрлэгчиддээ хөнгөлөлт үзүүлдэг юм. “Үр ашиг”, “чөлөөт зах зээл” гэдэг нэрийн дор хөгжиж буй орнуудыг эдийн засгаа нээлттэй болгож, чөлөөлөхийг шаардаж, үр дүнд нь дотоодын үйлдвэрлэгчид хөгжингүй орнуудын илүү

өндөр чанартай, хөнгөлөлттэй бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадваргүй болон хаагдаж, эцсийн дүнд ажилгүйдэл, ядуурал улам нэмэгдэж байна. Энэхүү хоёрдмол номлол /Миний хийснийг биш, хэлснийг хий/-оос салж, зах зээлийн баримжаатай бодлогыг хэрэгжүүлэх нь ядуурлыг бууруулахад нэн чухал. Өнөөдрийн худалдааны бодлого хамгийн ядуу бүсүүдийн тусын тулд “шударга” худалдааны тогтолцоогоор солигдох ёстой. Ийм тохиолдолд хөгжиж буй орнууд дэлхийн эдийн засагт байр суурьтай болно. /Public Citizen Global Trade Watch, Focus on the Global South, The Third World Network-ыг үз/

ЯДУУРЛЫГ ДЭЛХИЙ НИЙТИЙН ХҮРЭЭНД ОЙЛГОХ НЬ

Ядуурлыг бууруулах тухай хамгийн сүүлийн үеийн үзэл бодол дэлхий нийтийн хэмжээнд ядуурлыг ойлгохоос эхлэх ёстой. Нэг талаас ядуурал нь зөвхөн гуравдагч ертөнцийн асуудал биш болжээ. Неолиберал бодлогыг баримталсан 20 жил барууны орнуудын иргэдийн амьдралын нөхцлийг дордуулсан байна. 1970-аад онд дайны дараах цэцэглэсэн хөгжил дуусч хөгжингүй орнуудын бодлого боловсруулагчид Кейнсийн хандлагыг орхиж, нийлүүлэлтийг баримжаалсан бодлого руу шилжин “неолиберал ортодокс”-ыг сурталчилж компаниуд өрсөлдөх чадвараа дээшлүүлэхэд “өсөлт” бий болно гэсэн зөв үзэлтэй болжээ. Ийм бодлогыг 20 жил баримталсны үр дүнд үйлдвэрлэлийн үр ашиг сайжирч өсөлт байнга явагдаж байв. Гэсэн хэдий ч ийм үр дүнд хүрэхийн тулд төлсөн үнэ бий. Бүтцийн өөрчлөлт гэгддэг зүйл өрсөлдөөнийг өсгөсөн боловч тухайн нэг компанийн ашгийг бууруулсан. Ингэснээр болоод компаниуд ажиллах хүчээ хумьж, цалингаа багасгаж, тэтгэвэр халамжийн мөнгөө хасчээ. Үүнээс үүдэн Засгийн газар ч нийгмийн халамжид зарцуулах мөнгөө нэлээн багасгажээ. Ингээд барууны олон иргэний амьдралын нөхцөл муудаж, өсөлтийн хэмжээ бага, ажилгүйдэл ба хүн амд төлөх “өр” өндөр хэвээр үлджээ. Энэ нь юунаас болсон бэ гэвэл дээрх богино хугацааны неолиберал бодлогууд удаан хугацааны хөгжилд чиглээгүй юм: Хэт их нийлүүлэлтэд анхаарч байсан нь дэлхий нийтийн хэмжээний ажиллах хүчний илүүдлийг бий болгож эрэлтийг бууруулжээ. Үүний

хажуугаар хөгжингүй орнуудад дэлхийн хэмжээний шийдэл гартал ядуурал ба ажилгүйдэл тэдгээр оронд өссөн хэвээр байна.

Дэлхий нийтийн хэмжээнд сэтгэх шаардлагатайн бас нэг шалтгаан гэвэл хөгжиж буй орнууд дахь ядуурлын шалтгаан тухайн улсын засгийн газрын шийдвэрлэх боломжгүй олон улсын бодлогуудаас үүдэлтэй. Жишээлбэл, тэдгээр улс орнууд хөгжингүй орнуудын зах зээл рүү нэвтрэх боломж бага байдаг. Өмнөх хэсэгт дурдсанчлан ядуурлыг бууруулахын тулд олон улсын хамтран зөвшилцсөн хүчин чармайлт шаардлагатай. Түүгээр ч үл барам 1980-1990-ээд оны үед хөгжиж буй орнуудаас хөгжингүй орнуудтай ижил ортодокс загварыг баримтлахыг шаардаж байсан нь “Вашингтоны зөвшилцөл” гэгдэх бодлого /бүтцийн зохицуулалт, хөрөнгө ба худалдааны хяналтыг багасгах, тогтмол бус олон нийтийн зарцуулалт, өмч хувьчлал/ байлаа. Үүний дүнд хямрал гүнзгийрч, хүний нөөц зэрэг үндэстний хөгжлийн хэтийн бодлогодоо хөрөнгө оруулахын оронд нийгмээс хөндийрсөн бодлогыг хэрэгжүүлэх явдал түгээмэл болж байв. Иймээс ч 1980-1990-ээд оныг “алдагдсан жилүүд” гэж нэрлэх нь бий.

Даяаршил худалдаа, хөрөнгө оруулалт, технологийг хөдөлгөөнд оруулж, үнэт зүйлсийг өөрчилж, эдийн засгийн харилцан хамаарал, эрсдэлд өртөмтгий байдлыг бий болгож байна. Нийгмийн халамжийн бодлогыг энэ үед хэрэгжүүлэхгүй бол улс орнуудад ажилгүйдэл, ядуурал, улс төрийн зөрчилдөөн нүүрлэн, хүн ам нь хямралын үр дагаварыг үүрэх болно. Даяаршилыг хүлээн зөвшөөрөхийн тулд илүү сайн менежмент хийх шаардлагатай буюу даяаршилын үр ашгийг зөвхөн цөөн хэдэн хүн биш, харин бүх хүн хүртэх боломжтой хөгжингүй ба хөгжиж буй орнуудын аль алинд зориулсан “Шинэ Гэрээ” хэрэгтэй. Цаашилбал, ядуурлыг дэлхий нийтийн хэмжээнд бууруулахад дэлхий нийтийн эрэлт хэрэгцээ, үйлдвэрлэлийн үр ашиг огцом нэмэгдэнэ. Ингэхээр ядуурлыг бууруулснаар бусад бэрхшээл арилхын сацуу тогтвортой өсөлт, сайн ажиллагаатай зах зээл бий болгох боломж бүрдэнэ.

АНХААРАХ ЗҮЙЛС БҮЮУ ОНОЛ, ПРАКТИК ХОЁРЫГ ЯЛГАХ

- Хамгийн эхний байнга тавих ёстой асуулт бол: Хэнд ашигтай вэ? Х юм уу У бодлогоос хэн чухамдаа ашиг олох вэ? Бодлого боловсруулахдаа цөөн хэдэн давуу эрхтэй хүмүүсийг биш, харин ихэнх иргэдэд ашигтай байх явдалд голлон анхаарах ёстой.
- Сүүлийн үеийн эдийн засгийн бодлогууд, санхүүгийн цочроох арга хэмжээнүүд нийгэмд хэрхэн нөлөөлсөн бэ? /хөдөлмөр, ажил эрхлэлт, чухал бараа үйлчилгээний үнэ, эмэгтэйчүүд, эмзэг бүлгүүдэд хэрхэн нөлөөлсөн бэ?/
- Төсвийн хөрөнгө хаашаа хуваарилагдаж байна вэ? Ядуучууд хуваарилалтанд хамрагдаж байна уу? /засгийн газар буюу аливаа хөгжлийн байгууллагад хамаарах асуулт/. Зарцуулалт нь захиргааны байгууллагууд, хууль ёсны ашиг сонирхлуудад төвлөрч байна уу, эсвэл нийтийн салбар шаардлагагүй үед хувийн секторыг олшруулж байна уу? Засгийн газар төсвөө хэрхэн хуримтлуулдаг вэ? Дэвшилтэт татварын тогтолцоо хэрэгжиж байгаа юу?
- Гол салбаруудын /хөдөө аж ахуй, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр зэрэг/ хөтөлбөрүүд ядуурлыг бууруулах чиглэлд тус нэмэр болж байна уу? Хэнд ашигтай байна? Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөгжлөөс ашиг хүртэхэд ядуучуудад юу саад болж байна?
- Авилга, гэмт хэрэг нь хөрөнгө оруулалт болон иргэдийн идэвхийг бууруулж байна уу? Бүх иргэд шударга ёс, аюулгүй байдал, үйлчилгээг тэгш хүртэж чадаж байна уу? Засгийн газар хүйс, анги бүлэг, арьсны өнгө, шашин шүтлэгээр ялгаварлах явдал үр дүнтэй тэмцэж чадаж байна уу? Нийгмийн бүлгүүд зохион байгуулагдсан уу, тэд өөрсдийгөө тэгш бус хандлагаас хамгаалах механизмыг мэддэг үү?
- Дэвшлийг юугаар хэмжиж байна вэ? Ядуурлын шугамыг хэрхэн тооцож байгаа ба тооцох арга зүй өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа юу?
- Тухайн орон дотооддоо хэр их юм хийх чадалтай вэ? Тухайн улсын нийгмийн халамжид зарцуулдаг хөрөнгөтэй харьцуулж өрийн үйлчилгээний түвшинг хяна. Санхүүгийн цочир уналтанд орсон уу? /тухайлбал Азийн хямрал/, тийм бол эдийн засаг бүрэн сэргэсэн үү? Үндэстний ямар бүтээгдэхүүн хөгжингүй орнуудын зах зээлд хүрэхэд саад бэрхшээлтэй тулгарч байна вэ?

Нэмэлт мэдээлэл авах эх сурвалжууд:

1. Millenium Development Goals (MDGs)
<http://www.developmentgoals.org/>
2. World Bank Poverty Network
<http://www.worldbank.org/poverty/>
3. United Nations Development Program Poverty Page
<http://www.undp.org/poverty/>
4. Sussex University Eldis Poverty Resource
<http://www.eldis.org/poverty/>
5. Overseas Development Institute Poverty and Public Policy
<http://www.odi.org.uk/pppg/index.html>
6. 50 Years is Enough: U.S. Network for Global Economic Justice
<http://www.50yeras.org>
7. Glasgow-based The Poverty Alliance
<http://www.povertyalliance.org>
8. DFID-sponsored site on Globalization and Poverty
<http://www.gapresearch.org>
9. Global Issues, Энэтхэг гаралтай Ануп Шах гэдэг компьютерийн ухааны эрдэмтний бүтээсэн энэ сайт ядууралд хамаатай олон асуудлыг багтаасан
<http://www.globalissues.org/TradeRelated/Poverty.asp>
10. Northwestern University and University of Chicago's Joint Center for Poverty Research
<http://www.jcpr.org>

ДЭЛХИЙН БАНК

Абид Аслам

Бүхнийг бүх хүний төлөө юу?

Сэтгүүлчид Дэлхийн Банкыг зээлдүүлэгч байгууллага, хөгжлийн агентлаг, бодлого боловсруулагч, олон улсын улс төр, эдийн засгийн бодлогын төв, хүнд суртлын аппарат, 10.000 ажиллагсадтай байгууллага гэх зэрэг олон талаас нь сурвалжилсаар өнөөг хүрчээ.

Энэ Банк нь дэлхийн II дайны дараа улс орнуудад эдийн засгаа сэргээн босгоход нь туслах үндсэн зорилготойгоор 1944 онд анх байгуулагджээ. 1960 он гэхэд Дэлхийн Банк ядууралтай тэмцэх явдлыг өөрийн үндсэн зорилгоо болгон тодорхойлсон байна. Өнөөгийн байдлаар Банк нь хөгжиж байгаа болон хуучин Зөвлөлт Холбоот улсын бүрэлдэхүүнд багтаж байсан улс орнуудад жилд дунджаар 20 орчим тэрбум ам. долларыг зах зээлийн түвшингийн хүүтэй ойролцоо хүүтэйгээр, 6 тэрбум орчим долларыг хүүгүйгээр зээлдүүлдэг байгууллага болоод байна. Банкнаас олгож байгаа зээл нь улмаар тухайн улс орны засгийн газарт бусад улс орон, арилжааны банкууд болон хувийн сектороос зээлсэн мөнгөө эргүүлэн төлөх боломжийг олгодог байна. .

Гишүүн улс орнуудын зүгээс үзүүлж байгаа нөлөөлөл, олон нийтийн идэвхтэн байгууллагууд, өөрийнх нь ажиллагсдын шаардлагаар Банкны бодлого болон үйл ажиллагаа ихээхэн хэмжээгээр өөрчлөгдсөөр ирсэн юм.

Өнөөгийн байдлаар Банк дэд бүтцийн төслүүд, тухайлбал усан цахилгаан станц, усан боомт, хот хоорондын томоохон замууд засмал зам барих төслүүдийг санхүүжүүлэх нь түгээмэл хэвээр байна. Гэсэн хэдий ч 1970 он гэхэд Банк хэрэгжүүлж буй төслүүдийнхээ амжилтыг уг төсөл хэрэгжих бодлогын орчингоос ихээхэн шалтгаалдаг гэсэндүгнэлтийг хийж эхэлжээ. Ийм ч учраас банк улс орнуудад зээл олгохдоо тэдгээрийн засгийн

газарт эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрхэн явуулах талаар зөвлөмж өгөх болжээ. Тэдгээр зөвлөмжийн дагуу хийсэн бүтцийн өөрчлөлтүүд нь “хоёр дахь үеийн” гэж нэрлэх санаачлагуудыг, тухайлбал, дэд бүтэц, цахилгаан холбоо, нийгмийн үйлчилгээний салбаруудын хувьчлал; хөдөлмөр, иргэний үйлчилгээнүүд; тэтгэврийн системд хувийн хөрөнгө оруулалт орох боломжийг бий болгох төсөл зэргийг өрнүүлжээ. Төсвийн алдагдлыг бууруулах, тарифыг хөнгөлөх, богино хугацааны хөрөнгө оруулалтад эдийн засгийг нээлттэй болгох зэрэг нь либералчлал, тогтвортой байдлыг хангах бүтцийн чухал өөрчлөлтүүд юм.

Бүтцийн өөрчлөлтүүдэд зориулагдсан бодлогын болоод зөвхөн тодорхой нэг бүтцийн өөрчлөлтэд зориулагдсан зээлүүд банкнаас олгосон нийт зээлийн тал орчим хувийг эзэлж байна. Ер нь бол Дэлхийн Банк төв байр нь Вашингтон хотод байрладаг байгууллага болох Олон улсын валютын сантай зөвшилцөлгүйгээр бүтцийн өөрчлөлтөд зориулж мөнгө зээлүүлдэггүй. (Тухайн улсад Олон улсын валютын сан үйл ажиллагаагаа зогсоовол Дэлхийн Банк нь ихээхэн хэмжээний зээл олгохоос аль болох зайлсхийдэг байна. Гэсэн хэдий ч Этиоп улсад Банкнаас олгосон зээлийн хэмжээ сүүлийн жилүүдэд 3 дахин өссөн бол, Вьетнамд 90-ээд оны үед мөн л ихээхэн хэмжээний зээл олгодог байсан байна.)

Бүтцийн өөрчлөлтөд зориулагдсан зээл Банкнаас олгосон нийт зээлийн дийлэнх хэсгийг нь эзэлдэг болохын хэрээр эрүүл мэнд, боловсрол болон бусад салбаруудад, мөн ядуурлыг бууруулахад чиглэсэн төслүүдэд зээл олгох явдал мөн өргөжсөн байна. Энэ бодлого 1960 оны үед Роберт Макнамара тус Банкны ерөнхийлөгч байх үед эхэлж одоогийн ерөнхийлөгч Жэймс Вольфансоны үед ч үргэлжилж тодорхой хэмжээгээр өөрчлөгдсөөр иржээ. Дээрх хоёр ерөнхийлөгч Банкны гол зорилго нь ядууралтай тэмцэх явдал гэж хэлдэг байсан ч Вольфансон Банкны зорилгыг өмч хувьчлал болон эдийн засгийн либералчлал-(заримдаа энэ бодлогыг “Вашингтоны Зөвшилцөөн” буюу “нолиберал”, эсвэл “зах зээлийн фундаменталист” гэж нэрлэх нь бий)-д голлох анхаарал хандуулсан олон оролцогч, өргөн хүрээг хамарсан “хөгжлийн зохистой орчин”-г бий болгох явдал гэж өргөжүүлэн тодорхойлсон юм.

Ийнхүү өөрчлөгдсөөр ирсэн Банкны зорилго нь бүтцийн өөрчлөлтүүд болон өндөр өртөгтэй дэд бүтэц бий шүүмжлэлийг даван туулж чадсан юм. Бүтцийн өөрчлөлт явуулах нь ядуучуудын амьдралд ихээхэн хүнд тусдаг,

өндөр өртөг бүхий дэд бүтцийн төслүүд нь хүрээлэн буй орчинд муугаар нөлөөлдөг гэсэн шүүмжлэлүүд одоо ч гарсаар байна.

Банкнаас олгож байгаа зээл нь байгаль орчин болоод нийгэмд хохирол учруулж байна гэсэн шүүмжлэлийн хариуд Банкны зүгээс тодорхой бодлогуудыг боловсруулан хэрэгжүүлж эхэлжээ. (Дор дэлгэрэрэнгүй өгүүлэх болно) Мөн Банк авилгын асуудалд анхаарлаа хандуулах болсон байна. Түүнчлэн, ихээхэн хэмжээний өр төлбөрийн дарамтад байгаа, хөгжил нь удаашралтай улс орнуудын өр, төлбөрийн дарамтыг багасгах талаар ч анхаарч эхэлжээ. Уг зорилгодоо хүрэхийн тулд Их хэмжээний өрийн дарамтад байгаа ядуу улс орнуудад туслах санаачлагыг өрнүүлэн ажиллаж эхэлжээ. (Highly Indebted Poor Country Initiative)

Гэсэн хэдий ч бодлогын аливаа өөрчлөлт бүхэн ямарваа нэг маргаанаас ангид явагдаж байсангүй. Банкнийг хөгжиж буй улс орнуудад шийдвэр гаргах аливаа үйл явцад дуу хоолойтой оролцох боломжийг олгодог, энэ тал дээр харьцангуй дадлага туршлагатай, зээл олгохоосоо илүү тусламж олгодог байгууллага байх ёстой гэж зарим нь шүүмжилдэг. Нэгдсэн Үндэстний Байгууллага түүний салбар байгууллагуудын гүйцэтгэх ёстой үүргийг Банк булаан авч гүйцэтгэж байна гэсэн шүүмжлэл мөн байдаг бол нөгөө нэг хэсэг шүүмжлэгчид Банкны ядуучууд руу чиглэсэн нийгмийн талын бодлогыг үр дүн муутай гэж үздэг. Гэтэл өөр нэг хэсэг нь Банкны зорилго, үйл ажиллагаа нь огт тодорхойгүй байна хэмжээн шүүмжлэх нь бас бий.

1997-1999 оны хооронд үргэлжилсэн Дэлхийн санхүүгийн хямралын улмаас Банкны зүгээс нийгмийн салбарт олгодог зээлийн хэмжээ үлэмж хэмжээгээр буурсан ажээ.

АНУ болон бусад олон улсын шахалт, ОУВС-ийн батлан даалттайгаар Банк Өмнөд Солонгос, Тайланд, Индонези болон Бразилд ихээхэн хэмжээний зээл олгосон байна. (Энэ хугацаанд Банк ОУВС-аас явуулж байсан олон бодлогыг шүүмжилж байсан юм. Тухайлбал, ОУВС-ийн улс орнуудад богино хугацааны хөрөнгө оруулалтад улсаа нээлттэй болгохыг шаардаж байсан байр суурь г.м. ОУВС-ийн зүгээс Банкны зарим нэг саналыг л харгалзан үзсэн мэт байдаг)

Санхүүжүүлэгч, зөвлөгч байгууллагын үүргийг гүйцэтгэх явцдаа Банк нь зээлдэгч болон зээлдүүлэгч улс орнууд, дотоодын бизнес эрхлэгчид, гадаадын

хөрөнгө оруулагчдын хоорондын яриа хэлэлцээг зуучилдаг зохион байгуулагчийн үүргийг гүйцэтгэдэг болжээ. Тухайлбал, баян улс орнууд, олон улсын байгууллагуудаас зохион байгуулдаг донор улсууд болон байгууллагуудын ээлжилт чуулга уулзалт дээр Дэлхийн Банк даргалагчийн үүрэгтэйгээр оролцдог. (Бусад зарим улс оронд энэ үүргийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр гүйцэтгэдэг /UNDP/)

Ийнхүү Банк ихээхэн нөлөө бүхий эрх мэдлийг өөртөө төвлөрүүлсэн байгууллага болж чадсан аж. Харин энэхүү нөлөө бүхий байдал нь Банкны баян гишүүдийн байр суурь, зээлдэгч нарын улс төр, санхүүгийн тогтвортой байдал, ОУВС-ийн зүгээс тухайн нэг улсад хэрэгжүүлж буй бодлогоос ихээхэн хамааралтай байдаг.

Дээр өгүүлсэнчлэн, сэтгүүлчид Дэлхийн банкийг аль талаас нь харуулах сонирхолтой байгаагаас үл хамааран уг байгууллагын үйл ажиллагаатай танилцах боломжтой байх ёстой. Хэдийгээр Банк ОУВС (нэгэн цагт Тагнуулын төв газраас ч нууцлагдмал байгууллага гэж яригддаг байсан)-г бодвол харьцангуй нээлттэй байгууллага гэж тооцогддог ч, шүүмжлэгч нар уг байгууллага юу хийдэг, ажлаа хэрхэн явуулдаг тухай мэдээлэл авах бусдын эрхийг хүлээн зөвшөөрдөггүй хэмээдэг. Одоо уг байгууллагын удирдлагын хэлбэр болон бүтэц зохион байгуулалтын тухай зарим ерөнхий зүйлсийг дор өгүүлье.

Засаглал-хэн юуг хянадаг вэ?

Дэлхийн Банк НҮБ - тай адил гишүүнчлэлтэй биш бөгөөд 184 улс орон хувьцааг нь эзэмшдэг олон улсын санхүүгийн байгууллага юм. Тухайн нэг улс орны эзэмших хувьцааны хэмжээ, шийдвэр гаргахад тооцогдох саналын тоо нь уг улс гишүүн болохдоо барьцаа болгон оруулсан Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хэмжээгээр тодорхойлогддог. Улс бүрийн хувьд захиалж болох хувьцаанд нь хязгаар тогтоосон байдаг. Олон улс орон, тухайлбал Хятад улс, Банкинд эзэмшдэг өөрийн хувьцаагаа нэмэгдүүлж саналын тоогоо өсгөхийг хүсч байсан боловч энэ нь бусад орнын саналын тоог бууруулах учир Банк зөвшөөрөөгүй аж. Хувьцааны захиалга, түүнтэй холбоотой саналын тоо нь улс орнуудын эдийн засгийн хүчин чадлаас шалтгаалах ёстой байтал ийм байдал үүссэн нь зөрөлдөөн гарах шалтгаан болсон байна.

“I хэсгийн” буюу баян улс орнууд Банкны нийт хувьцаа эзэмшигчдийн 14% хувийг эзэлдэг боловч саналын 62%-ийг хянадаг байна. Зээлдэгч улс орнууд буюу “II хэсгийн” улс орнууд нь нийт хувьцаа эзэмшигчдийн 86 % -ийг эзэлдэг боловч нийт саналын 38 %-ийг л эзэмшдэг байна. АНУ бол хамгийн том хувьцаа эзэмшигч бөгөөд заншил ёсоор Банкны Ерөнхийлөгчийг томилсоор иржээ.

Банкнаас зээл олгох зориулалтаар олгож байгаа хөрөнгийн ихээхэн хэсгийг олон улсын санхүүгийн зах зээл дээр бонд худалдах замаар олсон орлого бүрдүүлдэг. Ингэхдээ Банк нь хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг барьцаа болгон ашиглаж найдвартай зээлдэгч байж чаддаг учир маш тааламжтай нөхцөл бүхий эргэж төлөгдөх зээлийн хөрөнгийг төвлөрүүлж чаддаг. Хөрөнгө оруулагчдаас төвлөрүүлсэн энэ хөрөнгөө Банк бусад улс оронд илүү өндөр хүүтэйгээр зээл олгох замаар ажилладаг. Зээлдэгч улс орнууд зээлийг эргүүлэн төлөхөд Банк өөрийн авсан зээлийг төлж хүүгийн орлогоо хуримтлуулах замаар мөнгөн хөрөнгөтэй болдог.

Дунд орлого бүхий хөгжингүй улс орнууд Банктай зээлийн хоршоо хэлбэрээр харьцаар иржээ. Өндөр орлоготой улс орнууд Банкны зээлийн үйл ажиллагааг бага орлоготой улс орнуудыг дэмжих, бодлогын зөвлөгөө өгөхөд гол анхаарлаа чиглүүлэх зэргээр Банкыг удирддагт тэдгээр дунд орлого бүхий зээлдэгч улс орнууд таагүй хандах явдал гардаг байжээ (Дунд орлого бүхий зарим улс орон олон улсын хөрөнгийн зах зээлээс Банкнаас олгодог зээлийн нөхцлөөс харьцангуй тааламжтай нөхцлөөр зээл авах боломжтой байдаг).

Ийнхүү санхүүгийн чадварын хувьд харьцангуй боломжтой улс орнууд Банкнаас олгодог хөнгөлөлттэй зээлийн шалгуурыг хангахгүйн улмаас зээл авч чаддаггүй байдал нь Банк цаашид зээлийн хоршоо хэлбэрээр үйл ажиллагаа явуулах ёстой юу, эсвэл хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн улс орнуудын өр төлбөрийг уучилдаг хэвээрээ байх уу гэдэг асуулт зүй ёсоор гарч иржээ.

Банкны хувьцаа эзэмшигчдийн төлөөлөгчид энэ зөрчилдөөнтэй байдлыг хүлээн зөвшөөрч ойлгож байгаа юм. Банкны хувьцаа эзэмшдэг бүх улс орны санхүү, хөгжил буюу төлөвлөгөөний асуудал хариуцсан сайд нараас бүрэлдсэн Банкны Удирдах зөвлөл жилд хоёр удаа чуулж Банкны үйл ажиллагааг хэлэлцэж ерөнхий

бодлого, нэн тэргүүний зорилтуудыг тогтоодог. Удирдах зөвлөлийн гишүүд нь Банкны үйл ажиллагааны эцсийн үр дүнг хариуцаж ажилладаг.

Гэсэн хэдий ч Банкны Гүйцэтгэх удирдлагыг

24 гишүүнтэй Гүйцэтгэх захирлуудын зөвлөл хэрэгжүүлдэг. Уг зөвлөл нь бүрэн бүрэлдэхүүнээрээ долоо хоногт нэгээс хоёр удаа хуралдаж Банкнаас олгож байгаа бүхий л зээлийг хэлэлцэн баталдаг. Түүнээс жижиг нэгжүүд болох хороод нь бараг өдөр бүр хуралддаг. Банкны томоохон хувьцаа эзэмшигчид өөрийн Гүйцэтгэх захиралтай байдаг. Харин харьцангуй жижиг хувьцаа эзэмшигчид бүлгүүд байгуулж гол төлөв хоёр жил тутам Гүйцэтгэх захирлыг ээлжлэн томилдог ажээ. Тухайлбал Африкийн 47 улс 2 Гүйцэтгэх захирлыг томилох эрхтэй байдаг. Ийм бүлэг нь төлөөлж байгаа нийт эсвэл зарим улсуудын хүмүүсээс бүрдсэн ажиллагсадтай байдаг.

Гүйцэтгэх захирлууд нь хувьцаа эзэмшигч улсуудаа төлөөлж ажиллахын зэрэгцээ Банкны орон тооны ажиллагсад байдаг бөгөөд Банк цалин, байр болон нарийн бичгийн дарга нараар хангадаг. Банкны Ерөнхийлөгч удирдах зөвлөлийн хуралдааныг даргалдаг.

Дээр өгүүлсэн хуралдааны тоо олон, эсвэл цөөн байгааг ойлгохын тулд нэгэн харьцуулалт хийе. НҮБ-ын агентлагуудын гүйцэтгэх зөвлөлийн гишүүд жилд нэгээс дөрвөн удаа хуралддаг бөгөөд агентлагаасаа цалинждаггүй.

Гүйцэтгэх захирлуудын үүргийн тухайд маргаантай зарим нэг асуудал бий. Энэ нь зээлдэгч улс орнуудын шийдвэр гаргахад оролцох санал нь Банкинд эзэмшдэг хувьцааны хувь хэмжээгээр тодорхойлогддог мөн Гүйцэтгэх захирлууд нь цалин, бусад хангамжаараа Банкнаас хамааралтай болж болох тухай болгоомжлол юм.

Банк тэдгээрийн бүрэн эрхийг нь дуусгавар болгож албан тушаалаас нь чөлөөлж чадах учир түүний бодлогыг тэр бүр эсэргүүцдэггүй байх гэсэн болгоомжлол хүмүүсийн дунд байдаг. Банкны ахлах мэргэжилтнүүдийн хувьд Банкны менежерүүдтэй байнгын ажлын холбоотой байх бөгөөд Удирдах зөвлөлийн гишүүдээс доогуур түвшингийн албан тушаалтнуудаас бүрдэнэ. Харин Банкны Ерөнхийлөгч, гүйцэтгэх удирдлагууд нь зээлдэгч улс орнуудын ерөнхийлөгчид, ерөнхий сайдуудтай шууд харьцах сонирхол илүүтэй байдаг.

Гэсэн хэдий ч Хятад буюу Энэтхэг зэрэг томоохон зээлдүүлэгч улс орнуудын гүйцэтгэх захирлууд “I хэсгийн” орнуудын төлөөлөгчид болох гүйцэтгэх захирлуудын зүгээс гаргасан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөний тухай болон бусад эсэргүүцлийг даван туулж улсдаа зээл олгуулж чадсан байдаг. “I хэсэг”-т хамаарах улс орнуудын хууль тогтоогчид болон засгийн газрын комиссууд нь эдгээр асуудлыг лобби хийхээр оролдож байгаа корпорациудын шаардлага, байгаль орчныг хамгаалах байгууллага, бусад олон нийтийн идэвхтэн байгууллагын шахалттай уялдуулан шийдвэрээ гаргаж байдаг.

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ- НЭРНИЙ УЧИР

1. Бидний Дэлхийн Банк гэж дууддаг энэ байгууллагыг Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк гэж нэрлэдэг. 1945 онд анх байгуулагдсан энэ нэгж Дэлхийн Банкны Группын гол цөм болсон байгууллага нь юм. Уг байгууллага нь зээлийг зах зээлийн хүүгийн түвшинтэй ойролцоо хүүтэйгээр 15-20 жилийн хугацаанд эргэж төлөгдөх нөхцөлтэйгөөр өгдөг.
2. Олон улсын хөгжлийн ассосиаци буюу ОУХА нь 1960 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Банкны хамгийн ядуу гишүүдэд хөнгөлөлттэй зээлийг олгож ажилладаг үндсэн нэгж юм. Энэ байгууллагаас олгодог зээл нь хүүгүй (зээлийн дүн дээр 0.75 хувийн захиргааны зардал нэмэгддэг) 10 жил сунгагдах хугацаатайгаар 35-40 жилийн хугацаанд эргэж төлөгдөх нөхцөлтэй байдаг. ОУХА-г ОУСБХБ-тай харьцуулбал үйл ажиллагааны хувьд төдийлөн их ялгаагүй юм. Энэ байгууллагыг “хөнгөлөлттэй зээлийн цонх” гэж нэрлэх нь цөөнгүй тохиолддог.

ОУХА-аас олгож байгаа зээл нь тэтгэлгийн чанартай байдаг учир 3 жил тутам дараагийн зээлүүдийг олгоход шаардагдах мөнгөн хөрөнгө хуримтлагдах ёстой болдог. Энэ зээл нь хөрөнгө оруулалтын зардлаас илүү өндөр хүүтэй олгодог ОУСБХБ-ны зээлээс ялгаатай юм. Зарим улс орны парламент ОУХА-ийн төсвийг хэлэлцэн баталдаг. АНУ-ын Конгрессийн хувьд, лоббигийн болон бусад бүлэглэлүүд Банкнаас тодорхой төслүүдийг хэрэгжүүлэхийг шаардан түүний шийдвэрт нөлөөлөхийг оролддог.

3. Олон улсын санхүүгийн корпораци буюу ОУСК нь 1956 онд байгуулагдсан Банкны зээлдэгч орнуудын хувийн секторт хөрөнгө оруулалт хийх үндсэн зорилготой байгууллага юм. Энэ байгууллагын гишүүдийн тоо нь Банкны хувьцаа эзэмшигчдийн тоогоор хязгаарлагдсан байдаг. ОУСК нь зарим талаараа ердийн хөрөнгө оруулалтын банктай төстэй ажиллаад зогсохгүй зээлээс гадна хувьцаа худалдаж авах замаар хөрөнгө оруулалт хийдэг.
4. Олон улсын хөрөнгө оруулалтыг баталгуужуулах агентлаг буюу ОУХОБА нь 1988 онд байгуулагджээ. Энэ байгууллага нь Банкны зээлдэгч улсуудад шууд хөрөнгө оруулалт хийж байгаа гадаадын компаниудад улс төрийн эрсдэлийн эсрэг баталгаа гаргаж өгдөг. ОУХОБА -ыг байгуулах шаардлага нь хөгжиж буй улс орнуудад оруулах хөрөнгө оруулалтын эрсдэлтэй холбоотой юм. ОУХОБА нь Засгийн газрын зүгээс валют шилжүүлэхэд тавих аливаа хязгаарлалт, дайн болон бусад иргэний мөргөлдөөн, гэрээний үүргийг зөрчих зэрэг эрсдлийн эсрэг баталгаа гаргаж өгдөг. Зөвхөн Банкны хувьцаа эзэмшигчид л ОУХОБА-ын бүрэлдэхүүнд багтсан байдаг
5. Дэлхийн банкны институт нь Банк өөртөө болон үйлчлүүлэгчддээ зориулан сургалт зохион байгуулж судалгаа хэвлэн гаргадаг байгууллага юм. Энэ байгууллага нь Банкнаас санхүүжиж байгаа төслүүдийн талаарх мэдээллийн чухал эх сурвалж болох төдийгүй зээлдэгч улс орнуудын байгууллагын албан хаагчид, сэтгүүлчдэд зориулсан сургалт явуулдаг. Гэхдээ Банкны нөлөө бүхий судалгааны төвүүд нь Ахлах эдийн засагчдын газар, Судалгааны газар хоёр юм. Энэ 2 газар нь өөрийн вэбсайттай бөгөөд түүнээс Банкны үйл ажиллагаа, бодлогын хандлагыг олж мэдэж болно. (Доорх хаягийг үз)

Мөн банкны бүрэлдэхүүнд гадаадын хөрөнгө оруулагч, тухайн засгийн газар хоорондын маргааныг шийдвэрлэх олон улсын эрх бүхий Олон улсын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх хүрээлэн буюу ОУХОМШХ ажилладаг. Уг байгууллага 1966 онд байгуулагджээ. Жишээлбэл, Betchel Group Боливи улсын эсрэг тус улсад дотоодын хямрал, тэмцлийн улмаас орон нутгийн усны компанийн хувьчлал хүчингүйд тооцогдож, Betchel-н охин компанийн хөрөнгө оруулалтад аюул учруулсантай нь холбогдуулан маргаан үүсгэжээ.

Түүнчлэн Дэлхийн банкны бүрэлдэхүүнд хандивлагч улс орнуудын бүлгүүд, санхүүжүүлэгч байгууллагууд, судалгааны төвүүд ажилладаг. Банк эдгээр байгууллагуудад нөлөөтэй байдаг ч үйл ажиллагааны үр дүнг нь хариуцдаггүй. Хөдөө аж ахуйн судлалын зөвлөгөө өгөх бүлэг (GGIAR) болон Нэн ядуу орнуудад туслах, зөвлөгөө өгөх бүлэг (GGAP) зэрэг жижиг зээл болон жижиг аж ахуй дэмжих хөтөлбөрүүд нь дээрх байгууллагуудын эрхлэх ажлын хүрээнд багтдаг.

Хүнд суртлын тогтолцоо

Хэн юу хийдэг вэ?

Дэлхийн Банкны группын бүх байгууллагууд, түүний дотор ОУСБХБ-нь хэвлэл мэдээллийн ажилтнуудтай байдаг. Гэхдээ мэдээллийн сонирхолтой эх сурвалж, үйл явдлууд олон нийтэд тэр бүр хүртээлтэй байж чаддаггүй. Эдгээр байгууллагууд нь:

- ОУСБХБ -ийн Үйл ажиллагааны үнэлгээний газар (Operations Evaluation Department) Энэ нэгж Банкнаас хэрэгжүүлсэн хөтөлбөр болон төслүүдийн үр дүнд дүн шинжилгээ хийдэг. Мөн бодлогын өөрчлөлт, стратеги, үйл ажиллагааны талаар олж тогтоосон зүйл, зөвлөмжүүдийг гүйцэтгэх зөвлөлд танилцуулдаг. Сурвалжлагчид, тухайлбал Банкнаас хэрэгжүүлсэн уул уурхайн төслүүд ядуучуудад тус болж чадсан эсэх талаар мэдээллийг ОУСБХБ-ын бэлтгэсэн тайлангаас авч болно. Гэхдээ энэ нэгж гол анхаарлаа хөгжлийн үр дүнгээс илүү өөрийнхөө үйл ажиллагаанд чиглүүлдэг.
- Банкны Хяналтын Зөвлөл (Inspection Panel) нь Банкны зүгээс хэрэгжүүлсэн төслүүд хэрхэн үр дүнгүй болсон тухай, тийнхүү бүтэлгүйтсэний үр дагаварыг арилгах талаар юу хийж байгаа талаар мэдээллийг олж авах гол газар юм. Энэ байгууллага харьцангуй хараат бус статустай бөгөөд Банкнаас хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төслүүдтэй холбоотой аливаа зөрчлийн талаар гомдлыг (байгаль орчны хамгаалалт, олон нийт болон уугуул хүмүүстэй холбоотой асуудлууд) хүлээн авдаг. Тухайлбал, хяналтын энэ нэгж нь 1994 онд байгуулагдан Энэтхэгийн Нармада гол дээр барих Sardar Sarma-da даланг барих төслийн ажил тухайн бүс нутгийн хүмүүсийн эсэргүүцэлтэй тулгарч маргаан үүссэнийг шийдвэрлэсэн бөгөөд уг маргааны дараа Банк төслөө зогсоожээ.

Зарим шүүмжлэгчид Банкны зүгээс Хяналтын зөвлөлийн эрхийг өргөжүүлж төслүүдийг шууд зогсоох шийдвэр гаргах эрхтэй болгохыг шаарддаг. Мөн энэ нэгжийн эрх хэмжээг Банк ихээхэн хязгаарласан гэж үздэг аж.

Эрх зүйн бүрэн бус орчин, Банк болон засгийн газруудын нөлөөллийн доор энэхүү зөвлөл аливаа нэг мэдээллийг гадагш алдахгүйн тулд туйлын болгоомжтой ажилладаг. Зөвлөлөөс гаргасан тайлангууд нь олон нийтэд цацагддаг боловч олон нийтийн байгууллагуудын хэдийн мэдэж байсан зүйлс байх нь олонтаа тохиолддог.

Тухайлбал, EххonMobil-ийн удирдан хэрэгжүүлсэн Чад-Камеруны газрын тос үйлдвэрлэх, түгээх төсөл; Аргентин-Парагвай улсуудын Yасугета далан барих; Хятад улсад хэрэгжүүлсэн Төвд орчмын хөгжлийн хөтөлбөрүүд нь улс төрийн хүрээнийхнийг хамарч томоохон мөрдөн шалгах ажиллагаа явагдсан хэргүүд байсан юм.

- Залилан, Авилгын эсрэг нэгж (Fraud and Corruption Unit) нь мөрдөн байцаагч байсан хүмүүсээс бүрддэг бөгөөд Банкны ажиллагсад, Банктай ажил хэргийн харилцаатай компаниудтай холбогдол бүхий хэргүүдийг мөрдөн шалгадаг.
- Магадгүй дээр дурдсан бүх нэгжээс хамгийн чухал нь Хөгжлийн үр дүнг дүгнэх хороо байж болох юм. Энэ нэгж нь Үйл ажиллагаанд үнэлгээ өгөх газрын тайланг хүлээн авах, Банкны үйл ажиллагаа, стратеги, үнэлгээтэй холбоотой асуудлуудыг хариуцдаг.
- Банкны дээд удирдлагад багтах албан тушаалтнууд Үйл ажиллагааны бодлогын хороогоор дамжуулан Удирдах зөвлөлд зөвлөмж гаргах боломжтой байдаг.
- Удирдах зөвлөлөөс баталсан ямар ч бодлого буюу хэрэгжүүлэх стратегийн биелэлтийг Үйл ажиллагааны бодлогын газар, Улс орнуудын туслалцаа үзүүлэх газар хариуцдаг. Энэ нь банкны доторх хамгийн эрх мэдэлтэй газруудын нэг юм.

УЛС ХАРИУЦСАН ГАЗРУУДЫН БҮТЭЦ

Дэлхийн Банк нь тухайн бүс нутаг, салбарт өөрийн төлөөлөгчдийн сүлжээ бүхий зохион байгуулалттай байгууллага юм. (Дэлхийн хөгжиж буй орнуудыг 6 бүс болгон хуваадаг) Банк өөрийн ажиллагсадаа үндсэн дөрвөн сүлжээ хэсгүүд болгон зохион байгуулдаг. Эдгээрт: Байгаль орчинд ээлтэй нийгмийн баримжаатай

тогтвортой хөгжил; Санхүү, Хувийн хэвшил болон дэд бүтэц; Хүний хөгжил; Ядуурлыг бууруулах ба эдийн засгийн удирдлага зэрэг багтаж байдаг.

Вольфансоны өгүүлсэнээс үзвэл, Банк өөрийн ажиллагсдын дийлэнхийг нь бүс нутгууд буюу зээлдэгч улс орнуудад ажиллуулдаг ажээ. Зарим бүс нутгийг хариуцсан захирлууд, Банкны удирдлага болон салбар хариуцсан гол албан тушаалтнууд нь Вашингтонд ажилладаг байна.

Банкны удирдах төв байгууллагад ажиллаж байгаад бүс нутагт томилогддог мэргэжилтнүүд нь тодорхой асуудлуудын талаар өргөн мэдлэгтэй байдаг. Тухайлбал, Банкнаас баталсан журмууд, боловсрол буюу усны менежментийн талаар, Банк уг асуудлуудыг бодлогын түвшинд хэрхэн шийдвэрлэдэг талаар өргөн мэдлэгтэй байдаг. Мөн тэд олон улс, бүс нутгуудад ажилласан туршлагатай байдаг.

Улс хариуцсан газар нь бодлого хэрэгжүүлдэг нэгж юм. Банк нь зээлдэгчтэй хамтран тухайн улсад туслах төлөвлөгөө буюу “Мастер төлөвлөгөө”-г батлан гаргадаг.

Улс хариуцсан газар нь ерөнхийдөө дараахь үндсэн бүтэцтэй байдаг. Үүнд:

1. Улс хариуцсан захирал: Нэгээс зургаа хүртэл тооны Улс хариуцсан газруудыг хариуцдаг.
2. Суурин төлөөлөгч: Улс хариуцсан захирал Вашингтонд ажилладаг бол тухайн улсад байрлах суурин төлөөлөгчийн газрыг тэргүүлдэг.
3. Улс хариуцсан зохицуулагч: Улс хариуцсан захирал зээлдэгч улсад суурин ажилладаг бол зохицуулагч нь Банкны төв байранд байрлаж ажилладаг.
4. Улс хариуцсан эдийн засагч: Тухайн улсад тусламж үзүүлэх стратегийг хэрэгжүүлэх, зохицуулах ажлыг эрхэлдэг.
5. Төрийн бус байгууллага/Иргэний нийгэм хариуцсан мэргэжилтэн: тухайн орны иргэний нийгмийн төлөөлөгчидтэй холбоотой ажилладаг.
6. Улс хариуцсан мэргэжилтэн: Тухайн улсад олгосон зээлийн удирдлагыг хэрэгжүүлдэг.
7. Салбарын тэргүүн/мэргэжилтнүүд: Банкнаас хэрэгжүүлэх бодлогын хүрээнд төслүүдийг шалгаруулдаг (байгаль орчин, эрүүл мэнд буюу орон нутгийн хөгжил)

8. Багийн тэргүүнүүд: Тухайн нэг төслийг удирддаг (далан, хот хоорондын зам барих г.м.)
9. Олон нийтийн мэдээлэл хариуцсан мэргэжилтэн: Олон нийтийн мэдээллийн төвийн үйл ажиллагааг удирддаг.
10. Улс хариуцсан газарын бүрэлдэхүүнд хуулийн зөвлөх, үйл ажиллагааны шинжээч, хөтөлбөрийн ажилтнууд, төлбөр тооцооны мэргэжилтнүүд, санхүүгийн удирдлагын мэргэжилтнүүд, Олон улсын санхүүгийн корпорацийн төлөөлөгчид, нягтлан бодогчид зэрэг орсон байж болно.

БАНКНААС ХЭРЭГЖҮҮЛДЭГ ТӨСЛҮҮДИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ ТУХАЙ

Банкны зээлийн дийлэнх хэсгийг тодорхой төслүүдэд олгодог (бүтцийн өөрчлөлтөд зориулагдсан зээлээс бусад бүх зээл) Энэ нь тухайлбал, зөвхөн ганц далан барих төсөл байдаггүй, харин “эрүүл мэндийн салбарыг шинэчлэх ” г.м.өргөн хүрээнд хэрэгждэг.

Төслийг дараахь үндсэн шатаар боловсруулдаг (Мэдээллийн эх сурвалж):

1. Төслийг тодорхойлох: Банк болон тухайн улсын засгийн газар төслийн саналыг гаргана. Улмаар төслийн баг “Төслийн мэдээллийн баримт, материалуудыг бэлтгэдэг бөгөөд тэдгээр нь олон нийтэд нээлттэй байх ёстой. Банкны Улс хариуцсан газар нь уг төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлно. (Энэ шатанд мэдээлэл авч болох гол эх сурвалжууд: Дэлхийн банкны Улс хариуцсан газар, Яамд/Агентлагууд, Төслийн баг/багийн тэргүүн)
2. Төслийн бэлтгэл ажил: Засгийн газар, Банкны зөвлөхүүд нь эдийн засгийн болон бусад судалгаануудыг цуглуулж, техникийн тоо баримт бүхий баримт бичгийг бэлтгэдэг бөгөөд сэтгүүлчид тэдгээр баримт бичгүүдийг олж үзэж болох юм. Энэ ажиллагаа нь олон нийтийн хэлэлцүүлэг, оролцоог аль болох хангах ёстой байдаг. (Мэдээллийн гол эх сурвалжууд: Засгийн газрын агентлагууд, Зөвлөхүүд, Төслийн баг/багийн тэргүүн)
3. Үнэлгээ: Энэ шатанд Банкны үнэлгээний баг төсөлтэй танилцаж, засгийн газрын холбогдох албан

тушаалтнуудтай уулзалт зохион байгуулан төсөлд үнэлгээ өгдөг. Улмаар Банкны мэргэжилтнүүд Төслийн Үнэлгээний Баримт бичгийг (Үнэлгээний тайлан ч гэж нэрлэдэг) бүрдүүлж Банкны гүйцэтгэх захирлуудад батлуулахаар хүргүүлдэг. Энэ баримт нь Вашингтон дахь мэдээллийн албаар дамжин олон нийтэд хүрдэг байна. (Мэдээллийн гол эх сурвалжууд: Үнэлгээний баг (ажлын хэсгийн ахлагч, зөвлөхүүд багтсан байна)

4. Хэлэлцээр: Энэ шатанд Банк, тухайн улсын Засгийн газар төслийн хүрээнд олгох зээлийн нөхцлүүдийн талаар зөвшилцдөг. Банкны хуулийн хэлтэс шаардлагатай бүхий л бичиг баримтыг бэлтгэж боловсруулдаг. (Мэдээллийн гол эх сурвалжууд: Ажлын хэсгийн ахлагч, Улс хариуцсан захирал, Банкны хуулийн зөвлөх, тухайн улсын засгийн газрын холбогдох яамд/агентлагуудын хэлэлцээ хийх талууд, зээлдэгч улсын Сангийн яам)
5. Төслийг батлах: Энэ шатанд банкны гүйцэтгэх захирлууд төслийг хэлэлцэж, улмаар төсөл батлагдсан тохиолдолд Банк болон зээлдэгч тухайн улсын засгийн газар хоёр зээлийн гэрээнд гарын үсэг зурдаг. (Мэдээллийн гол эх сурвалжууд: Банкны гүйцэтгэх захирлууд, Төслийн баг/Ажлын хэсгийн ахлагч буюу Улс хариуцсан захирал)
6. Төслийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих: Энэ шатанд зээлдэгч улсын засгийн газрын зүгээс төслийг хэрэгжүүлэх явцад Банк хяналт тавьж оролцдог. Банк төслийн хэрэгжилтийн байдалтай газар дээр нь мөн танилцдаг. (Мэдээллийн гол эх сурвалжууд: Зөвлөхүүд, Засгийн газрын агентлагууд, Банкны хяналт, шалгалтын баг, Ажлын хэсгийн ахлагч)
7. Төсөл хэрэгжсэний дараахь үнэлгээ: Зээлдэгч засгийн газар буюу Банк өөрөө Төслийн гүйцэтгэлийн тайланг Банкны гүйцэтгэх захирлуудад хүргүүлдэг. Банкны Үйл ажиллагааны үнэлгээний газар Төсөлд Аудит хийгдсэн тухай тайланг гүйцэтгэх захирлуудад зориулан бэлтгэдэг. (Мэдээллийн гол эх сурвалжууд: Ажлын хэсгийн ахлагч, төслийн ажиллагсад, Үйл ажиллагаа болон Үнэлгээний газар, гүйцэтгэх захирлууд)

Дэлхийн банкны вэбсайт ихээхэн хэмжээний мэдээллийг агуулж байдаг. Мөн Банкны үйл ажиллагааны тухай тоймыг багтаасан сар тутмын товхимол гардаг

бөгөөд шинэ, хэлэлцэгдэж байгаа зээлүүдийн тухай мэдээллийг тусгасан байдаг.

Банкнаас хэрэгжүүлэх аливаа төсөл маргаантай байх нь бас бий. Учир нь Банкнаас олгож буй санхүүжилттэй янз бүрийн бодлого уялдаатай байдаг. Зарим шүүмжлэгч нар өрнөдийн улс орнуудын засгийн газрын зүгээс учруулж байгаа дарамтын улмаас зээлдэгч улсуудын засгийн газар өөрийн улсын ашиг сонирхолд нийцсэн бус, харин тэдгээр баян орнуудын ашиг сонирхолд нийцсэн бодлого барихад хүрдэгийг шүүмжлэх нь бий. (Тухайлбал, Дэлхийн Банк болон Олон улсын валютын сан нь анхан шатны боловсролын зардлыг нөхөх, өөрөөр хэлбэл ядуу хүмүүс сургуульд явсныхаа төлөө төлбөр төлдөг болгохыг зарим улсын засгийн газраас шаардаж байжээ. Эдгээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлсний дараа Уганда болон бусад улсад сургуулийн төлбөрийн хэмжээ өчүүхэн бага байсан ч эцэг, эхчүүд хүүхдүүдээ, тэр дундаа охидоо сургуульд явуулахаас татгалзаж эхэлжээ) Харин Дэлхийн Банкны судалгаануудаар тухайн улсын идэвхи, оролцоо аливаа нэг төслийн амжилтад хамгийн их нөлөөлдөг гэдэг дүгнэлт гарсан хэвээр байна.

СЭТГҮҮЛЧДЭД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

- Гүйцэтгэх захирлууд болон тэдгээрийн Вашингтон хот дахь мэргэжилтнүүд, тэдний улс төрийн бүлэгт хамаарах хүмүүс, хянагч нар г.м. нь мэдээллийн эх сурвалж болно. Хэрэв та банкны бодлого, хувьцаа эзэмшигчид хоорондын харилцааны тухай сурвалжлах гэж байгаа бол дээрх эх сурвалжууд маш чухал юм. Мөн Банкинд тодорхой сонирхолтой парламентын гишүүд буюу хууль тогтоогчид мэдээллийн эх сурвалж болж болно. (Бразил, бусад зарим улс оронд Банктай гэрээ байгуулах асуудал нь засгийн газрын эрх хэмжээний асуудал уу, эсвэл парламентийн бүрэн эрхийн асуудал уу гэдэгтэй холбоотой Үндсэн хуулийн маргаанууд гарч байжээ)
- Төрийн бус байгууллагууд. Банкны бодлогыг дэмждэг, бодлогод нөлөөлөхийг (лобби) оролддог, эсвэл Банкны үйл ажиллагааг эсэргүүцдэг Төрийн бус байгууллагууд нь Банкны зарим албан тушаалтнуудтай холбоо тогтоосон байдаг. Мөн тэд төлөвлөгдөж байгаа лоббидох үйл ажиллагаа, Банкинд үзүүлэх шахалт, Банкны маргаан шийдвэрлэх зөвлөлийн шийдвэрлэх хэргүүдийн талаар мэдээллийг олж авсан байдаг. Тэдгээр төрийн бус байгууллагууд нь өөрийн дэмжигч нарт e-mail -ээр аливаа мэдээг захиалгын дагуу хүргэдэг. Мөн компаниуд, ажиглагчид банктай холбоотой аливаа асуудлаар хийх мэдээллийг сурвалжлагч нар байнга анхаарч байх шаардлагатай.

- Банк үйл ажиллагаа явуулж байгаа улсдаа хэнтэй гол төлөв харьцаж байгааг олж мэдэхийг хичээ. Банкны эрх бүхий хүмүүс тухайн улсад олон тооны хүмүүстэй уулзаж байна уу, эсвэл засгийн газрын цөөн тооны албан тушаалтнууд, компанийн удирдлагуудтай л уулзаж байна уу, Банк бодит мэдээллийг олж авч чадаж байна уу, эсвэл хүмүүс Банкны төлөөлөгчдийн сонсохыг хүссэн зүйлийг тэдэнд хэлж байна уу гэдгийг анхаарах нь чухал. Эдгээр асуултууд нь төсөл, түүний бодлогод нэгэн адил хамаарах бөгөөд тухайн Улсад туслалцаа үзүүлэх стратегид мөн хамаарна.
- Интернет болон бусад эх сурвалжийг ашигла. Үүнд: бусад сэтгүүлчидтэй шууд харилцаатай байж таны өөрийн улсдаа сурвалжилж байгаа зүйлсийг олон улсын хэмжээнд ямар хэлбэрээр мэдээлж байгааг олж үзэх хэрэгтэй. Ялангуяа та Банкны төв байранд боловсруулсан бодлогын үр дүн тухайн бүс нутагт хэр оновчтой бууж байгаа талаар бичиж байгаа бол таны хувьд энэ эх сурвалжууд нэн чухал. Олон улсын хэмжээний харьцуулалтууд хийх нь нийтлэлийг өргөн сэдэвтэй, зөвхөн тухайн бүс нутгийн тухай мэдээллээр хязгаарлагдаагүй, мэдээлэлтэй бусад сурвалжлагчдын байр суурь, аргыг хооронд нь харьцуулах боломжийг олгодог.
- Банкнаас хэрэгжүүлэх олон төслүүд нь тоног төхөөрөмж нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх гэрээнүүд байдаг. Төслийн гүйцэтгэгчийг сонгох уралдаант шалгаруулалтууд хэрхэн явагдаж байгааг анхааралдаа авах шаардлагатай. Гүйцэтгэгчийг хахуулиар сонгож байна уу, сонгон шалгаруулалтад оролцсон бусад компаниуд уг сонгон шалгаруулалт шударга, нээлттэй явагдаж байгаа гэж үзэж байгаа эсэхийг сонирхон үз.
- Засгийн газрын буюу Банкнаас хэрэгжүүлсэн Төслийн үр дүнг хүртэх ёстой хүмүүстэй ярилцахыг хичээ. Төслийн үр шимийг хэн хүртэж, хэн чадахгүй байна гэсэн асуултууд маш чухал.

МЭДЭЭЛЛИЙН ЛИНКУУД:

1. Дэлхийн банк
<http://www.worldbank.org>

(Энэ вэбсайтад зөвхөн сурвалжлагч нарт зориулсан булан бий бөгөөд нууц үгээр хамгаалагдсан хэсэгт нэвтэрч, e-mail—ээр мэдээлэл авахаар захиалга өгч болно.)
2. Дэлхийн банкны судалгаа
<http://econ.worldbank.org>
3. Олон улсын санхүүгийн корпораци
<http://www.ifc.org>
4. Олон улсын хөрөнгө оруулалтын баталгааны агентлаг
<http://www.miga.org>
5. Хөгжлийн гарц (Дэлхийн банкнаас бэлтгэсэн хөгжлийн асуудлын талаарх портал)
<http://www.developmentgateway.org>
6. Дэлхийн банкны Үйл ажиллагааны үнэлгээний газар
<http://www.worldbank.org/oed/>
7. Дэлхийн банкны хяналтын зөвлөл
<http://wbnl0018.worldbank.org/ipn/ipnweb.nsf>
8. Банкны мэдээллийн төв (Вашингтонд төвтэй олон нийтийн бүлэг бөгөөд идэвхтнүүд, хэвлэл мэдээлэл, судлаачдад үйлчлэх мэдээллийн төв; тодорхой төслүүд дээр ажиллах албан тушаалтнууд, дэмжигчдийн тухай гэх мэт мэдээллийг агуулсан байдаг; Линкүүд гэсэн хэсэг нь дэлхий даяар орших бүлгүүдийн тухай мэдээллийг агуулдаг)
<http://bicusa.org>
9. Бреттон Вудсийн төсөл (Лондонд төвтэй олон нийтийн идэвхтэй бүлэг бөгөөд улс төр, хүнд суртлыг анхааралдаа байлгаж төслүүдийг хөндлөнгөөс ажигладаг)
<http://www.brettonwoodsproject.org>

СЭТГҮҮЛ ЗҮЙГ ӨӨРИЙН БИЗНЕС БОЛГОХ

Грэхэм Ваттс

2002 оны хөл бөмбөгийн Дэлхийн цомын тэмцээний шигшээ тоглолтод Өмнөд Солонгос шалгарсан бол хэчнээн сэтгэл хөдөлгөсөн үйл явдал болох байсныг төсөөлөөд үз дээ. Нутагтаа уг тэмцээнийг явуулах зориг гаргасан, Азийн орнуудаас хамгийн түрүүнд ийм өндөр амжилтанд хүрсэн баг дэлхийн хамгийн шилдэг баг Бразилтай учирна. Ази тив Латин Америкийн эсрэг гэсэн үг. Хөл бөмбөгийг огт мэддэггүй хүмүүс ч ийм үйл явдалд баярлах биз.

Харин одоо бизнес сонинд энэ тухай хэрхэн бичсэн байхыг төсөөлөөрэй.

76 371 үзэгч, түүний дотор Олон улсын Хөл бөмбөгийн Холбооны ерөнхийлөгч эрхэмсэг ноён Жозеф Сепп Блаттер нар цугларсан Японы Йокогама Олон улсын цэнгэлдэх хүрээлэнд дөрвөн долоо хоног гаруйн хугацаанд явагдсан, 96 тоглолтод эх орноо төлөөлсөн нийт 637 тамирчин бүхий 32 баг оролцсон 2002 оны FIFA-ийн Дэлхийн цомын эцсийн ялагчийг тодруулахаар хагас шигшээ тоглолтоос амжилттай гарч ирсэн хоёр багийн хоорондын уулзалт боллоо.

Түрүүнд би таныг төсөөлөөд үз гэсэн шүү дээ. Тэгэхээр та төсөөлөх хэрэгтэй гэсэн үг. Яагаад гэвэл дээрх мэдээнээс аль баг нь ялсныг мэдэж авах аргагүй байна.

Яагаад бид мэдээг ингэж бичиж байнаа? Бид эдийн засаг, бизнесийн тухай бичихдээ бичиж байгаа зүйлийнхээ голыг яагаад орхиж байгаа юм бол? Бид өгүүлэлдээ гол үйл явдлаа нэгдүгээрт тавихаа мартжээ. Бидний бэлтгэсэн өгүүлэлд чухал биш баримтууд голлох ёсгүй гэдгийг мартсан байна. Бид мэдээгээ товч бөгөөд энгийн хэлээр бичсэн байх ёстойг мартжээ. Эцсийн эцэст бид бизнес санхүүгийн тухай бичиж байгаа хэдий ч энэ нь сэтгүүлзүй гэдгээ мартаж байна.

Үүнд мэдээж олон шалтгаан бий. Магадгүй хамгийн гол шалтгаан нь хөл бөмбөгийг эс тооцвол бид бичиж байгаа зүйлийнхээ тухай хангалтгүй мэдлэгтэй байна. Тэгээд бид яг юу болсныг бичихдээ ч, ямар нэр томъёо хэрэглэх вэ гэдэг дээр ч засгийн газрын албаны хүмүүс болон олон нийтийн харилцаа холбооны хэлтсүүдээс хамааралтай болдог. Төв банкны тухай “нээлттэй байр суурь” гэсэн нэр томъёог сонсоод уншигчдад ойлгомжтой болгохын тулд энгийн үг эрж өөрийгөө зовоохын оронд мэргэжлийн үг хэллэгийг хэрэглэх нь илүү амар байдаг. Ойлгомжгүй нэр томъёогоор бичсэн зүйлийг чинь танай дарга юм уу редактор уншаад “Хөөе, энэ чинь юу гэсэн үг юм бэ?” гэж асуухгүй. Дарга нар өөрсдийгөө юм мэддэггүй гэж харуулах дургүй шүү дээ. Тэгээд тэд ойлгомжгүй үгийг хэвээр нь орхиж, эцсийн үр дүнд уншигчид маань харанхуйд үлддэг.

Мэдээгээ хэт их тоо, техникийн үг хэллэгээр дүүргэж байгаагийн бас нэг шалтгаан бол бид бизнесийн мэдээ уншдаг хүмүүсийг энгийн хүмүүсээс ялгаатай бөгөөд маш их мэдээллийг боловсруулж чаддаг, мэргэжлийн үг хэллэг мэддэг гэж боддог. Заримдаа бид уншигчиддаа болон хамт ажилладаг хүмүүстээ мундаг үг хэрэглэж гайхуулах гэж оролддог. Би нэг удаа бизнесийн сонинд дараах гарчгийг уншсан: ADR ба GDR нь татварын бодлогоос шалтгаалдаг”. Үнэндээ би юун тухай гарчиг байсныг огт ойлгоогүй.

Өөр нэг шалтгаан бол бизнесийн сурвалжлагч байхад ганцаарддаг. Маш бага хэмжээний удирдамж зөвлөгөө, түүнээс ч бага дэмжлэг тусламж авдаг хэрнээ урьд өмнө нь огт дуулаагүй зүйл дундуур ганцаар явж ямар нэгэн мэдээ мэдээлэл бэлтгэх хэрэгтэй болдог. Зарим үед яах гэж ийм ажил хийж байгаагаа өөрөө ч гайхаж, улс төрийн эсвэл спортын сурвалжлагч нарт атаархан жинхэнэ ертөнцийн хэсэг болох юмсан гэж мөрөөддөг.

Гэвч санаагаар бүү унаарай. Таны бичиж байгаа ертөнц ч гэсэн жинхэнэ ертөнц. Энэ номын үлдсэн хэсгийг уншвал, нэгэнт уншиж амжаагүй бол яг одоо нэг зүйлийг мэдэж авна: бизнес, эдийн засгийн шийдвэрүүд ч амьдралын асуудлуудыг хамардаг. Зөвхөн хөл бөмбөгийн сурвалжлагч нар л өөрсдийнхөө мэдээг бизнес мэдээнээс илүү чухал гэж баталж чадах байх.

Зөв талаас нь хандах юм бол бид ч гэсэн өөрийн салбараа илүү сонирхолтой, өөртөө өгөөжтэй болгох төдийгүй бусад хүнээс огтхон ч ялгаагүй өөрийнхөө уншигчдаадаа хүртээлтэй, хэрэгтэй болгож чадна.

Уншигчид нь техникийн үг хэллэгүүд ямар утгатайг ойлгодог гэсэн итгэл санхүүгийн мэдээ бичдэг маш олон сэтгүүлчийн дунд байсаар байна. Үнэндээ бол уншигчид маань мэргэжлийн үг хэллэгийг ойлгодоггүй. Ихэнх уншигч санхүүгийн сонин сэтгүүлийг гүйлгэж хараад өнгөрдөг. Яг өөрсдийнхөө хийдэг ажилтай холбоотой хэсгийг уншаад үлдсэнийг нь цаг зав байсан ч огт уншдаггүй. Яагаад гэвэл тухайн хүн аж үйлдвэр, санхүү, засгийн газрын өндөр цалинтай ажилтан ч байлаа гэсэн нэг л зүйлд мэргэшсэн байдаг. Химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн сайн нягтлан бодогч хүн худалдааны бодлогод юу болж байгааг мэдэх онцын шаардлага байхгүй. Хөдөө аж ахуйн сайн эдийн засагч хүн тэтгэврийн сангаас мөнгийг нь хэрхэн хөрөнгө оруулж байгааг мэдэх шаардлага багатай. Жижиглэнгийн худалдааны менежер хүн гадаад арилжааны зах зээлүүд хэрхэн ажиллаж байгааг мэдэх албагүй.

Хэрвээ сэтгүүлчид бид уншигчиддаа мэддэггүй зүйлийг ойлгоход тус болох юм бол уншигчид маань улам ихийг уншиж, бидний хэвлэлийг илүү хэрэгцээтэй, баталгаатай болгож өгнө. Ингэснээр сэтгүүлчдэд ч, уншигчдад ч ашигтай болно.

Харин уншигчиддаа хэрхэн туслах вэ? Сэтгүүл зүйг өөрийн бизнес болгох замаар.

- Бичиж байгаа зүйлээ өөрийн болго. Бизнесийн сэтгүүлчдийн хийдэг хамгийн том алдаа бол тухайн зүйлийн тухай ганцхан эх сурвалжаас авсан мэдээндээ тулгуурладаг. Засгийн газрууд, компаниуд, төрийн бус байгууллагууд үй олон хэвлэлийн мэдээ (пресс релиз), бусад материал гаргадаг нь сонин хэвлэлд хүний гар бараг хүрэлгүйгээр хэвлэгддэг. Ийнхүү мэдээллийг хэвээр нь гаргаж буй сэтгүүлчид өөрсдөө ажлын таашаал авахгүй. Үүний оронд та авсан мэдээлээ өөрийн бичих гэж байгаа зүйлийн эхлэлийн цэг гэж ойлго. Өөр мэдээлэл, эх сурвалж, өнцөг хай, тэгснээр ямар нэг юманд хүрч бүтээсэн гэсэн мэдрэмж танд төрнө. Хэрвээ анх авсан мэдээлэл чинь нэмэлт судалгааны эцэст хуучин, сонирхолгүй, үр дүнгүй мэдээлэл болж хувирвал “Үүгээр өгүүлэл бичих хэрэггүй. Үүнд цагаа үрэх шаардлагагүй.” гэж хэлэх зоригтой бай. Тэгээд жинхэнэ сэдвээ ол.
- Асуудлын голыг ол. Илүү гүн утгатай бодит өгүүллийг бич. 24 цагийн турш телевизээр дамжуулдаг бизнесийн мэдээ, интернэтийн, эсвэл гар утсан дахь мэдээ гэх зэргийн хагас боловсруулсан, тулгуур

мэдээллийг даруйхан авч болох өнөө үед уншигчид яг юун тухай уншиж байгаагаа ойлгож байх нь чухал. Тэгэхээр бид бичиж байгаа зүйлийнхээ хамгийн гол утга учрыг нэгдүгээрт тавих хэрэгтэй.

- Та өөрөө таашаал ав. Ажлынхаа өрөөнөөс гар. Хэвлэлийн мэдээнд бичсэн хийсвэр зүйл бодитоор болж байгаа газар луу яваад бизнесийн шинж чанарыг нь алдалгүйгээр амьд мэдээ болго. Таны ажлаасаа авах таашаал эрс нэмэгдэхийг та өөрөө мэдрэх болно. Уншигчид таны өгүүллүүдэд дуртай болж, бичсэн асуудлыг чинь илүү сайн ойлгодог болно.
- Бодит хүмүүсийг оролцуул. Өгүүлэлээ илүү амьдралтай, олон өнгөтэй болгохын тулд сонирхолтой хүмүүсийн тухай бас бич. Уншигчид хүний сонирхлын тухай өгүүллүүдэд дуртай бөгөөд хүмүүсийн тухай унших дуртай гэдгийг бид бүгд мэднэ. Гэтэл бизнесийн сонин сэтгүүлд бичсэн хүмүүс саарал костюм өмссөн уйтгартай хүмүүс байдаг. Эсвэл хүмүүсийн тухай огт дурдахгүй өнгөрдөг.
- Асуудлаа өөрөө сайн ойлгож ав. Ингэснээр таны хувьд бичиж байгаа зүйл чинь амьтай болж ирнэ. Та өөрөө тухайн сэдвээ сонирхолгүй, ойлгомжгүй гэж бодож байгаа бол уншигчдад тань яг тиймээр хүрэх болно. Харин та зах зээлийн хөдөлгөөн, нууцлаг байдал, эдийн засгийн бодлогын нийгмийн үр дагаврыг ойлгож эхлэх юм бол та амьдрал ер нь хэрхэн явж байгааг илүү мэдэх болно. Бизнесийн ертөнцөд хамаагүй гэж бодож байсан улс төр, боловсрол, гэмт хэрэг, хууль гэх зэрэг сайхан амьдрал юм уу зовлон авчирч болдог бүхий л зүйлийг хооронд нь холбож сурна.
- Ойлгож авсан зүйлээ сайн тайлбарла. Харилцаа холбооны бизнесийн хамгийн сайхан мөч бол хүмүүс урьд өмнө нь ойлгодоггүй байсан зүйлээ хэрхэн ойлгож авч байгааг харах явдал байдаг. /Өө, одоо л нэг ойлголоо гэх/ Хэрвээ та ийнхүү ойлгож авсан зүйлээ уншигчиддаа хүргэвэл танд бүр ч сайхан байх болно. Техникийн ойлголтууд, үйл явцыг ойлгож авч байгаа уншигчдад яг хэзээ нь яаж туслах, туслахын тулд ямар үг хэллэг хэрэглэх вэ гэдгээ мэддэг болох хэмжээний мэдрэмжийг хөгжүүлэх хэрэгтэй гэсэн үг.

Дээрх зөвлөгөөнүүдийн заримыг хэрэгжүүлэхэд хэцүү байдаг. Хуучинсаг үзэлтэй, өөртөө итгэлгүй олон дарга таныг “энэ тухай бичих шаардлага алга” гэж хэлэхэд

дургүйцнэ. Олон дарга нэгэнт тухайн мэдээллийг хэвлэлийн мэдээнд юм уу засгийн газрын албаны хүн хэлсэн учраас заавал мэдээ байх ёстой гэж ойлгодог. Зарим дарга зүгээр л түргэхэн хуудсуудаа дүүргэж гэртээ харихыг бодно. Үүнтэй тэмцэхэд амаргүй байх болно.

Гэхдээ та чанартай сэтгүүлзүйг эрхэмлэдэг бол тэмцэхээс өөр аргагүй. Амжилттай тэмцэхэд юу хийх хэрэгтэй гэдгийг одоо авч үзье.

Хамгийн түрүүнд бид аливаа өгүүлэл Хэн, Юу, Хаана, Хэзээ, Яагаад, Хэрхэн гэсэн асуултуудад л хариулах ёстой гэсэн ойлголтоосоо өргөн цар хүрээнд сэтгэх хэрэгтэй. Дээрх асуултуудад хариулаад зогсохгүй цаашаа явах хэрэгтэй. Хамгийн эхлээд өөрсдөөсөө “юу болсон бэ, болсон явдлаас манай уншигчид юуг мэдэх шаардлагатай вэ?” гэж асуугаад тухайн үйл явдлын ач холбогдлыг тодорхойлох шаардлагатай. Бид тухайн үйл явдалд үнэлгээ өгөх буюу хэмжих хэрэгтэй. Хамгийн том үйл явдал уу, хамгийн урт уу, эсвэл хамгийн өндөр үү? 10 хувь уу, 50 хувь уу. Анхных уу, цорын ганц уу, сүүлчийнх үү? Дэлхийн хамгийн том агаарын компани гүйцэтгэх захирлаа халсан тухай мэдээ хамгийн жижгээрээ тавд ордог компани онгоцны багийн гишүүнийг халсан тухай мэдээнээс илүү сонин байна шүү дээ. Болсон явдлыг бүх талаас нь хэмжиж үз. Компаниуд, хүмүүс, үйл явдлуудыг бүгдийг нь хэмжээд уншигчиддаа авсан хэмжээнийхээ талаар тодорхой ойлголт өгөөрэй. Ингэснээр та мэдээнийхээ ач холбогдлыг өөрөө тайлбарлах боломжтой болно.

Тайландын нэг сонинд гарсан дараах өгүүллийг авч үзье.

УЛСЫН АРВАН ТАВАН ПҮҮС НЭГЭН ДОР ХУВЬЧЛАГДАХ ГЭЖ БАЙНА

Дараагийн хоёр жилд улсын арван таван компани хөрөнгийн биржид хувьцаагаа зарах бөгөөд ингэснээр зах зээлийн хөрөнгөжилт 803 тэр бум бат-аар нэмэгдэнэ гэж ерөнхий сайд Таксин Шинаватра хэллээ.

Интернэт Тайланд, Тай Эйрвэйс Интэрнэшнл, Тайландын Түлшний хэрэг эрхлэх газар гэсэн гурван компани 83.6 тэрбум батын үнэлгээгээр энэ жил хувьчлагдана.

Одоо 90 гаруй хувь нь засгийн газрын эзэмшилд байгаа Круг Тай банк мөн л хувийн хөрөнгө оруулагчдын гарт шилжинэ.

Ноён Таксины хэлснээр 2002 онд нийт 303.7 тэрбум батаар үнэлэгдсэн улсын долоон аж ахуйн нэгжийг хувьчлах юм. Үүнд: Телефон харилцааны байгууллага, Харилцаа холбооны хэрэг эрхлэх газар, Тайландын Тамхины монополь, Нисэх онгоцны буудлын хэрэг эрхлэх газар, Засгийн газрын орон сууцны банк, Усан онгоцны хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хадгаламжийн банк зэрэг оржээ.

2003 онд зах зээлийн хөрөнгөжилтийг 309.9 тэрбум батаар нэмэгдүүлэх таван компани хувьчлагдах нь Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн хэрэг эрхлэх газар, Том хотын эрчим хүчний хэрэг эрхлэх газар, Хөдөө орон нутгийн эрчим хүчний хэрэг эрхлэх газар, Том хотын усан станцын хэрэг эрхлэх газар, Хөдөө орон нутгийн усан станцын хэрэг эрхлэх газар юм.

“Хувьчлалын үйл явц эдийн засгийн байдал сайжрахыг хүлээх ёсгүй. Улсын компаниуд хувьчлагдахад бэлэн байгаа бол бирж рүү шилжиж болно” гэж ноён Таксин хэллээ.

Улсын аж ахуйн нэгжүүдийг Үндэсний Аж ахуйн нэгжийн Холдингс Ко. хэмээх шинэ пүүсийн удирдлаган дор салбараар нь бүлгүүдэд хуваах аж.

Сангийн сайд Сомкид Жатусрипитадын хэлснээр зарим агентлаг түрүүлж хөрөнгийн биржид зарлагдаад дараа нь хувьцаагаа хувийн хөрөнгө оруулагчдад зарж болно гэнэ. Тухайн компанийн ажилтнуудад хувьцаа авах боломж бас олгоно.

Хөрөнгийн бирж ба Үнэт цаасны хороо нь улсын үйлдвэрүүдийн хувьцаа хөрөнгийн биржээр дамжин хувьчлагдах бүртгэлийг түргэсгэх болно. Компаниуд хувьцаат компани болсноос нэг жилийн дараа Хөрөнгийн бирж, Үнэт цаасны хороо нь бүртгэлийн шаардлагыг хангасан баталгааг компанид автоматаар гарган өгдөг.

Дээрх нуруу өгүүлэлд юун тухай бичсэнийг та ойлгосон хэдий ч энэ өгүүллийн ач холбогдлыг мэдрээгүй байх. Улсын хэдэн том компани хувьчлагдах гэж байгаагаас өөр юу ч мэдэж аваагүй биз дээ.

Ямар үйл ажил явагдаж байгааг бүрэн мэдэж авахын тулд дээрх өгүүлэлд дараах гурван баримт мэдээг нэмэх шаардлагатай. Үүнд:

1. Энэ үед Тайландын Хөрөнгийн биржийн нийт хувьцааны үнийн дүн 1.409 тэрбум бат байсныг /зах зээлийн хөрөнгөжилтийн хэмжээг гэсэн үг/;
2. 1995 онд зах зээлийн хөрөнгийн хэмжээ хамгийн өндөр түвшинд буюу 3.500 тэрбум бат байсныг;
3. 1997 оны Азийн санхүүгийн хямралын төгсгөлөөс хойш хөрөнгийн зах зээл рүү эргэж ирэх гадаадын хөрөнгө оруулагчдын тоо эдийн засгийг сэргээх хэмжээнд хүрэхгүй болсныг.

Дээрх мэдээллийг оруулан өмнөх өгүүллийг засварлавал дараах байдалтай болж байна:

Засгийн газар дараагийн хоёр жилд улсын 15 компанийг хувьчлах гэж байна. Ингэснээр хөрөнгийн зах зээлийн хэмжээ 1/4 –ээр нэмэгдэж эдийн засаг сэргэх байх гэж найдаж байгаа юм.

Интернэт Тайланд, Тай Эйрвэйс Интэрнэшнл, Тайландын Түлшний хэрэг эрхлэх газар болон өөр 12 компанийн хувьцааг зарснаар засгийн газар 1990-ээд онд зах зээлийг өнөөдрийнхөөс хоёр гаруй дахин өсгөсөн гадаадын хөрөнгө оруулагчдыг эргүүлж татахыг хичээж байна.

Дээрх өгүүллийн голыг олохын нууц нь: компаниудаас авсан мэдээлэл дэх бүхий л жижиг сажиг мэдээг /– компаниудын нэр, удирдлагуудын нэр, албан тушаал, зөвлөхүүд, банкирүүд, голлох хүмүүсийн нэр зэргийг-/ хасах юм. Тэгээд үлдсэн мэдээллээрээ өгүүлбэр зохиоход манай жишээнд: Засгийн газар өнөөдрийн байдлаар хүнд байдалд байгаа хөрөнгийн зах зээл ба эдийн засгаа сэргээх оролдлого хийж зарим том компаниудаа хувьчлах гэж байна гэсэн өгүүлбэр үлдэнэ. Энэхүү цөм болох мэдээлэлдээ дараа нь нарийн баримт нэмээд хэл найруулгаа засахад хангалттай.

Сэтгэлгээний дараах шат бол мэдээллээ өргөжүүлэх. Энэ шатанд л та уг мэдээллийг өөрийнх болгоно гэсэн үг. Бичиж буй үйл явдлаас үүсч гарч ирэх боловч уг мэдээлэлд багтаагүй асуултуудыг тавина. Хамгийн түрүүнд уг үйл явдалд хамаатай тодорхой нэг хүн буюу компаниас /олон улсын эдийн засгийн мэдээ бол тодорхой нэг орон/ илүү дэлгэрүүлж сэтгэх хэрэгтэй.

Тэгээд доор бичсэнтэй төстэй асуултуудыг тавина:

- Энэ компани буюу салбарт ийм явдал анх удаа гарч байна уу?

- Энэ явдал тодорхой нэг чиг хандлагын хэсэг үү?
- Эсвэл чиг хандлагаас эсрэг үү?
- Эсвэл үйл явдлын явцад өөрчлөлт гарахын дохио юу?
- Болсон явдал тухайн компани, салбар, улс орон, бусад зүйлд хэрхэн нөлөөлөх вэ?

Бидний дээрх жишээнд ингэж асуух ёстой: Засгийн газар өмнө нь ийм юм хийх гэж оролдож байсан уу? Азийн өөр нэг оронд ийм оролдлого хийгдсэн үү? Хэрвээ тийм бол, манай жишээнд Өмнөд Солонгост ингэж байсан, ямар үр дүнд хүрсэн бэ? Хэрэв өөр хаана ч үүнийг хийгээгүй бол яагаад хийхгүй байгаа вэ?

Эдгээр зүй ёсны болон бусад асуултыг тавьсны дараа хариултыг нь хай. Хариултыг та өөрөө мэдэх ёстой гэж бодож болохгүй. Энд л та сэтгүүлчийн мэдлэг чадвараа ашиглан мэргэжлийн хүмүүсээс асууж эхэлнэ. Асуултанд хариулах хүмүүс гэвэл: газар дээрээс нь мэдээлэл өгөх хүмүүс, ижил салбарт ажилладаг өөр компаниуд, хөрөнгийн брокерүүдийн шинжээчид, эрдэмтэн судлаачид, банкны эдийн засагчид зэрэг олон хүн орох бөгөөд хамт ажилладаг хүмүүсээ /танаас өмнө мэдээ бичдэг байсан хүнийг/, ерөнхий редактороо мартаж болохгүй. Мөн архивын материалыг /номын сан, одоо цагт компьютер дэх мэдээллийн сан, интернэт/ хэзээ ч мартаж болохгүй. Ингээд асуултын хариугаа хайвал таны өгүүлэл ганцхан эх сурвалжтай байхаа болино. Манай дээрх жишээнд ерөнхий сайд, түүний сангийн сайд хоёр нэг эх сурвалж болж байна. Уншигчид эдийн засагчид, хөрөнгө оруулагчид, дотоодын хөрөнгө оруулалтын байгууллагууд зэргээс ямар ч мэдээлэл аваагүй учраас өөрийн дүгнэлт өгөх боломжгүй байна. Ийм өгүүлэл амжилтанд хүрнэ гэж та бодож байна уу? Би лав тэгж бодохгүй байна.

Дараах алхам бол аль тоо баримтыг мэдээндээ оруулах вэ гэдгийг шийдэх. Анхны эх сурвалжаас танд маш их хэмжээний тоо баримттай мэдээ өгөх байх. Гэвч тэдгээр нь “хэмжилт хийхэд” хэрэгцээгүй байдаг. Танд цөөн боловч ач холбогдолтой тоо чухал. Ийм тоо баримтыг шилж авсныхаа дараа түүнийгээ уншигчдад ойлгогдох хэлбэрээр хүргэ. Худалдааны эргэлтийн 32.79 хувь гэхийн оронд 1/3 гэж бич. Хүн амын 10-аас 7 нь гэж хэлж болох зүйлийг 69.36 хувь гэж битгий бич. Та манай жишээ рүү эргээд нэг харвал засварласан хэлбэрт бид 1/4, хоёр дахин гэх мэтийн үгийг хэрэглэсэн байгаа.

Өгүүллийн голд тоон мэдээг яг таг мэдээлэх албагүй байдаг.

За, одоо та өгүүллээ бичихэд бэлэн боллоо. Ингээд аль баримт мэдээллээ хамгийн түрүүнд бичих вэ гэдгээ эхлээд шийдэх болно. Эхлэл хэсгийг хэрэгцээгүй нарийн мэдээллээр, нэр ус, тоо баримт, ялангуяа танил бус мэдээллээр дарахын оронд өгүүллийнхээ голыг бичихийг хүсч байгаа биз дээ. Манай жишээний анхны хувилбарын эхний өгүүлбэр уг нь муугүй болсон боловч дараах өгүүлбэрүүд нь уг өгүүллийг амьгүй олон нэрсийн жагсаалт болгожээ.

Дараа нь өгүүллийнхээ эхэнд юмуу эхэн хавьд уншигчдаа юуны тухай, яагаад энэ өгүүллийг бичиж байгаа гол утгыг бич. Ингэж бичсэнээр толгойд нь олон асуулт эргэлдэж байгаа ч дэс дараатай эрэмбинд оруулах зав чөлөө муутай уншигчдаа удирдамж буюу тайлбар хийж өгч туслах бөгөөд асуултынхаа хариуг олж авах ажлыг л үлдээнэ гэсэн үг. Манай жишээний эхний хувилбарт уншигчид тус болох зүйл нэг ч үгүй байна. Харин засварласан өгүүлэлд яагаад тэдгээр хувьчлалыг явуулж байгаа шалтгааныг / эдийн засаг сэргэх байх гэж найдаж/ оруулсан. Энэ нь яагаад бид энэхүү өгүүллийг уншигчдад зориулж байгааг харуулж байгаа юм.

Гол утгыг эхэндээ авчрах гээд үз, дараа нь дэлгэрүүлж бич. Хэрвээ та хэрэгтэй хүмүүс рүү утасдсан бол тэр гол утга дээр ажиллах нэмэлт материал хангалттай авсан байх ёстой.

Ингээд өгүүлэл тань дэлгэрэнгүй болоод ирэхэд шаардлагатай суурь мэдээлэл, хам утга (контекст) оруулахаа мартаузай. Шинэ өгүүллийг уншигч олон хүн шинэ уншигч /-дөнгөж бизнес мэдээ уншиж эхэлж байгаа, эсвэл гадаадад байж байгаад ирсэн, эсвэл хүүхдээ асарч байгаад ажилдаа эргэж орж байгаа гэх мэт-/ байдаг. Тэгэхээр та өгүүллээ хүн бүрт ойлгомжтойгоор бичих хэрэгтэй. Өмнө нь юу болсныг мэдэхгүй байгаа уншигчийн толгой яг аль хэсэгт эргэж магадгүйг мэдрэх чадварыг өөртөө хөгжүүл. Архиваас ба сурвалжлагаас олж цуглуулсан мэдээлэл болон толгойнд байгаа зүйлээ боловсруулж уншигчдад юу болсныг сануулсан үг өгүүлбэр багтаасан хэлбэртэй болгох хэрэгтэй. Суурь мэдээлэл гэдэг нь юу болсныг сануулдаг ба хам утга (контекст) нь болж байгаа зүйлийн орчин тойронг өргөнөөр харуулахыг хэлдэг юм. Дахиад жишээгээ авч үзье. Тэнд ямар ч суурь мэдээлэл, хам утга (контекст) алга. Ерөнхий сайдын мэдэгдэл гэнэтийнх юм уу удаан

хүлээж байсан зүйл үү? Эдийн засагт юм уу сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлд ер нь юу болж байсныг ч мэдэх аргагүй.

Дараа нь өгүүлэлдээ амь оруулах буюу хүний хэлсэн үгийг хэвээр нь оруулах хэрэгтэй. Эдгээр үг нь бодит хүмүүсийн яриа учраас бичиж байгаа зүйлийг илүү хүчтэй, бодитой болгож байгаа юм. Ингэснээр өгүүлэл маань хэлбэрээ өөрчилж уншигдаад зогсохгүй бас сонсогдох болно. Мөн хүмүүсийн ярианд өдөр тутмын үг хэллэг орж ирдэг.

Ингээд эцсийн хариуцлага тань уншигчтайгаа хамт техникийн нэр томъёоны бартааг давах. Хамгийн хэцүү нь юуг тайлбарлахаа болон юуг олонх хүн мэдэж ойлгодгийг тодорхойлох явдал. Нийтлэл бүрт энэ асуудлыг өөр өөрөөр шийдвэрлэдэг хэдий ч миний туршлагаар бол санхүүгийн сэтгүүлчид буруу тал дээр алддаг буюу тэд тайлбарлах ёстой хэмжээнээсээ бага тайлбарлах хэрэгтэй гэж боддог.

Уншигчдаа туслах гэдэг нь уншигчаа юм мэдэхгүй гэж үзэж байгаа гэсэн үг биш. Уншигчид туслах хэд хэдэн арга бий. Үүнд:

- Танихгүй зүйлтэй тулгарсан учраас мэдэхгүй зүйлд таагүй сэтгэдэл төрсөн, бухимдсан уншигч хуудсаа эргүүлж болзошгүй тэр цэгт тодорхой, ойлгомжтой тодорхойлолт оруулах. Ингэхдээ тухайн зүйлийг уншигч заавал мэдэх албагүй гэдгийг уншигчдаа тодорхой дохиогоор ойлгуулах /ялангуяа техникийн хэцүү шинэ ойлголт байвал/. Ийм үед өгүүлж буй зүйлээ зогсоогоод тайлбараа бич.
- Тайлбараа өгүүллийн дундуур оруулахдаа техникийн нэр томъёоны тодорхойлолтоо сурвалжлагынхаа энгийн явц дунд өгүүлбэрийн хэсэг болгож оруул. Жишээ нь “худалдааны хомсдол гэдэг нь тухайн орны импортын хэмжээ экспортоосоо илүү байхыг хэлнэ” гэж “худалдааны хомсдол” гэсэн шинэ нэр томъёоны тодорхойлолтыг бичихийн оронд ерөнхий бичиж буй зүйлээ худалдааны хомсдол гэж юуг хэлдгийг ойлгуулах хэлбэрээр зохион байгуул. Үүнд: Тус орны хүчирхэг эдийн засаг нь экспортын хэмжээ өсөхөөс илүү хурдацтайгаар гадаадын барааг оруулж ирсний дүнд худалдааны хомсдол 1999 онд 271 тэрбум ам.долларын хэмжээнд буюу 65 хувиар өссөн байна. Хамгийн гол нь тодорхойлолтоо мэдээллийнхээ нэг хэсэг болгох хэрэгтэй.

- Техникийн нэр томъёог энгийн өгүүлбэрт багтаа. Харин дараагийн өгүүлбэрт тодорхойлолтоо цаашдын мэдээлэл өгөхдөө ашигла. Жишээ нь: Инфляци 1999 онд 6 хувь байсан. Энэ бол бараа үйлчилгээний үнэд өөрчлөлт оруулах гэсэн засгийн газрын арга хэмжээ сүүлийн арван жилд анх удаа 5 хувиас илүү гарсан гэсэн үг. Энэ жишээнд шинэ мэдээлэл ба суурь мэдээллийг өгөхийн зэрэгцээ өгүүллээ зогсоохгүйгээр тодорхойлолтоо оруулсан байна.
- Бичил лекц хичээл заа. Заримдаа уншигчдад техникийн үгийг ойлгоход төдийгүй нийт үйл явцыг ойлгоход тусламж хэрэгтэй байдаг. Жишээлбэл зээлийн хүүгийн түвшин нэмэгдэж болзошгүй гэсэн болгоомжлолоос үүдэн хувьцааны үнэ буурдаг. Нийтээр мэддэг баймаар мэт энэ үйл явцыг ямар нэгэн хэмжээгээр тайлбарлаж болно. Үүнд: Зээлийн хүүгийн түвшин нэмэгдэж магадгүй гэж хөрөнгө оруулагчид болгоомжилж байна. Яагаад гэвэл үүнээс болж тэдний хөрөнгө оруулж буй компаниудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд хэрэглэгчдийн эрэлт буурч тэдгээр компанийн хувьд зээл олгоход илүү хүндрэлтэй болдог. Тиймээс зээлийн хүүгийн түвшин өснө гэсэн айдас хөрөнгө оруулагчдын дунд өргөн тарыхын хамт хувьцааны үнэ буурч байна.

Ойлгомжтойгоор, энгийн хэлбэрээр бичнэ гэдэг бол техникийн нэр томъёо олноор ашиглан нэг ч тайлбар хийхийг хичээхгүйгээр бичихээс хамаагүй хэцүү байдаг. Танд боломж байгаа бол Уолл Стрит Журналын нэг дугаарыг олж авах хэрэгтэй. Энэ хэвлэл дэлхийд хамгийн олон хувь борлогддог сайн чанарын бизнес сонин юм. Эднийхэн шинэлэг бөгөөд энгийн хэв маягаар бичихдээ уншигчдад ойлгоход хэцүү байж болох зүйлүүдийг тайлбарлаж, мэдээлэл өгөөд зогсохгүй, бас зугаацуулах үүрэгтэй гэдгээ дандаа санаж явдаг улс. Ингэж бичих бол өдөр тутмын сонинд хэрэглэх ёстой хэлбэр бөгөөд эрдэм шинжилгээний буюу худалдааны сэтгүүлд зориулсан мэт бичих ёсгүй. Бид тэгэхээр өөр ямар ч сэтгүүлчийн хэрэглэдэг шалгуур тестийг хэрэглэх ёстой гэсэн үг. Энэ мэдээ шинэ үү? Онцлог уу? Сонирхолтой юу? Зүгээр зугаа гаргах зүйл үү? Үүнд л бидний ажил оршино.

СУУРЬ ОЙЛГОЛТ: ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖ

Изабел Ортис

ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖИЙН ТУХАЙ САНАА

Хөгжлийн тусламжийн тухай санаа бол шинэ зүйл биш. XX зуунаас өмнө бүх их гүрнүүд колони орнууддаа хөрөнгө оруулалт хийж байжээ. Ромын Эзэнт гүрнээс авахуулаад Хятад, Испани, Турк, Оросын Эзэнт гүрэн, Британий Эзэнт гүрэн хүртэл бүгд л өөрсдийн колониудаа хөгжүүлэхийн төлөө хүн хүчний болон санхүүгийн нөөцүүдээ зориулж байлаа. Тэдний оруулсан хөрөнгө оруулалт тэргүүлэх чиглэлээсээ хамаарч янз бүр байсан бөгөөд зарим нь боомт, тариалан гэх мэтэд, зарим нь сүм хийд, усан санд хөрөнгө оруулж байхад зарим нь шашныг илүү анхаарч, бусад нь татварын удирдлага хөгжүүлэхэд онцгой анхаарч байв. Эдгээр нь эзэнт гүрэн бүрт өөр утга агуулгатай байсан боловч тэд бүгд “хоцрогдсон” бүдүүлэг газруудад “иргэншил”-ийг авчрах зорилготой байв. Гэвч, тэдний хөрөнгө оруулалт нутгийн “бүдүүлэг” хүн амаас илүү тэнд байгаа нутаг нэгтнүүд болон нутгийн баян язгууртнуудад ашиг тусаа өгч байлаа. Өнөөгийн хөгжлийн тусламж ч мөн энэ хандлагын үргэлжлэл гэж шүүмжлэгчид маргадаг бөгөөд энэ талаар хожим энэхүү танилцуулгад авч үзнэ.

XX зууны эхэн үед хөгжлийн тусламжийн тухай ойлголт колонийн системтэй холбоотой хэвээр байв. Европын орнууд боловсрол, соёл, тээвэр, санхүү, цагдаа, шүүхийн тогтолцоо гэх мэт асуудлаар колони орнуудынхаа засаг захиргаанд хөрөнгө оруулж байлаа. Жишээ нь, Даничууд Индонезид дотоодын зах зээлийг байгуулах, тосгодыг сайжруулах, услалтын системийг өргөтгөх, мөн 1900-1920 онд Явад хөдөөгийн зээлийн хоршооны системийг дэмжин хөгжүүлэхэд хөрөнгө оруулж байсан нь өнөөгийн хөдөөгийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй тун төстэй байв. Их Британийн засгийн

газраас колони орнуудаа тасралтгүй хөгжүүлэхэд хүлээх хариуцлагыг 1929 онд Колонийн Хөгжлийн Хууль гаргаснаар анх хүлээн зөвшөөрсөн бөгөөд уг хуульд Британийн Парламент 10 жилийн төсвийг нь жил бүр баталж байхаар заажээ.

Хөгжлийн тусламжийн тухай санаа Дэлхийн II дайны дараа улам төгөлдөржив. Бреттон Вүүдсийн гэрээ дэлхийн шинэ дэглэмийг зоригжуулж өгчээ. Тусламж авах шаардлагатай гол газар нь дайны хөлд сүйдсэн Европ тив байлаа. 1948 онд АНУ-ын Конгрессоос АНУ-ын Үндэсний Нийт Бүтээгдэхүүний (ҮНБ) 2-3 хувийг Европын сэргээн босголтод зориулсан тусламжийг санхүүжүүлэхэд зориулахаар баталсан нь 1953 он хүртэл Маршалын Төлөвлөгөө гэдгээрээ алдаршжээ. Үүгээр тусламж хүртэгч Европын 16 оронд нийт 13 тэрбум ам. долларын (1997 оны ханшаар 87 тэрбум \$) тусламж олгожээ. Тусламжийн бараа бүтээгдэхүүний дөрөвний гурав орчим хувийг Америкийн пүүс компаниуд нийлүүлж, мөн коммунизм тархан дэлгэрэхийг зогсоож чадсан учраас АНУ ч өөрөө улс төр, эдийн засгийн хувьд хожсон байна. Маршалын Төлөвлөгөө нь хөгжлийн тусламж хэрхэн үр өгөөжтэй байж болохыг харуулж урам зориг өгсөн үлгэр жишээг үлдээсэн юм.

Гэвч, 1950-иад он бол харамсалтай нь Хүйтэн Дайн давамгайлсан арван жил байлаа. Тусламж тухайн хандивлагч орны арилжааны эсвэл улс төрийн ашиг сонирхолтой холбоотой хоёр талын шинжтэй хэвээр байлаа. Жишээ нь, Баруун Герман улс гэхэд коммунист Зүүн Герман, ЗСБНХУ болон түүний дагуул улсуудыг хүлээн зөвшөөрсөн аливаа улсын засгийн газарт тусламж үзүүлэхгүй байх байв. АНУ ч мөн адил, Изриаль, Өмнөд Солонгос гэх мэт улсууд, мөн Баруун Европын орнуудад анхаарлаа төвлөрүүлж байлаа. 1955 онд Энэтхэгийн Ерөнхий сайд Неругийн тэргүүлсэн хөгжиж буй орнууд хамтран уулзаж, Хүйтэн дайны үеийн үзэл суртлын зөрөлдөөнөөс зайлсхийх, тусгаар тогтнолын төлөө, ядуурлыг бууруулахын төлөө, эдийн засгийн хөгжлийн төлөө олон үндэстний тэмцэлд анхаарал хандуулах зорилгоор Эвсэлд Үл Нэгдэх Хөдөлгөөнийг байгуулсан байна. Өмнөдөд гарсан энэхүү өөртөө итгэлтэй байдал нь сонирхолтой үйл явдлуудад хүргэсний дотор Латин Америкийн дотооддоо чиглэсэн хөгжлийн төлөө Пребиш загвар, эсвэл хожим дэвшүүлсэн Олон Улсын Эдийн Засгийн Шинэ Дэглэмийн төсөл зэргийг хэлж болно.

“Өмнөдөд зориулсан Маршалын Төлөвлөгөө”-ний тухай санаа бол иргэний нийгмийн бүлэглэлүүдийн

санаа байсан бөгөөд эцэст нь 1950-иад оны сүүлээр Европын засгийн газраас албан ёсны дэмжлэг авсан юм. Үүнийг 1960 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсны дагуу баян орнууд ҮНБ-нийхээ 1%-ийг Өмнөдөд тусламж үзүүлэхэд зарцуулах ёстой болжээ.

1955-1965 онд Европын олон тооны колони орнууд тусгаар тогтносон бөгөөд тусламж авах хэрэгцээ асар их байлаа. Ерөнхийлөгч Кеннеди 1960-аад оныг “хөгжлийн арван жил” хэмээн тунхаглан зарлаж, АНУ-ын ОУХА-ны Агентлаг, Энхтайвны корпус болон бусад АНУ-ын хоёр талын туслалцааны байгууллагуудыг үүсгэн байгуулжээ. Бүс нутгийн Хөгжлийн Банкууд ч байгуулагдав. Энэ үед хөгжиж байгаа орнуудын өсөн нэмэгдэж буй хүн амын хүнсний хэрэгцээнд дэмжлэг үзүүлэх зорилготой “Ногоон хувьсгал” гэгчийг өргөжүүлэн тэлэхэд ихээхэн анхаарч байв. Гэвч тусламжийн хэмжээ ҮНБ-ний 1% гэсэн зорилтот хэмжээндээ хэзээ ч хүрч байсангүй, дээр нь тусламжийн зарцуулалтад оруулж буй зүйлсийн талаар хүлээх хариуцлагатай холбоотой дуулиант асуудлууд гарч байлаа. 1969 онд, Канадын Ерөнхий сайдын тэргүүлсэн нэгэн Комисс баян орнууд арилжааны зээл, цэргийн зардлыг эс тооцон ҮНБ-нийхээ 0.7%-ийг тусламжаар өгөхийг уриалжээ. Үүнийг 1970 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблей дээр бүх хөгжилтэй орнууд зөвшөөрч баталсан юм.

1960-аад он сулхан үр дүнтэй болсны дараа НҮБ-аас 1970-аад оныг “хөгжлийн хоёр дахь арван жил” болгон зарлав. Гэвч газрын тосны хямрал тусламжийн хэмжээг бүр доогуур түвшинд хүргэж, дунджаар ҮНБ-ний 0.29% болтол буурав. Гэхдээ, оюун санааны талаас нь авч үзэх юм бол 1970-аад он туйлын үр бүтээлтэй байлаа. Хүйтэн дайны байдал, хөгжиж байгаа орнуудын ядуурлын хүлцэхийн аргагүй түвшнээс залхсан хөгжлийн ажилтнууд, эрдэмтэн судлаачид үүнд шүүмжлэлтэйгээр үнэлэлт дүгнэлт өгч, хөгжлийн туслалцааны шинэ санааг хөхиүлэн дэмжиж байв. Энэ үед байгаль орчин, нийгмийн хөгжил, жэндэр, эдийн засгийн хуваарилалт буюу дахин хуваарилалт, ажил эрхлэлт, хүний эрх, суурь хэрэгцээний тухай хандлагууд болон бусад олон гол дэвшлүүд гарсан юм.

1980-аад оныг “хөгжлийн алдагдсан арван жил” гэж нэрлэж байсан нь 1990-ээд онд ч сайн тохирох нэр байв. Латин Америк гадаад өрийн хямралын хүнд цохилтод орж, хүүгийн хувь өсч, өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдснээр удалгүй бусад хөгжиж буй орнууд ч хямралд нэрвэгдэв. Тэдэнд тулгарсан хүндрэл бэрхшээлд хариу

болгох шийдэл нь “Вашингтоны зөвшилцөл” нэртэйгээр гарч ирсэн бөгөөд энэ нь инфляцийн эсрэг хатуу арга хэмжээ авах, төсвийн зарлагыг багасгах, нийтийн эзэмшлийн өмчлөлт хийхийг санал болгосон томъёолол байв. Гэвч зээлийг төлөх, инфляцийг тогтоон барих, нөөц бий болгох нь (ихэвчлэн ам.долларын бондоор) хямралд нэрвэгдсэн орнуудын хөгжлийн гол тэргүүлэх чиглэлүүд байсан гэж үү? Танзанийн Ерөнхийлөгч Найрьер нийтэд хандан мэдэгдэл хийсэн шиг “Бидний өрийг төлөхийн тулд үр хүүхдүүд маань өлсөх ёстой гэж үү?”. Бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрүүдийг ихээхэн шүүмжлэх болов. Цаад шалтгаан нь колончилолыг мөнхөлсөн нийгмийн асар их зардал гаргаж байж хөгжилтэй орнуудын банкуудыг хамгаалах, америк долларын ханшийг тогтвортой байлгах явдал байсан гэж олон хүмүүс маргаж байна. Дэлхий даяар ядуурал, иргэний мөргөлдөөнүүд хурцдаж нийгмийн үзүүлэлтүүд буурав. ДОХ гэх мэтийн тахал өвчнүүд дэлгэрэв. Энхийг сахиулах, онц байдлын арга хэмжээнүүдэд зарцуулж буй зардлын эзлэх хувь огцом өсч, ихээхэн хэрэгцээ шаардлагатай байсан хөгжлийн тусламжийн хэмжээ доогуур хэвээр үлдэв.

ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖ ХХІ ЗУУНД

Эдийн засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын Хөгжлийн Тусламжийн Хорооны хамгийн сүүлийн үеийн баримтад (2000-2003) тулгуурлан авч үзвэл шинэ зууны Хөгжлийн Албан Ёсны Тусламжийн (ХАЁТ) дараахь дүр зураг гарч байна.

(а) Хөгжлийн хязгаарлагдмал нөөцүүд

ДНБ-ний зорилтот 0.7% нилээд доогуур хэвээр, дөнгөж 0.2% байна. Үүнээс АНУ 0.12%, Япон 0.23%, Европын Холбоо 0.34%-ийг хандивласан байна. 0.7%-ийн зорилтот түвшинд зөвхөн Дани, Люксембург, Нидерланд, Норвеги, Швед улсууд хүрсэн байна. Жилд дунджаар Европын Холбоо 29.7 тэрбум \$, АНУ 12.7 тэрбум \$, Япон 8.1 тэрбум \$-н хандив өргөсөн байна. Баян орнууд улам баяжиж, улам харамч болсоор байна. Бодит байдал дээр тэдний өргөсөн хандив өмнөх арван жилтэй харьцуулахад буурсан (тэдний орлоготой

харьцуулахад) байх бөгөөд 1990-ээд оны эхээр хандивын хэмжээ дунджаар ЭЗХАХБ-ын орнуудын ДНБ-ний 0.32% байлаа.

ХАЁТ ингэж буурсан нь хөгжлийн тусламжийн хязгаарлагдмал үр нөлөөтэй байдал туйлдсанаас үүдэлтэй мэт санагддаг. Сүүлийн арван жилийн турш ядуурлыг бууруулах буюу эдийн засгийн хөгжлийн тогтвортой нөхцлүүд бий болгоход хөгжлийн тусламж хангалттай тус нэмэр болсонгүй. Зарим талаар, баян орнууд хэзээ ч Өмнөд зориулсан Маршалын төлөвлөгөөнд хөрөнгө оруулж байгаагүй, харин түүний оронд нөөц баялгаасаа өчүүхэнийг л өгсөн, улмаар дэлхийн хөгжиж байгаа 175 орон хэзээ ч бүрэн хөгжиж байгаагүй гэсэн таамаглал биелэлээ олох нь тодорхой байна.

Гэвч, энэ маргаанд бас хууль ёсны асуудлууд байна: Нутгийн баян (бас авилгад идэгдэж ялзарсан гэж олон хүн үздэг) элитүүдэд зохих ёсоор татвар ногдуулдаггүй мөртлөө яагаад ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын дундаж ангийнхан хөгжиж байгаа орнуудын төсвийн зарлагын төлөө мөнгө төлж байх ёстой юм бэ? Хөгжиж байгаа орнуудад орлогын тэгш бус байдал асар их байдаг учраас дотоодын татварын бодлогыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлснээр хөгжлийн нэмэлт нөөц баялагийг бий болгох ёстой. 1980-90-ээд оны үеийн неолиберал үзэлтнүүд (өнөөгийн хуучинсаг үзэлт засгийн газруудын) хөрөнгө чинээтэй баячуудад ингэж татвар ногдуулах явдалд дургүй байв. Дахин хуваарилалт, авилгатай тэмцэх, татвараас зайлсхийх, татварын диваажин зэрэг сэдвүүд саяхнаас л олон талт байгууллагуудын хүрээнд төрөн гарсан нь гадаадаас орж ирж байгаа хомсхон тусламжид нэмэр болохуйц хөгжлийн нэмэлт эх үүсвэрээр хангах зорилготой байв.

Зарим хүмүүс хувийн салбарын хөрөнгө оруулалт хөгжлийн тусламжаас давах болно гэж маргадаг. Хөгжиж буй орнуудад орж байгаа хувийн салбарын хөрөнгийн урсгал их боловч түүний 80 хувь нь зөвхөн цөөн хэдэн дунд орлоготой орнуудад (Аргентин, Бразил, Хятад, Энэтхэг, Индонези, Солонгос, Малайз, Мексик, Филиппин, Сингапур, Тайвань, Тайланд) ашиг тусаа өгч байгааг тэмдэглэх нь зүйтэй. Африк юм уу өөр хаа нэгтээ байгаа хамгийн буурай хөгжилтэй орнуудад хувийн хөрөнгийн урсгал ач холбогдолгүй байдаг. Хувийн салбарын хөрөнгийн урсгал бол хөгжлийн тусламжийг орлогч биш юм.

2002 онд Монтерейгийн хөгжлийн бага хурлаас

хандивлагч орнууд ДНБ-нийхээ 0.7%-ийг хандивлах амлалтаа дахин нотлох, хөгжиж буй орнууд дотоод нөөц бололцоогоо дайчлахыг уриалав. Үр дүн муутай байгаатай холбогдон Бразилийн Ерөнхийлөгч Лулагийн санаачлагаар дэлхийн удирдагч нарын 2004 оны уулзалтаас хөгжлийн санхүүжилтийн шинэ эх үүсвэрүүдийг олж тогтоох зорилгоор Өлсгөлөн, Ядуурлын Эсрэг Үйл ажиллагааны Тунхаглалыг зарлажээ. Харамсалтай нь АНУ, Японы биш, харин НҮБ-ын дэмжлэгтэйгээр дараахь санал зөвлөмж бүхий тайлан гаргажээ. Үүнд: хөгжлийн хязгаарлагдмал нөөцөд нэмэр болгож (i) зэвсгийн худалдаа, байгаль орчны бохирдол, хил дамнасан санхүүгийн урсгалыг тогтворгүйжүүлэх зэрэг дэлхий нийтэд сөрөг үр дагавартай үйл ажиллагаанд татвар ногдуулах (Тобины татвар гэж нэрлэдэг), (ii) Олон Улсын Санхүүгийн Хэрэгсэл бий болгох, (iii) Тусгай Сугалааны Эрхүүд (ТСЭ) шинээр гаргах, (iv) татвараас зайлсхийх, татварын диваажин бий болгохын эсрэг олон улсын нэгдмэл арга хэмжээ авах, (v) шинэ аргууд (кредит карт, сугалааны борлуулалтын хувь гэх мэт) ашиглан сайн дурын хандивыг нэмэгдүүлэх, (vi) нийгмийн зүй ёсны хөрөнгийн сангуудын портфелийг сайжруулах, (vii) гадаадад ажиллагсадын мөнгөн гуйвуулгыг нэмэгдүүлэх зэргийг зөвлөмж болгожээ.

(б) Хоёр талын харилцаа өргөжиж, дэлхий нийтээр хэлэлцэх нийтлэг асуудал хомсдсон байдал

XXI зууны эхээр хандивлагчид олон талт харилцааг илүүд үзэхгүй байна. 2000-2003 онд үзүүлсэн ХАЁТ-ийн 64%-ийг хоёр талт харилцаанаас (улам өсөх хандлагатайгаар), дөнгөж 36%-ийг нь НҮБ-ын байгууллагууд, хөгжлийн банкууд гэх мэт олон талт байгууллагуудаас (тэдэнд өгч байгаа хандивыг хассан хэвээр байх хандлагатай байна) үзүүлсэн байна. Асуудлын гол нь нийтлэг нэг асуудалтай санал нийлэхгүй байгаа томоохон хүчирхэг улсуудаас болж байна.

Энэ бол бас нэг санаа зовоосон чиг хандлага юм. Байгаль орчин гэх мэт дэлхий нийтийг хамарсан асуудлууд дэлхий нийтийн шийдэл шаардаж байна. Бага хэмжээний хоёр талын тохиролцооны хэлбэрт шилжих нь хандивлагч орнуудад ашигтай байж болох ч (улс төр, эдийн засгийн нөлөөний хувьд), маш их хэрэгтэй байгаа урт хугацааны үр дүнг авчрахгүй юм.

Дээр нь нэмж хэлэхэд, хандивлагчид олон талтай байх нь хөгжиж байгаа орнуудын засгийн газруудад хүндрэл үүсгэж байна. Хандивлагч бүр асуудлыг тодруулах, үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, үнэлгээ өгөх өөр өөр журам, механизмтай ирж, өөр өөр тайлагнах шаардлагууд тавьдаг бөгөөд төрийн ажилтнуудын цаг, нөөцийг шавхсан асар их бичиг цаасны ажилтай байдаг. Хандивлагч бүр өөрийн бодлогын тэргүүлэх чиглэлтэй, тэдгээр нь хоорондоо зөрчилдөх нь олонтаа байдаг учраас хөгжиж байгаа орны засгийн газрууд хоорондоо уялдаа холбоо муутай бодлогын шинэчлэлүүдийн хооронд хавчуулагддаг байна.

Заримдаа, хандивлагчид төвлөрүүлэн төлөвлөх эрх бүхий байгууллагыг алгасан шууд салбарын чиглэлийн яамдтай төслийнхөө талаар тохиролцож, улмаар үндэсний засгийн газрын байгууллагуудын хооронд хурцадмал байдал үүсгэдэг байна. Мөн хандивлагчид хамтран хуваах арга хэрэглэж, үзүүлэх тусламжийнхаа цар хүрээ, найдвартай байдлыг үл харгалзан хандив өгөх чиглэл салбаруудыг өөр хоорондоо хувааж авснаар (өөрөөр хэлбэл, нэг хандивлагч нь эрүүл мэндийн салбарт, нөгөө нь боловсролын салбарт, аль эсвэл хандивлагчид өөр хоорондоо тохиролцон газар зүйн бүсээр нь хувааж аван хандив өргөх гэх мэт) засгийн газрууд чиглэл бүрт харилцан адилгүй буюу тэнцвэртэй бус дэмжлэг авахад хүргэх явдал олон тохиолддог. Дээр нь, хандивлагч орнууд өөрийн гэсэн санхүүжилт олгох үйл явцтай, тэр нь хөгжиж байгаа орнуудын төсвийн циклээс өөр байдаг; түүнээс ч дор нь, заримдаа тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр найдваргүй байснаас санхүүжилт хойшлох, хөтөлбөрүүд тасрах явдал гардаг.

Хандивлагч нарын олон талт байдлаас үүссэн эдгээр олон тооны дутагдлыг арилгах үүднээс 2003 онд ЭЗХАХБ-ын Хөгжлийн Тусламжийн Хорооноос Тусламжийг Уялдуулан Жигдрүүлэх тухай нэгэн чухал санаачлагыг эхлүүлсэн юм. Дээр нь, тусламжийн сангуудыг нэгэн дээврийн дор нэгтгэх зорилгоор бий болгосон тусламжийн шинэ арга хэрэгслүүд, Салбарын Хэмжээний Арга, Төсвийн Шууд Дэмжлэг болон бусад аргуудыг энэ өгүүллийн дараагийн хэсэгт тайлбарлах болно. Гэсэн хэдий ч, дэлхий нийтийн хэтийн зорилго, дэлхийн бүх орны нийгэм, эдийн засгийг удирдах мастер төлөвлөгөө, байгаль орчин гэх мэт дэлхий нийтийг хамарсан асуудлуудыг авч үзэх явдал байхгүй хэвээр байна.

(в) Хэн хождог вэ?

Уяатай тусламж хэм хэмжээ болсоор

Ихэнх хөгжлийн тусламжууд уяатай хэвээр байна. Уяатай тусламж гэдэг нь хөгжлийн санхүүжилт олгохдоо бүхий л бараа, үйлчилгээг ямар ч үнэтэй байсан зөвхөн тухайн хандивлагч улс дагнан нийлүүлнэ гэсэн нөхцлөөр олгоно гэсэн үг. Олон улсын зах зээл дээрээс илүү хямд, чанартай бараа, үйлчилгээг худалдан авах боломжтой нөхцөлд уяатай тусламж олгох нь тусламжийн 25 орчим хувьтай тэнцэх алдагдал үүсгэж байна гэж Дэлхийн Банк тооцоолж байна.

Уяатай тусламжаас үүдэн хөгжлийн тусламжаас хэн хожиж байна вэ гэсэн асуулт тавигддаг: уяатай тусламж бол хандивлагч орны компаниудад олгож буй дам татаас юм. Энэ нь ялангуяа ядуу орнууд эргүүлэн төлөх ёстой хөгжлийн зээлийн хувьд байж болшгүй нөхцөл юм. Өөрөөр хэлбэл, ядуу орны татвар төлөгчид баян хөгжилтэй орнуудын компаниудад дэмжлэг үзүүлдэг байж таарахгүй!

2005 онд Финлянд, Франц, Герман, Ирланд, Япон, Нидерланд, Норвеги, Швед, Швейцари, Их Британи зэрэг цөөхөн хэдэн орон хөгжлийн хандив тусламжуудаа уяанаас бүрэн чөлөөлсөн байна.

**(г) Хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлүүд:
Хөгжлийн хэлэлцэх асуудал**

XXI зууны эхэнд тусламж авагч гол орнууд бол БНА Конго Улс, Индонези, Вьетнам, Хятад, Пакистан, Энэтхэг, Серб-Монтенегро зэрэг улс байна. Энэхүү өгүүллийг бичиж дуусах үед 2004 оны тоо баримт гарч дуусаагүй байсан боловч гол хүлээн авагч орны нэг нь Ирак болохыг нотлох баримтууд харуулж байна. Эдгээр нь эдийн засгийн болон улс төрийн ашиг сонирхлын хувьд дэлхийн томоохон гүрнүүдтэй холбоотой орнууд байв. XXI зууны эхний арван жилд неоколончиллын хандлага дахин сэргэж байна хэмээн шүүмжлэгчид цохон тэмдэглэж байна.

Тусламж авагч гол салбарууд гэвэл: (i) боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, ус гэх мэт нийгмийн талын хөрөнгө оруулалтууд 2000-2003 оны нийт хөрөнгө оруулалтын 32%-ийг эзэлж, цаашдаа ч өсөх хандлагатай байна; (ii) тээвэр, эрчим хүч гэх мэт эдийн засгийн

салбарууд 10%-ийг эзэлж байгаа нь цаашид буурах хандлагатай байна; (iii) сөргөлдөөний дараахь болон онц байдлын тусламжууд 8% байгаа нь цаашид өсөх хандлагатай байна; (iv) хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалт 4%-тай, цаашид буурах хандлагатай байна. Энэ нь 1980-1990 онуудынхаас илт ялгаатай байна. Энэхүү өгүүллийн эхэнд дурдсанчлан хөгжлийн тусламжийн тэргүүлэх чиглэлүүд цаг хугацааны явцад өөрчлөгдсөөр байна. 1950-иад оны үеийн тэргүүлэх чиглэл дэд бүтэц байлаа. 1960-аад онд иргэний бүтээн байгуулалт, хөдөө аж ахуй буюу “ногоон хувьсгал” тэргүүлж байв. 1970-аад оноос нийгмийн хөгжлийн сэдвүүд шинээр орж ирсэн байна. Харин 1980-90-ээд онууд нь өрийн хямралыг дагасан санхүүжилт, бүтцийн өөрчлөлтийн жилүүд байж, тогтворжуулах хөтөлбөрүүдээс гадна салбаруудын хэмжээгээр өмч хувьчлах, өртөг зардал бууруулах арга хэмжээнүүд авсан буюу “Вашингтоны зөвшилцөл”-д хүрсэн жилүүд байлаа. Гэтэл, 1990-ээд оны сүүлээр ядуурлыг бууруулах, засаглал (сайн төрийн удирдлага), байгаль орчин (тогтвортой хөгжил), зэрэг хөгжлийн хэлэлцэх асуудлууд хүчтэй түрэн орж ирсэн юм.

Хамгийн сүүлд Монтерейгийн бага хурал дээр хөгжил бол зөвхөн сангийн сайд нарт даатган орхиж болохгүй дэндүү чухал, дэндүү нарийн түвэгтэй асуудал болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Сэтгэлгээний энэхүү өөрчлөлтийн нэг хэсэг нь иргэний нийгмийн бүлгүүдийн шахалт болон Дэлхийн Банкны илүү дэвшилтэт удирдлагын манлайллаас үүдэн гарч байна. Ядуурлыг Бууруулах Стратегийн Баримт Бичиг (ЯБСББ) гэдэг хөгжлийн төлөвлөлтийн шинэ хэрэгсэл төрөн гарав.

Энэхүү ЯБСББ-таливаа орны ядуурлын шалтгаануудыг судлан шинжилж, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад хөгжлийн түншүүдийг татан оролцуулсан хамтын оролцооны аргаар тухайн улс орны онцлогт тохирсон хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тогтоодог байна. Тэргүүлэх чиглэлүүд улс орон бүрт харилцан адилгүй байна. Урьд өмнө нь олон төлөвлөгөөг тухайн орны онцлогт хязгаарлагдмал хүрээнд нийцүүлж хуулбарлан хэрэглэдэг байсан нь хүлээгээгүй үр дагавруудыг үүсгэдэг байлаа. Жишээлбэл, 1980-90-ээд онд ихэнх хөгжиж буй оронд хэрэгжүүлсэн бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ нь нийгмийн асуудлуудыг орхигдуулан эдийн засгийн үйл ажиллагаанд голлон анхаарч байв. ЯБСББ-ийн эхний үе нь тэгш байдлын асуудлуудыг төрийн бодлогод чиглүүлж, ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжих талаар тухайн улс орны онцлогт

тохирсон тэргүүлэх чиглэлүүд бий болгох тохиролцоонд хүрснээрээ маш их ач холбогдолтой байлаа. Нийт улс орнуудын хэмжээнд тавигдаж буй ерөнхий нэг тэргүүлэх чиглэл нь 2015 он гэхэд Мянганы Хөгжлийн Зорилгуудыг (МХЗ-ууд) биелүүлэх явдал болоод байна. Үүнд туйлын ядуу, өлсгөлөн байдлыг тал хувиар бууруулах, нялхсын эндэгдлийг бууруулах, бүх нийтээр бичиг үсэгтэй болох, эхчүүдийн эрүүл мэндийг дээшлүүлэх, хүйсийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, ДОХ болон хумхаа өвчинтэй тэмцэх, байгаль орны тогтвортой байдлыг дэмжих, хөгжлийн түншлэлийн хүчин чармайлтуудыг нэгтгэх зэрэг зорилгууд тавигдаж байна. Цаг хугацааны туршид хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд өөрчлөгддөг шиг зайлшгүй шаардлагатай хоёр дахь үеийн ЯБСББ-ийг боловсруулах ажил одоо ид явагдаж байна.

**(д) Хөгжлийн туслалцааны хэрэгслүүд:
буцалтгүй тусламж ба зээл, төслийн ба
төсвийн дэмжлэг**

Тусламжийг нэг бол зээл эсвэл буцалтгүй тусламжийн хэлбэрээр олгож болдог. Олон талт банкуудаас олгосон зээлийг арилжааны эсвэл хөнгөлөлттэй хүү тооцож, эргүүлэн төлөх ёстой бөгөөд хөнгөлөлттэй хүүгийн хувь жилийн 1% орчим, тухайн санхүүгийн байгууллагаас хамаарч 20-30 жилийн хугацаатай байдаг. Олон талт банкууд Мексик, Энэтхэг гэх мэт нэг хүнд ногдох ДНБ өндөртэй хөгжиж буй орнуудад зөвхөн арилжааны зээл олгодог. Сануулж хэлэхэд, Гуравдагч Ертөнцийн орнуудын өрийн ихэнх нь олон талт байгууллагуудад бус, харин хувийн банкуудад төлөх өр байдаг.

Уламжлал ёсоор хөгжлийн тусламжийн үндсэн хэлбэр нь “төсөл” байсан бөгөөд замын төсөл гэх мэт өөрийн гэсэн хангамж нийлүүлэлт шаардсан тодорхой төслийн элементүүдтэй байдаг байв. Тухайн оронд туслахын тулд хандивлагч бүр бага хэмжээний төслүүд боловсруулж (тухайлбал, аль нэг хотын тодорхой тооны эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэг үзүүлэх, бүс нутагт усалтын систем хөгжүүлэх, аль нэг яаманд зөвлөгөө өгөх гэх мэт), харин тухайн орны засгийн газар ерөнхий төрийн удирдлагыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ доноруудын хооронд зохицуулалт хийж байдаг. Тэр болгонд хандивлагч бүр өөр өөр захиргааны болоод тайлагнах системтэй, дээр дурдсанчлан их хэмжээний

бичиг цаасны ажил шаарддаг учраас ажил үйлчилгээний зардал өндөртэй байдаг.

Хөгжлийн тусламжийн чиг хандлага төслийн хэлбэрээс аажмаар шилжиж, төсвийн дэмжлэг үзүүлэхэд бүх хандивлагчдыг оролцуулж, голцуу нийгмийн салбарын зарцуулалтад чиглэдэг болоод байна. Энэ нь засгийн газрын захиргааны удирдлагад дэмжлэг үзүүлэх (хандивлагчид тэдний өмнөөс юм хийхийн оронд) нэг арга зам боловч (i) засгийн газрыг зөв зүйл хийхэд нь туслахад нэлээд хэмжээний техникийн туслалцаа шаарддаг, (ii) санхүүжилт зөв хийгдэж байгаа эсэхийг шалгах үүднээс сайн ЯБСББ, Дунд Хугацааны Зарцуулалтын Хүрээ (ДХЗХ)-тэй болох нэг нөхцөл болдог. Ингэж ядуурлыг бууруулах зардлуудад төсвийн дэмжлэг үзүүлэх өөр өөр хэлбэрүүд байдаг. Үүнд:

- Ядуурлыг Бууруулах Өсөлтийг Хангах Хэрэгсэл(ЯБӨХХ) бол ОУВС-аас ESAF (бүтцийн өөрчлөлтийн хэрэгсэл)-ийн оронд хэрэгжүүлж буй ядуу буурай орнуудад зориулсан хөтөлбөр бөгөөд аливаа орны ЯБСББ-г тулгуурласан байх ёстой.
- Төсвийн Шууд Дэмжлэг (ТШД) нь олон улсын хандивлагчид/байгууллагуудаас аливаа хөгжиж байгаа орны ерөнхий төсөвт оруулж буй шууд шилжүүлгээс бүрддэг. Жишээлбэл, аливаа орны ЯБСББ-ийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Дэлхийн Банкнаас олгож буй Ядуурлыг Бууруулахад Дэмжлэг Үзүүлэх Зээллэг (ЯБДҮЗ) эсвэл аливаа орны ЯБСББ болон ДХЗХ-ний чанарыг хүлээн зөвшөөрсөн хандивлагч нараас олгож буй олон хандивлагчтай ТШД байж болно.
- Салбарын Хэмжээний Аргууд (СХА-ууд) нь аливаа засгийн газрын салбарын стратеги болон төсөвт үзүүлэх олон хандивлагчийн дэмжлэгт тулгуурладаг. Нэгэнт засгийн газар болон гол хандивлагчид эсвэл хандивлагч байгууллагуудын хооронд гэрээ байгуулсан буюу түншлэл явагдаж байгаа тохиолдолд хандивлагчид тухайн засгийн газрын бүх санхүүжилтийг зохих ёсоор зарцуулах, бүртгэж тайлагнах журамд найдан холбогдох төсөвт нь санхүүжилт хийдэг байна. 2004 оны эхээр хөгжиж байгаа орнуудын хэмжээгээр нийт 100 орчим СХА-ууд хэрэгжсэний 85% нь Африк тивд, дийлэнх хувь нь эрүүл мэнд, боловсролын салбарт зарцуулагдаж байсан ч хөдөө аж ахуй, усан хангамж, байгаль орчин, эрчим хүч болон бусад салбарын чиглэлээр оруулах хөрөнгө нэмэгдсэн байна.

Хандивлагчид, олон улсын байгууллагууд, хөгжиж буй орны засгийн газар бүгд л ядуурлыг бууруулахад голлон анхаарч байгаа тул тэдгээрийн тавьж буй зорилтуудыг уялдуулахад эдгээр шинэ механизмуудын ач холбогдол оршиж байна. Бодлогын зорилтуудыг уялдуулж, тухайн засгийн газарт шууд дэмжлэг үзүүлснээр ядуурлыг бууруулах тэргүүлэх чиглэлүүдийг ил тод байдлаар авч үзэж, санхүүжилтийг сайн ашиглаж байгаа эсэхийг хандивлагчид мэдэх боломжтой бөгөөд эсрэг тохиолдолд үзүүлж байгаа дэмжлэгээ зогсоож ч болох юм. Нөгөө талаас, хөгжиж байгаа орны засгийн газрууд ядуурлыг бууруулахад тулгарч буй дотоодын саад бэрхшээлүүдтэй тэмцэх (голдуу хамгийн хэцүү саад бэрхшээл нь улс төрийн эсэргүүцэл байдаг), хөгжлийн тусламжийн ажил үйлчилгээний зардлуудыг хамгийн доод түвшинд хүртэл багасгах, орчин үеийн засаг захиргааг хөгжүүлэх чадавхиа бэхжүүлэх тал дээр хүчтэй дэмжлэг олж авдаг.

Юу дутагдаж байна вэ: Дэлхий нийтийн хөгжлийн хэтийн зорилго

Өнөөдрийн байдлаар хөгжлийн тусламж бол хөгжилд зайлшгүй шаардлагатай хэдий ч хангалттай бус нөхцөл болоод байна. Бидний үзсэнчлэн, тусламж харилцан уялдаатай, улам үр нөлөөтэй болж байгаа нь сайн хэрэг билээ. Хөгжиж байгаа орнууд илүү сайн төрийн удирдлагатай болох, эрүүл мэнд, боловсрол, ус эсвэл тээврийн системээ сайжруулах зэргээр цөөн салбарын хүрээнд дэмжлэг авдаг болсон нь ч сайн хэрэг. Гэвч, энэ нь Гурвадагч Ертөнцийн орнуудыг хөгжүүлэхгүй.

Хөгжлийн тусламж бол хөгжилтэй орнуудаас хөгжиж буй орнуудад нөөц баялагийг шилжүүлж буй хэрэг юм. Энэ нь баян бүс нутгууд нь арай ядуу бүс нутагтаа хөрөнгө оруулдаг бүс нутгийн хөгжилтэй адил зүйл. Бүс нутгийн хөгжил амжилттай хэрэгжиж, ядуу бүс нутагт хөгжил цэцэглэлт авчирсан маш сайхан жишээнүүд байдаг. Үүний нэг жишээ бол Европын Холбоо. ЕХ-ны шилжүүлгийг хүртэж, хөрөнгө оруулалт, зах зээлд нэвтэрсний ачаар Испани, Португаль, Грек, Ирланд зэрэг орон бусдыгаа маш хурдан гүйцэж аваад байна. Үүний нэг адил хөгжлийн тусламж хэмжээгээр их байж, дэлхий нийтийн зах зээл дээр шинээр орж ирэгсдэд эн тэнцүү байр суурь эзлүүлэхүйц хангалттай хэмжээний худалдаа, өрсөлдөөний бодлогууд дагалдсан байх шаардлагатай байна.

Гэвч хөгжлийн тусламж нөөцийн хувьд маш хязгаарлагдмал төдийгүй хөгжиж буй орнуудад ашиг тустай худалдааны дэглэмийн асуудлыг авч үздэггүй билээ. Одоогийн худалдааны загвар нь улс орнуудын хооронд санасан ёсоор чөлөөтэй, үл ялгаварлан гадуурхах өрсөлдөөн өрнүүлэх Дэлхийн Худалдааны Байгууллагын (ДХБ) хэтийн зорилгод тулгуурлаж байна. Гэхдээ, Монгол эсвэл Малави гэх мэт жижигхэн, ядуу, алслагдмал орнууд яаж дэлхийн зах зээлийн хүчтэй өрсөлдөгч нартай адил тэгш нөхцлөөр өрсөлдөж чадах билээ? Дээр нь, ЕХ, АНУ, Япон зэрэг улсууд өөрийн үйлдвэрлэгч нартаа, түүний дотор ядуу буурай орнууд ядуурлыг бууруулахын тулд өөрсдөө хөгжүүлж чадах эдийн засгийн цөөхөн үйл ажиллагааны нэг болох хөдөө аж ахуйн салбартаа, татаас олгож байгаа нөхцөлд одоогийн худалдааны загвар бол ташаарал болно. Харин түүний оронд, “үр ашиг”, “чөлөөт зах зээл” гэсэн нэрийн дор хөгжиж байгаа орнуудын эдийн засгийг нээлттэй, чөлөөтэй болгох үүрэг хүлээлгэдгээс болж дотоодын үйлдвэрлэгч нар нь өндөр хөгжилтэй орнуудын татаас авдаг, чанар сайтай бүтээгдэхүүнтэй өрсөлдөж чадалгүй хаагдаж, улмаар ядуурал, ажилгүйдэл бий болгосоор байна. Энэхүү ёс суртахууны давхар үүргийг (“Миний хийж байгааг биш, хэлж байгааг хий”) хөсөр хаяж, зах зээлийн баримжаатай бодлогыг шийдвэрлэх түвшинд хэрэгжүүлэх нь ядуурлыг бууруулахад онцгой чухал юм. Одоогийн худалдааны бодлогыг хөгжиж байгаа орнуудын дэлхийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг хангасан, ядуу дорой бүс нутгуудыг дэмжих чиглэлд ялгавартай ханддаг “шударга” худалдааны тогтолцоогоор солих шаардлагатай байна.

Хөгжлийн тусламжид юу дутагдаж байна вэ гэвэл дэлхий нийтийн хөгжлийн хэтийн зорилго буюу дэлхийг бүхэлд нь хөгжүүлэх төлөвлөгөө юм. Хоёр талт харилцаанд чиглэсэн өнөөгийн чиг хандлагаас ийм үр дүн гарах магадлал бага төдийгүй энэ нь байгаль орчны хямрал, татвараас зайлсхийх, татварын диваажин бий болгохын эсрэг хийх тэмцэл зэрэг дэлхий нийтийн үйлсэд хувь нэмэр оруулж чадахгүй. Дэлхийн улс орнуудын нэгдэл нягтрал буюу эдийн засгийн даяаршил нь дэлхий нийтийг хамарсан асуудлуудаар хамтын үйл ажиллагаа явуулах шаардлагыг улам бүр бий болгож байна. Хөгжлийн тусламжийн шинэ хэлэлцэх асуудлуудыг дэлхий нийтийн, үндэсний, орон нутгийн гэх мэт бүх шатанд хэрэгжүүлж, өнөөгийн улс орнуудын гол анхаарал тавьж буй асуудлуудыг олон улсын түвшний хүчин чармайлт болгон дэмжих шаардлагатай байна. Дэлхийн нийтийн

хөгжлийн энэхүү хэтийн зорилгыг хөгжилтэй орнууд хангалттай санхүүжүүлэх ёстой. Одоо үгүйлэгдэж байгаа зүйл бол амласан хэрнээ, хэзээ ч олгож байгаагүй өнөөх “Өмнөдөд зориулсан Маршалын Төлөвлөгөө” юм.

АНХААРАХ ЗҮЙЛС

- Хөгжлийн тусламжийн талаар бичихдээ асуух ёстой нэн тэргүүний асуулт бол “Хөгжлийн тусламж аливаа орны тэргүүлэх хэрэгцээг хангахад зориулагдаж байна уу?” гэсэн асуулт юм. Ядуу буурай орнуудын хэрэгцээ бараг хязгааргүй, гэвч хөгжилд зориулсан нөөц баялаг маш хомс учраас гол асуудал тэргүүлэх чиглэл тогтоох явдал оршиж байна гэдгийг хэн бүхэн ухамсарлах ёстой. Тухайлбал, дараахь асуултуудыг өөрөөсөө асуу: Энэ далан байгуулах хөрөнгө оруулалт бусад зүйлсээс, жишээ нь жижиг зээлийн хөтөлбөрөөс, илүү чухал гэж үү? Хүмүүсийг ядуурлаас гаргахад аль хөрөнгө оруулалт нь илүү үр нөлөөтэй вэ? ЯБСББ-т тусгахаар хамтарч санал нэгдсэн үндэсний тэргүүлэх чиглэлүүд юу вэ?
- Нийт хандивлагчдын хэрэгжүүлж буй янз бүрийн хөтөлбөрүүд хоорондоо уялдаа холбоотой юу, хэмжээний хувьд тухайн орныг хөгжүүлэхэд хангалттай юу? Юу дутагдаж байна вэ?
- Нөөцийг дотоодоосоо дайчилж болох уу? Тухайн оронд орлогын тэгш бус байдал их үү? Хангалттай хэмжээнд татвар ногдуулж, улмаар хөгжлийн шинэ нөөц бий болгож чадах хөрөнгө чинээтэй элитүүд байна уу?
- Хөгжлийн тусламжийн үр өгөөжийг хэн хүртэж байна вэ? Тухайн төслийн үр өгөөжийг хүртэгч гол хүмүүс нь хэн бэ, олон тооны ядуу хүмүүс үү, эсвэл цөөн тооны онцгой эрхтэн дархтанууд уу?
- Тусламжийн хөтөлбөр буюу төсөл нь уяатай бус уу, эсвэл зөвхөн хандивлагч орноос бараа, үйлчилгээгээр хангах ёстой юу? Энэ хөтөлбөр буюу төсөл нь буцалтгүй тусламж уу эсвэл зээл үү?

АЛЬ НЬ ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨТӨЛДӨГ ВЭ:

ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЦУУЛАЛТ УУ, ЭСВЭЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ УУ?

Марк Скаузен

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХОД ДНБ, НИЙТ ГАРЦ БОЛОН БУСАД ҮНДЭСНИЙ ОРЛОГЫН СТАТИСТИКИЙГ АШИГЛАХ НЬ

Сэтгүүлч хүнд эдийн засгийн мэдээг мэдээлэхэд олонтаа тулгардаг гол асуулт бол эдийн засгийн байдлын цаад хөтлөгч хүч юу вэ, хэрэглээний зарцуулалт уу эсвэл хуримтлал, хөрөнгө оруулалт уу гэсэн асуулт байдаг.

Дэлхий нийтийн эдийн засгийн ухралтын ихэнх үед дийлэнх сэтгүүлчид хэрэглээний зарцуулалтад голлон анхаарч байжээ. 2001 онд Францын Засгийн газар иргэдээ хангалттай худалдан авалт хийхгүй байгаагаас болгоомжилж Засгийн газрынхаа зардлыг зургаан хувиар нэмэгдүүлсэн байна. Европт жижиглэн худалдааны хэмжээ буурсан нь “баярыг баллана” гэж The Economist сэтгүүл анхааруулжээ. Японд хэрэглэгчид хэт их хуримтлал хийж байсан бөгөөд Азийн энэ хүчирхэг эдийн засагт үсрэлт гаргах цорын ганц арга нь Японы хэрэглэгчдийн хуримтлал хийхийг нь зогсоож, мөнгийг нь зарцуулж эхлүүлэх явдал байсан гэж эдийн засгийн шинжээчид маргаж байв.

“Эдийн засгийн тоймд анхаарах ёстой нэгдүгээр зэргийн асуудал бол хэрэглэгчдийн хийж байгаа зүйл” гэж Голдмэн Заксийн ахлах эдийн засагч Эдвард МакКелви хэлсэн байдаг. АНУ-д CNN, CNBC-н их мэдэгч нар “Хэрвээ Бушийн Засгийн газрын үзүүлсэн татварын хөнгөлөлтийг зарцуулах биш, хуримтлуулж хадгалах юм бол эдийн засгийн сэргэлтэд ямар ч нөлөө үзүүлэхгүй” гэж байнга анхааруулдаг.

Гэвч эдийн засагчид хуримтлал, хөрөнгө оруулалт хоёр бол урт хугацааны хөгжлийн гол түлхүүр хэмээн ёс

төдий тунхаглахын зэрэгцээ олон оронд хуримтлалын хувь хэтэрхий доогуур байна гэж байн байн анхааруулдаг. Харвардын эдийн засагч Грегори Мэнкию өөрийн алдарт “Макроэдийн засаг” хэмээх сурах бичигтээ “хуримтлалын хувь бол капиталын хуримтлалыг тогтвортой байлгах гол тодорхойлогч мөн. Хэрвээ хуримтлалын хувь өндөр байвал эдийн засагт их хэмжээний капиталын хуримтлал бий болж үйлдвэрлэлийн түвшин өндөр байна. Хэрэв хуримтлалын хувь доогуур байвал эдийн засагт капиталын хуримтлал бага болж, үйлдвэрлэлийн түвшин доогуур байна” гэжээ.

Энэхүү хуримтлуулах зуршлын илэрхий логик зөрчлийг сэтгүүлчид хэрхэн шийдэж чадах вэ? Үүний хариулыг эдийн засгийн тэргүүлэх үзүүлэлт болох ДНБ, мөн саяхан АНУ-ын Эдийн засгийн Шинжилгээний Товчооноос гаргасан үндэсний орлогын шинэ үзүүлэлт болох “Нийт гарц”-ын тухай зөв ойлгосны үндсэн дээр олж болно.

ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЦУУЛАЛТ БА ДОТООДЫН НИЙТ ГАРЦ

Хэрэглээний зарцуулалт бол эдийн засгийн хамгийн том салбар мөн, тиймээс эдийн засгийн хөгжлийн цаад хөтлөгч хүчин болдог гэсэн санаа нь Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ)-ий статистикаас үүдэлтэй. Аж үйлдвэржсэн орнуудад тооцдог ДНБ нь аливаа орны тухайн жилд үйлдвэрлэсэн бүх эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн дүнг илэрхийлдэг. Математикийн хувьд ДНБ-ийг дараахь байдлаар илэрхийлдэг:

$$\text{ДНБ} = \text{C} + \text{I} + \text{G} + (\text{X} - \text{M}), \text{ энд}$$

$$\text{C} = \text{Хувийн хэрэглээний зардлууд}$$

$$\text{I} = \text{Нийт дотоодын хувийн хөрөнгө оруулалт}$$

$$\text{G} = \text{Засгийн газрын хэрэглээний зардлууд ба нийт хөрөнгө оруулалт}$$

$$\text{X} = \text{Экспорт}$$

$$\text{M} = \text{Импорт}$$

Улс үндэстэн бүрд хувийн хэрэглээний зардлууд нь ДНБ-нд хамгийн их хувийг эзэлдэг. Жишээ нь, АНУ-ын 2003 оны ДНБ-ийг дараахь байдлаар хуваагджээ: Хувийн хэрэглээний зардлууд (C) = 7,760.9 тэрбум \$; Нийт хувийн хөрөнгө оруулалт (I) = 1,665.8 тэрбум \$; Засгийн газрын зардлууд (G) = 2,075.5 тэрбум \$; Экспортоос (X)

хасах нь Импорт (М) = -498.1 тэрбум

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН (GDP) =
11,004 тэрбум \$

Хэрэглээ АНУ-д ДНБ-ний 70%, Их Британид 65%, Германд 58%, Японд 57%-ийг эзэлдэг байна. Энэ байдлыг мэдээд сэтгүүлчид АНУ-д “хэрэглээний зардал эдийн засгийн гуравны хоёрыг эзэлдэг” хэмээн онцлон тэмдэглэж, жижиглэн худалдааны хэв шинжийг ирээдүйн эдийн засгийн төлөв байдал, үнэт цаасны зах зээлийн байдлын гол тодорхойлогч болгон авч үзэх нь олонтаа байдаг.

Нийт Гарц: Нийт эдийн засгийн үйл ажиллагааны шинэ хэмжүүр

ДНБ бол тухайн эдийн засгийн бүхий л үйл ажиллагаа буюу зарцуулалтыг бүрэн хэмждэг хэмжүүр гэсэн үг биш болохыг сэтгүүлчид анхаарах нь зүйтэй. ДНБ бол бүтээгдэхүүн, үйлчилгээний зөвхөн ЭЦСИЙН үр дүнг хэмждэг. Үүнд бүх завсрын үйлдвэрлэл буюу бэлэн бус бүтээгдэхүүнүүд, өөрөөр хэлбэл машины үйлдвэрлэлд хэрэглэх ган гэх мэт үйлдвэрлэлийн эхний шатандаа яваа бүтээгдэхүүнүүдийн бүхий л борлуулалтыг зориуд орхигдуулдаг. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл, ДНБ бол зөвхөн өрх гэр, бизнес, Засгийн газарт хэрэглэж болох эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэмждэг гэсэн үг. Үйлдвэрлэлийн үе шат бүрт гарч буй зарцуулалтыг тооцох юм бол тооцоо хоёр, гурав дахин давхардчих гээд байдаг аж. Жишээ нь, талхны үйлдвэрлэлд гэхэд буудай, гурил хоёрыг хоёуланг нь талхны үнэд оруулж тооцох болох нь. Харин ДНБ зөвхөн эцсийн хэрэглэж болох бүтээгдэхүүн буюу хүмүүсийн гэртээ хэрэглэж байгаа талхыг л сонирхдог.

Эдийн засагчид завсрын үйлдвэрлэлийн процесс буюу эцсийн бүтээгдэхүүнд хүргэж байгаа үйлдвэрлэлийн шат дамжлагуудыг мөн сонирхдог. Энэ үйл явц нь анхан шатны түүхий эд материалын үйлдвэрлэлт, мөн судалгаа шинжилгээ, хөгжил гэх мэт нөөцийг бий болгох эхний шатнаас эхлээд, хагас боловсруулалт, үйлдвэрлэлтийн шат, мөн бөөний худалдаа ба түгээлтийн сувгууд, эцэст нь жижиглэн худалдаалах түвшний эцсийн борлуулалт хүртэлх бүх шатыг хамардаг. Эдийн засаг дахь бүх ажил үйлчилгээг хэмжихийн тулд бид зөвхөн эцсийн шат бус, бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийн шат бүр дэх бүх борлуулалтыг нэмж тооцох ёстой.

Саяхан хүртэл, эдийн засагчид тооллогын болон IRS-н мэдээллийн сангаас таван жил тутмын орцгарцын статистик тоо баримт цуглуулах замаар завсрын үйлдвэрлэлийн үнийн дүнг тодорхойлдог байв. Харин сүүлийн жилүүдэд АНУ-ын Худалдааны Департаментын Эдийн Засгийн Шинжилгээний Товчооноос (BEA) эдийн засаг дахь нийт зарцуулалтыг жил бүр хэмжих шаардлагыг хүлээн зөвшөөрч, Нийт Гарц (НГ) гэсэн үндэсний орлогын шинэ статистик үзүүлэлт гаргасан байна. (Skousen 1990-г үз) Энд үйлдвэрлэл, түүний дотор үйлчилгээний бүх үе шатны гарцын үнийн дүнг тодорхойлохыг эрмэлзэж байна. Энэ нь ДНБ-ээс бараг хоёр дахин их хэмжээтэй гарч байна. Жишээ нь, 2002 онд (хамгийн сүүлийн тоо баримт) Нийт гарцын хэмжээ 18.7 триллион ам.доллар гарсан бол, тэр үед ДНБ 10.6 триллион ам. доллар байсан байна. (НГ-ын тухай илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.bea.gov хаягаар орж, “ДНБ, салбараар” гэснийг олоод “интерактив хүснэгтүүд”-г үзнэ үү).

Шинэ НГ-ын үзүүлэлтийг ашигласнаар Америкийн эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бас нэг дүр зургийг харж болно. НГ-д тулгуурлан тооцвол АНУ-ын эдийн засаг дахь нийт зарцуулалтын 40%-ийг хэрэглээ эзэлж, бизнесийн хөрөнгө оруулалт (нийт үндсэн хөрөнгө оруулалт дээр завсрын бүтээгдэхүүнүүдийг нэмээд) 52%-ийг эзэлж байна. Хэдийгээр НГ-ын статистик үзүүлэлтийг Европ, Ази, Латин Америкт хараахан нэгтгэж гаргаагүй байгаа боловч бүх голлох аж үйлдвэржсэн орнуудад үүнтэй маш төстэй үр дүн гарах буюу бизнесийн хөрөнгө оруулалт нь хэрэглээний зарцуулалтаасаа хамаагүй илүү байх болно гэж би таамаглаж байна. Олон орон Нийт гарцын тооцоог Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) тооцох үедээ хийдэг учраас бусад орны хувьд энэ тооцоог хийхэд хэцүү байх ёсгүй.

Эдийн засгийн тэргүүлэх үзүүлэлтүүд бидэнд юуг хэлээд байна вэ?

Хэрэглээний зарцуулалт, хөрөнгө оруулалтын салбар хоёр эдийн засгийн тэргүүлэх үзүүлэлт болох нь ямар чухал ач холбогдолтой болохыг одоо шалгаад үзье. Энд аль аль салбар нь эдийн засгийн байдалд нөлөөлдгийг бид харж байгаа боловч бизнесийн салбар илүү хүчтэй үүрэг гүйцэтгэдэг мэт харагдана.

Гол гол орны эдийн засгийн тэргүүлэх үзүүлэлтүүдийн индексийг харъя. Бага хурлын удирдах зөвлөл 9 орны ийм индексийг хэвлэжээ. Үр дүн нь гэвэл:

- Бага хурлын удирдах зөвлөлөөс нэгтгэсэн Германы есөн тэргүүлэх үзүүлэлтээс харахад, хоёр нь буюу хэрэглээний итгэлтэй байдлын индекс, үйлчилгээний хэрэглээний үнийн индекс хоёр нь хэрэглээний зарцуулалттай холбоотой байна. Бусад нь бараа материалын өөрчлөлт, үндсэн хөрөнгө шинээр худалдан авалт, шинэ барилгын захиалга гэх мэт үйлдвэрлэлийн эхний шатуудтай холбоотой үзүүлэлт байна.
- Их Британийн тэргүүлэх үзүүлэлтүүд нь экспортын хэмжээ, инженерчлэлийн салбар дахь шинэ захиалгууд, бараа материал, орон сууцны эхэлсэн барилга, мөнгөний нийлүүлэлт зэрэгтэй холбоотой байна. Хэрэглээний итгэлтэй байдлын индекс нь цорын ганц хэрэглээний үзүүлэлт байна.
- Японы тэргүүлэх үзүүлэлтүүдийн нэг нь ч хэрэглээтэй холбоогүй: үйлдвэрлэл дэх илүү цаг ажилласан байдал, бизнесийн нөхцөлийн судалгаа, хөдөлмөрийн бүтээмж, бодит үйл ажиллагааны ашиг, машин техник болон барилгын шинэ захиалгууд зэрэг үзүүлэлт байна.
- Мексикийн зургаан үзүүлэлтэд бараа материалын сар тутмын судалгаа, аж үйлдвэрийн барилга, хувьцааны үнэ, хүүгийн хувь, түүхий нефтийн зардал орж байна. Мексикт мөн жижиглэн худалдааны индекс давхацсан байна.
- АНУ-д Бага хурлын зөвлөлөөс хэрэглээний итгэлтэй байдлын индексийг онцлон тэмдэглэсэн байна, харин үйлдвэрлэгчдийн хэрэглээний бараа, материал авах шинэ захиалга, барилгын зөвшөөрөл, долоо хоногийн дундаж үйлдвэрлэлтийн цаг, хувьцааны үнэ, батлан хамгаалалтын бус капиталын бүтээгдэхүүний шинэ захиалга зэрэг бусад 9 үзүүлэлт нь эцсийн хэрэглээтэй зөвхөн маш холуур холбогдож байна.

Кейнсийн хууль ба эрэлтэд тулгуурласан эдийн засаг

Одоо анх тавьсан асуулт руугаа эргэж хандъя. Эдийн засгийн байдал ба өсөлтийн хөдөлгөгч хүч юу вэ?

Бид эдийн засгийн эрэлтийн тал (хэрэглээ), нийлүүлэлтийн тал (хөрөнгө оруулалт) гэсэн хоёр хүчин зүйл үйлчилж байдгийг харж байна. Богино хугацаанд, ялангуяа ухралтын байдлын үед, ихэнх эдийн засагчид эрэлтийн талын ач холбогдолыг онцлон авч үзэж, эдийн засгийг уналтын үед ч ажиллагаатай байлгахад хэрэглэгчид гол үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь Кейнсийн хууль буюу “эрэлт өөрийн нийлүүлэлтийг бий болгодог” гэдгээрээ алдартай бөгөөд Британийн аугаа эдийн засагч Жон Мэйнард Кейнсийн (1883-1946) нэрээр нэрлэжээ.

Сэйгийн хууль ба Нийлүүлэлтийн талын эдийн засаг

Эдийн засгийн нийлүүлэлтийн тал бол эдийн засаг бараг бүрэн ажил эрхлэлттэй байх үеийн урт хугацааны эдийн засгийн өсөлтийн гол тодорхойлогч хүчин зүйл байдаг. НГ-ын задаргаа, эдийн засгийн тэргүүлэх үзүүлэлтүүд ч энэ баталгааг дэмждэг.

Үүнийг тайлбарлахад нэг түүхэн жишээ тусалж болох юм. Яагаад 1990-ээд оны үед АНУ-ын баруун эргийнхний (Сан Франциско, Портленд, Сийэтл гэх мэт) эдийн засагт их өсөлт гарсан бэ? Тус бүс нутагт харилцаа холбоо, интернэтийн шинэ технологи, эд баялаг, хөгжил цэцэглэлтийн бүхэл бүтэн цоо шинэ түвшинг бий болгосон байна. Intel, Cisco Systems, Microsoft зэрэг нь айл өрхийн нэрс болжээ. Технологийн их өсөлт дөнгөж эхэлмэгц хэрэглэгчдийн автомашин, орон сууц, аялал жуулчлал, үнэт эдлэл, зугаа цэнгэлд зарцуулах зардал огцом өндөр түвшинд хүрснийг анзаараарай. Иймээс, хэрэглээ бол урт хугацаанд хөгжил цэцэглэлтийн үр дагавар болохоос шалтгаан биш байдгийг бид мэдэж авлаа. Энэ үзэгдэл нь Сэйгийн хууль буюу “нийлүүлэлт өөрийн эрэлтийг бий болгодог” гэдгээрээ алдартай бөгөөд Францын эдийн засагч Жан-Батист Сэйгийн (1767-1832), нэрээр нэрлэжээ. Сэйгийн хууль өнөөгийн эдийн засагт эргэлт болж байна (Kates 2003).

1990-ээд оны эдийн засгийн их өсөлтийн гол түлхүүр нь технологи, бүтээмж, бизнесийн үүсгэл санаачилга

байсан бөгөөд эдийн засагчдийн хэллэгээр эдийн засгийн “нийлүүлэлтийн тал” байв. Технологийн, бүтээмжийн, бизнесийн үүсгэл санаачилгын дэвшлүүд нь хэрэглэгчдэд зориулсан шинэ, илүү сайн бүтээгдэхүүнийг бага зардлаар бий болгож, эргээд хариуд нь шинэ зах зээл нээж, орлогыг нэмэгдүүлэн, хэрэглээнд ашиг тусаа өгч байна. Гэвч технологийн их өсөлт 2000 онд дуусах үед бизнесийн хөрөнгө оруулалт буурч, ажилгүйдэл өсөн, хэрэглээний зарцуулалт удааширсан байна. 2000-2003 оны ухралтын үед эдийн засгийг улам уналтад оруулалгүй барьж байсан зүйл бол хэрэглээний зарцуулалт байв (Кейнсийн хууль).

Бизнесийн мөчлөгийн туршид хөрөнгө оруулалтын зарцуулалт хэрэглээний зарцуулалтаас илүү их хувьсамтгай байх хандлагатай байна. Харин хэрэглэгчдийн жижиглэн худалдааны зарцуулалт эдийн засгийн өсөлт, бууралтын туршид харьцангуй тогтвортой байх хандлагатай байдаг. Иймээс, 2000-2003 оны дэлхий нийтийн эдийн засгийн ухралтын үед хэрэглээний зарцуулалт тогтвортой өсөлттэй байсанд гайхах зүйлгүй. Уг ухралт үндсэндээ бизнесийн ухралт байв. Ингээд 2003 онд эдийн засаг дахин сэргэхэд хүргэсэн зүйл бол эцсийн эцэст бизнесийн зарцуулалт байлаа.

Бизнесийн мөчлөгүүд, маркетингийн судалгаанаас үзэхэд үндсэндээ гүйцэтгэх захирлууд, бизнес анхлан эрхлэгчид, капиталистууд, бусад бизнесийн шийдвэр гаргагч нар нь эдийн засгийн гол идэвхжүүлэгчид байдгийг дахин дахин нотлон харуулдаг бөгөөд хэзээ капиталын хөрөнгө оруулалт хийж, эдийн засагт эргэлт гаргахыг тогтоож өгдөг. Засгийн газрын тэргүүнүүд эдийн засгийг сэргээхийн тулд хэрэглэгчдэд найдаж болохгүй. Тэд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгохоосоо илүү тэдгээрт хариу үйлдэл үзүүлэх байдлаар идэвхгүй байх хандлагатай байдаг.

Энгийн цагт, хуримтлал нэмэгдсэнээр капиталын хөрөнгө оруулалтын санг өргөтгөж, хүүгийн хувийг бууруулан, пүүс компаниуд шинэ үйлдвэрлэлийн процесс, шинэ технологи хэрэглэж, шинэ ажлын байр бий болгох боломж олгодог. Иймээс хуримтлал бол өөр хэлбэрт л байгаагаас биш, ердөө л хэрэглээтэй нэг адил зарцуулалтын хэлбэр бөгөөд зарим тохиолдолд илүү их капитал, хөрөнгө оруулалттай байх хэрэгцээг хангадаг утгаараа зарцуулалтын арай дээр хэлбэр юм.

СЭТГҮҮЛЧДЭД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

Эдийн засагт хэрэглээ ба хуримтлал, хөрөнгө оруулалтын хооронд зохих тэнцвэр барих нь маш чухал. Энэ хоёр хоёулаа баялаг, хөгжил цэцэглэлтийн үндэс суурийг тавихад зайлшгүй шаардлагатай. Гэхдээ хэрэглээний зарцуулалтыг хуримтлал ба хөрөнгө оруулалтын үнэ өртгөөр дэмжих ёсгүй.

Дараахь мэдэгдлүүдэд хянуур хандаарай

- “Хэрэглээний зарцуулалт эдийн засгийг хөтөлдөг.”
- “Хэрэглээний зарцуулалт эдийн засгийн гуравны хоёрыг төлөөлдөг.”
- “Хуримтлалыг нэмэгдүүлэх нь эдийн засагт тус нэмэр болохгүй.”

Урт хугацаанд эдийн засгийн байдлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол хуримтлал гэдгийг санагтун. Хэрэглээнээс илүү хуримтлал, хөрөнгө оруулалтыг дэмжсэн татварын хөнгөлөлт үзүүлэх нь заавал муу байх албагүй. Дараах мэдэгдлүүдээс зайлсхий:

- “Татварын хөнгөлөлтийг хуримтлуулах юм бол эдийн засгийг урамшуулахгүй. “ эсвэл
- “Хөрөнгөтэй баян хүмүүс дундаж ангийнхнаас бага зарцуулдаг учраас тэдэнд зориулж татварын хөнгөлөлт үзүүлэх нь үр нөлөөгүй.”

Хямралт эдийн засгийг сэргээхэд бизнесийн болон капиталын зарцуулалт амин чухал үүрэгтэй гэдгийг санагтун. Ихэвчлэн аж үйлдвэрийн үйлдвэрлэл, капитал бүрдүүлэлт, арилжааны болон орон сууцны зориулалттай барилга зэрэг хэлбэрээр сэргэлтийн анхны шинж тэмдэг хэрэглэгчдээс бус, бизнесээс төрдөг.

Уналтын үед хэрэглээний төлбөрөө багасгалаа гэж хэрэглэгчдийг бүү шүүмжил. Энэ бол тэдний ажил эрхлэлтэд болон эдийн засгийн байдалд үүссэн тодорхойгүй байдалд өгдөг төрөлхийн хариу үйлдэл юм.

Улсынхаа үндэсний орлогын статистик тоо баримтыг, түүний дотор Дотоодын Нийт Бүтээгдэхүүнийг (ДНБ), шинээр гарсан Нийт Гарц (НГ)-ын үзүүлэлтийг, мөн эдийн засгийн тэргүүлэх үзүүлэлтүүдээ сайн ойлгож, зүй зохистой ашиглаж буй эсэхээ шалгаарай. Ихэнх эдийн засгийн тэргүүлэх үзүүлэлтүүд хэрэглэгчидтэй биш, бизнес, хөрөнгө оруулалт хоёртой холбоотой байдгийг санаж яваарай.